

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-61-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл</p> <p align="center">(Шинэчлэгдэж байгаа) / 73 хуудас/ 2017 оны NZ amend.12</p>	<p align="center">НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ, ЗЭРЭГЛЭЛ</p> <p align="center">(Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 49 хуудас (үндсэн дүрэм- 49 хуудастай байсан)/1999 оны NZ amend.5</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг. Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>61.1 Зорилго (а) Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон баталгаажуулсан зөвшөөрөл олгоход тавих нөхцөл хангах шаардлага;</p> <p>(2) агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавих нөхцөл хангах шаардлага;</p> <p>(3) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийн тулд нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмших шаардлагатай этгээдийн дагаж мөрдөх нөхцөл;</p> <p>(4) нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон баталгаажуулсан зөвшөөрлийн эрх, хязгаарлалт.</p>	<p>61.1. Зорилго / Purpose (а) Энэхүү дүрмийн зорилго нь дараах зүйлүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино:</p> <p>1/ Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуульд заасны дагуу нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл олгох;</p> <p>2/ нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл авахад шаардагдах нөхцөл;</p> <p>3/ нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хүрээнд эдлэх эрх, үүргийн хязгаарлалт.</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p> <p>- 15 Apr 2016 Amend. 11-ээр орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан</p> <p>- “validation permit- баталгаажуулсан зөвшөөрөл”-ийг орхигдуулсныг нөхөж оруулсан</p>
<p>61.3 Нэр томъёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>	<p>61.3. Нөөц</p>	<p align="center">Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон</p>
<p>61.5 Нисгэгчийн үнэмлэх болон зэрэглэлийн шаардлага</p> <p>(а) Нисгэгчийн үнэмлэх-Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын агаарын хөлөг: Энэ зүйлийн (m), (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын</p>	<p>61.5. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлд тавигдах шаардлага</p> <p>(а) Нисгэгчийн үнэмлэх–Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад болон гадаад улсад нислэг үйлдэх: Энэ зүйлийн (з), (и)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсад бүртгэлтэй агаарын</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p>

бүртгэлтэй агаарын хөлгийн нисгэгч нь тохирох, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх үүрэгтэй ба тухайн үнэмлэхийг:

(1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл

(2) нисгэгчийн үнэмлэх олгох гадаадын эрх бүхий байгууллагаас олгосон ба 61.9-ийн дагуу баталгаажуулсан зөвшөөрөлтэй байна.

(b) Нисгэгчийн үнэмлэх-Монгол Улсын гадна үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын агаарын хөлөг: Энэ зүйлийн (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлтэй, Монгол Улсын гадна үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисгэгч нь тохирох, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх үүрэгтэй ба тухайн үнэмлэхийг:

(1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл

(2) тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа улсын нисгэгчийн үнэмлэх олгох эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн; эсхүл

(3) нисгэгчийн үнэмлэх олгох гадаадын эрх бүхий байгууллагаас олгосон ба 61.9-ийн дагуу баталгаажуулсан зөвшөөрөлтэй байна.

(c) Нисгэгчийн үнэмлэх - Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Гадаадын агаарын хөлөг: Энэ зүйлийн (m), (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаадын агаарын хөлгийн нисгэгч нь дараах тохирох, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх үүрэгтэй:

(1) агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийн үнэмлэх олгох эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн; эсхүл

(2) энэ Дүрмийн дагуу олгосон, Монгол Улсын нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийн үнэмлэх олгох эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрсөн.

хөлгөөр Монгол Улсад нислэг үйлдэх нисгэгч нь:

1/ энэ дүрмийн дагуу олгосон үнэмлэхтэй байх; эсхүл

2/ гадаадын эрх бүхий байгууллагаас олгогдсон үнэмлэхтэй бол тухайн үнэмлэх нь энэ дүрмийн 61.9-д заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн байна.

(б) Нисгэгчийн үнэмлэх–Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад нислэг үйлдэх: Энэ зүйлийн (з), (и)–д зааснаас бусад тохиолдолд, гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад нислэг үйлдэх нисгэгч нь:

1/ агаарын хөлгийн бүртгэлтэй улсын эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн үнэмлэхтэй байх; эсхүл

2/ энэ дүрмийн дагуу олгосон Монгол Улсын нисгэгчийн үнэмлэхтэй нисгэгч нь гадаадын агаарын хөлгөөр нислэг үйлдэх бол агаарын хөлгийг бүртгэгч улсын эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

-Amend.3-аар орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан

(d) Агаарын хөлгийн маягийн зэрэглэл: Энэ зүйлийн (m) - (q) хэсэг болон 61.57-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, эсхүл Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаадын агаарын хөлгийн нисгэгч нь тухайн агаарын хөлөгт, дараах хүчинтэй агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл
- (2) гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулсан зөвшөөрөлд заасан; эсхүл
- (3) агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийн үнэмлэх олгох эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан; эсхүл
- (4) Монгол Улсын агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа улсын нисгэгчийн үнэмлэх олгох эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан.

[\(e\) Нөөц](#)

[\(f\) Нөөц](#)

[\(g\) Нөөц](#)

[\(h\) Нөөц](#)

[\(i\) Нөөц](#)

(j) Хэрэглэлийн зэрэглэл: Энэ зүйлийн (m), (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол улсад IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, эсхүл гадаадын агаарын хөлгийн нисгэгч нь дараах тохирох, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл
- (2) гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулсан зөвшөөрөлд заасан, эсхүл
- (3) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа улсын нисгэгчийн

(в) Агаарын хөлгийн маягийн зэрэглэл: Энэ зүйлийн (з)-ээс (л) хүртэл болон энэ дүрмийн 61.51-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь Монгол Улсад, эсхүл гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад нислэг үйлдэх бол тухайн агаарын хөлгийн маягийн хүчин төгөлдөр зэрэглэлтэй байх бөгөөд тухайн зэрэглэл нь:

- 1/ энэ дүрмийн дагуу олгогдсон; эсхүл
- 2/ энэ дүрмийн 61.9-д заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан; эсхүл
- 3/ агаарын хөлгийг бүртгэгч улсын эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан; эсхүл
- 4/ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр гадаад улсад нислэг үйлдэх бол тухайн маягийн зэрэглэлийг энэ дүрмийн дагуу олгосон үнэмлэхэндээ тэмдэглэсэн байх, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан байх.

(г) Хэрэглэлийн зэрэглэл: Энэ зүйлийн (з), (и)-т зааснаас бусад тохиолдолд, Монгол улсад, эсхүл гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад хэрэглэлийн нислэгийн дүрэм (цаашид ХНД гэх)-ээр нислэг үйлдэх нисгэгч нь дараах шаардлагыг хангасан хүчин төгөлдөр хэрэглэлийн зэрэглэлтэй байна:

- 1/ энэ дүрмийн дагуу олгогдсон байх; эсхүл
- 2/ энэ дүрмийн 61.9-д заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан байх; эсхүл
- 3/ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, өөр улсад нислэг үйлдэх бол тухайн улсын эрх бүхий

<p>үнэмлэх олгох эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан, эсхүл;</p> <p>(4) хамааралгүй;</p> <p>(5) Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаадын бүртгэлтэй агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийн үнэмлэх олгох эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан.</p> <p>(к) Багш-нисгэгчийн зэрэглэл: Багш-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулсан зөвшөөрөлд заасан тохирох, хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.</p> <p>(л) Шалгагч-нисгэгчийн зэрэглэл: Шалгагч-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулсан зөвшөөрөлд заасан тохирох, хүчинтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.</p> <p>(м) Энэ Дүрмийн С Бүлгийн шаардлагыг хангаж байгаа сурагч-нисгэгчээс нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.</p> <p>(н) Бөмбөлөг, глайдер, ханг-глайдер, пара-глайдер, хэт хөнгөн болон спортын хөнгөн агаарын хөлөг, эсхүл моторт-глайдерын нисгэгчээс дараах тохиолдолд энэ Дүрмийн дагуу олгодог нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихийг шаардахгүй, хэрэв:</p> <p>(1) тухайн нисгэгч нь агаарын хөлгөөр хөлс, эсхүл шан урамшуулалттай нислэг үйлдээгүй бол;</p> <p>(2) тухайн нисгэгч нь ИНД-103, ИНД-104, эсхүл ИНД-106-гийн дагуу холбогдох нисгэгчийн болон үйл ажиллагааны шаардлагыг хангаж байгаа бол.</p> <p>(о) Хэрэв тухайн багш нь ижил төстэй конфигурацитай нисэх онгоцны хувьд, агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг бол, хүчинтэй А-Категорийн багш-</p>	<p>байгууллагаас олгогдсон, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан байх; эсхүл</p> <p>4/ гадаад улсын агаарын хөлөг Монгол Улсад нислэг үйлдэх бол агаарын хөлгийг бүртгэгч улсын эрх бүхий байгууллагаас олгогдсон, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан байх.</p> <p>(д) Багш нисгэгчийн зэрэглэл: Багш нисгэгч нь энэ дүрмийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр багш нисгэгчийн зэрэглэлтэй, эсхүл энэ дүрмийн 61.9-д заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан зэрэглэлтэй байна.</p> <p>(ж) Шалгах-нисгэгчийн зэрэглэл: Шалгах- нисгэгч нь энэ дүрмийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр шалгах-нисгэгчийн зэрэглэлтэй, эсхүл энэ дүрмийн 61.9-д заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан зэрэглэлтэй байна.</p> <p>(з) Энэ дүрмийн В бүлгийн шаардлагыг мөрдөж буй сурагч нисгэгчээс нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлтэй байхыг шаардахгүй.</p> <p>(и) Дараах нөхцөлд хийн бөмбөлөг, планер, дельтаплан, хэт хөнгөн агаарын хөлөг, хөдөлгүүрт планераар нислэг үйлдэх нисгэгчээс энэ дүрмийн дагуу олгох нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлтэй байхыг шаардахгүй.</p> <p>1/ урамшуулалттай буюу хөлсөөр нислэг үйлдээгүй бол;</p> <p>2/ ИНД-103, ИНД-104, эсхүл ИНД-106–ийн дагуу нисгэгчийн болон үйл ажиллагааны зохих шаардлагыг хангаж байгаа бол.</p> <p>(к) “А” ангиллын хүчин төгөлдөр зэрэглэлтэй багш нисгэгч нь нэг хөдөлгүүрт онгоцон дээр нисгэгчийн үүрэг гүйцэтгэх тохиолдолд, хийцийн хувьд ижил төстэй онгоцны маягийн</p>	<p>-“планер, дельтаплан” гэж оросоор нэрлэснийг “глайдер, ханг-глайдер, пара-глайдер, моторт-глайдер” гэх зэргээр криллээр галигласан</p> <p>-Amend.7-оор орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан</p>
---	---	--

<p>нисгэгчийн зэрэглэл эзэмшигчээс ганц хөдөлгүүртэй нисэх онгоцны нисгэгчийн үүрэг гүйцэтгэхэд агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.</p> <p><u>(p) ИНД 21-ийн Хавсралт E(1)-ийн дагуу түршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисгэгчээс агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.</u></p> <p>(q) Зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч зөвшөөрсөн бол, агаарын хөлгийн нисгэгчийг агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмших зорилгоор ур чадвараа шалгуулах, эсхүл дадлагын нислэг үйлдэх үедээ агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.</p>	<p>зэрэглэлтэй бол агаарын хөлгийн маягийн зэрэглэл шаардахгүй.</p> <p>(л) Багш нисгэгч зөвшөөрсөн бол агаарын хөлгийн маягийн зэрэглэл авах зорилгоор дадлага туршлагаа нэмэгдүүлэх, эсхүл дадлага туршлагаа шалгуулах нислэг үйлдэх нисгэгчээс агаарын хөлгийн маягийн зэрэглэл шаардахгүй.</p> <p><u>(м) Улсын агаарын хөлгийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч нь энэхүү дүрмийн 61.203-ын (а)-д заасан бичгийн шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд тухай үнэмлэхийг нь ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрч энэхүү дүрмийн дагуу коммерийн нисгэгчийн үнэмлэх олгож болно.</u></p>	
<p>61.7 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон <u>зөвшөөрөл</u></p> <p>(a) Дарга, Хууль болон энэ Дүрмийн холбогдох шаардлагын дагуу дараах төрлийн нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон <u>зөвшөөрлийг</u> олгоно:</p> <p>(1) <u>сонирхогч нисгэгчийн үнэмлэх:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нисэх онгоц; - Нисдэг тэрэг; <p>(2) хувийн нисгэгчийн үнэмлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Нисэх онгоц; - Нисдэг тэрэг; - <u>Глайдер;</u> <p>(3) коммерийн нисгэгчийн үнэмлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Нисэх онгоц; - Нисдэг тэрэг; - <u>Бөмбөлөг;</u> 	<p>61.7. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл</p> <p>(a) Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуульд заасны дагуу ИНЕГ-ын дарга энэ дүрмийн зохих шаардлагыг хангасан этгээдэд дараах нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл, <u>гэрчилгээг</u> олгоно.</p> <p>1/ хувийн нисгэгчийн үнэмлэх:</p> <ul style="list-style-type: none"> -онгоц -<u>планер</u> -нисдэг тэрэг <p>2/ коммерийн нисгэгчийн үнэмлэх:</p> <ul style="list-style-type: none"> -онгоц -<u>хийн бөмбөлөг</u> -<u>планер</u> -нисдэг тэрэг <p>3/ агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх:</p> <ul style="list-style-type: none"> -онгоц -нисдэг тэрэг 	<p>- Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.9-өөр орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан</p> <p>- сонирхогч нисгэгчийн үнэмлэх шинээр нэмэгдсэн</p>

- Глайдер:

(4) агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх:

- Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг;

(5) хэрэглэлийн зэрэглэл:

- Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг;

(6) А, В, С, D болон Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл:

- Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг;

(7) Шалгагч-нисгэгчийн зэрэглэл:

- Агаарын тээврийн;
- Ерөнхий зориулалтын нисэхийн;
- Хөдөө аж ахуйн (ХАА);

(8) баталгаажуулсан зөвшөөрөл

(9) 1-р Зэрэг ба 2-р Зэргийн ХАА-н зэрэглэл

- Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг;

(b) Энэ Дүрмийн холбогдох шаардлагын дагуу дараах зэрэглэлийг олгоно:

- (1) агаарын хөлгийн маягийн зэрэглэл;
- (2) аэробатик нислэгийн зэрэглэл;
- (3) глайдер чирэх зэрэглэл;
- (4) шүхэр хаях зэрэглэл;
- (5) [хүчингүй]

(6) нисгэгчийн химийн зэрэглэл;

(7) агаараас бордоо цацах зэрэглэл;

(8) агаараас шингэн цацах зэрэглэл;

4/ хэрэглэлийн зэрэглэл:

- онгоц
- нисдэг тэрэг

5/ “А”, “В”, “С”, “D”, “Е” ангиллын багш нисгэгчийн зэрэглэл:

- онгоц
- нисдэг тэрэг

6/ шалгах-нисгэгчийн зэрэглэл:

- агаарын тээвэрлэгч
- ерөнхий зориулалттай нисэх

7/ спортын нисгэгчийн үнэмлэх:

- онгоц

8/ хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ.

(б) Энэ дүрмийн зохих шаардлагыг хангасан аливаа этгээдэд дараах зэрэглэлийг олгоно:

- 1/ агаарын хөлгийн маягийн зэрэглэл;
- 2/ уран жолоодлогын нислэгийн зэрэглэл;
- 3/ планер чирэх зэрэглэл;
- 4/ шүхэр хаях зэрэглэл;
- 5/ 1 дүгээр ба 2 дугаар зэргийн хөдөө аж ахуйн зэрэглэл:
 - онгоц;
 - нисдэг тэрэг;
- 6/ химийн зэрэглэл.

- “Category-ангилал” - ыг “категори” гэж өөрчилсөн

- ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл нэмэгдсэн

- “уран жолоодлого” гэснийг “аэробатик” гэж өөрчилсөн

- ХАА-н зэрэглэлүүд нэмэгдсэн

- ИНЕГ-ын даргын Аюулгүй байдлын

<p>(9) агаараас мэрэгчийн хор цацах (VTA) зэрэглэл.</p>	<p>(в) 60-аас дээш настай нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй.</p> <p>(г) Хэрэв агаарын хөлгийн дарга нь 60-аас доош настай тохиолдолд 60-65 настай нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.</p>	<p>тушаалаар зохицуулагдана.</p>
<p>61.9 Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг баталгаажуулсан зөвшөөрөл</p> <p>(a) Баталгаажуулсан зөвшөөрөл авах этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй хувийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх; (2) энэ зүйлийн (a)(1)-д шаардсан гадаадын нисгэгчийн үнэмлэхтэй холбоотой тохирох, хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх; (3) хүсэлт гаргагч нь баталгаажуулсан зөвшөөрлийн эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлээр унших, ярих, ойлгох болон харилцах хангалттай чадвартай байх; (4) Даргын шаардаж болох бичгийн болон нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх. <p>(b) Баталгаажуулсан зөвшөөрөлд дараах шаардлагыг заасан байх ёстой:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн зөвшөөрлийн дуусах хугацаа нь олгосон өдрөөс хойш 6 сараас хэтрэхгүй байх ёстой байх; (2) тухайн эзэмшигчийн хэрэгжүүлж болох эрх нь гадаадын нисгэгчийн үнэмлэхээр олгосон эрхээс хэтрэхгүй байх ёстой байх. <p>(c) Баталгаажуулсан зөвшөөрөл нь дараахаас бусад</p>	<p>61.9. Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ</p> <p>(a) Дараах шаардлагыг хангасан этгээдэд хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ олгоно:</p> <ol style="list-style-type: none"> 1/Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон, наад зах нь хувийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; 2/энэ зүйлийн (a)1/-д заасны дагуу гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд шаардагдах эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх; 3/хүлээн зөвшөөрсөн гэрчилгээнийхээ эрхийг эдэлж, үүрэг хариуцлага хүлээх чадвартай байхын тулд англи, эсхүл монгол хэлээр унших, ярих, ойлгох, харилцах чадвартай байх; 4/хэрэв шаардлагатай бол, ИНЕГ-ын даргын шаардсан аливаа бичгийн болон нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх. <p>5/тухайн үнэмлэхийг олгосон гадаадын эрх бүхий байгууллагаас лавлагаа гаргуулсан байх:</p> <p>(б) Хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ нь дараах зүйлсийг тодорхойлно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ хүчинтэй хугацаа нь олгосон өдрөөс хойш 3 жилээс хэтрэхгүй байна; 2/ гэрчилгээг эзэмшигчийн эдлэх эрх нь тухайн гадаад улсын нисгэгчийн үнэмлэхээр эдэлдэг эрхээс дээгүүр байж болохгүй. <p>(в) Дараах зүйлсээс бусад тохиолдолд хүлээн</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p> <p>-“гэрчилгээ” гэснийг “зөвшөөрөл” гэж өөрчилсөн</p> <p>Баталгаажуулсан зөвшөөрлийн хугацаа “3 жилээс хэтрэхгүй” байсныг “6 сараас хэтрэхгүй” гэж өөрчилсөн</p>

<p>тохиолдолд, тухайн гэрчилгээнд заасан дуусах хугацаа хүртэл хүчинтэй хэвээр байна:</p> <p>(1) <u>Дарга түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон</u>; эсхүл</p> <p>(2) тухайн нисгэгчийн, гадаадын нисгэгчийн үнэмлэхний хугацаа дууссан, эсхүл тухайн олгосон Улс нь түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон.</p>	<p>зөвшөөрсөн гэрчилгээ нь олгосон хугацаа дуусах хүртэл хүчинтэй байна:</p> <p>1/ ИНЕГ-ын дарга <u>цуцласан, эсхүл түр түдгэлзүүлсэн</u> бол; эсхүл</p> <p>2/ тухайн гадаад улсын олгосон нисгэгчийн үнэмлэхний хугацаа дууссан, эсхүл цуцлагдсан, эсхүл түр түдгэлзүүлсэн бол;</p>	
<p>61.11 Хүсэлт гаргах болон <u>мэргэшлийн шаардлага</u></p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу Даргын олгох нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлтийг холбогдох САА маягтын дагуу гаргах ёстой.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу олгодог нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийн хүрээнд <u>үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлээр</u> унших, ярих, ойлгох болон харилцах хангалттай чадвартай байх үүрэгтэй.</p> <p>(c) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь холбогдох Бүлгийн нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихэд тавих нөхцөл хангах шаардлагыг бүрэн <u>хангасан байх үүрэгтэй</u>.</p>	<p>61.11. Өргөдөл гаргах</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу ИНЕГ-ын даргаас олгох нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл авах өргөдлийг ИНЕГ-061/01 маягтын дагуу гаргана.</p> <p>(b) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь нисгэгчийн эрхээ эдэлж, <u>үүрэг хариуцлага хүлээх чадвартай байхын тулд монгол хэлээр</u> унших, ярих, ойлгох, харилцах чадвартай байх ёстой.</p> <p>(в) Олон улсын нислэгт радио холбоо ашиглан нислэг үйлдэх нисгэгч нь Чикагогийн конвенцийн Хавсралт 1-д тогтоосон англи хэлний 4 дүгээр түвшний шаардлагыг хангасан байна. Энэхүү шаардлага нь 2011 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.</p> <p>(г) Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлтэй холбогдох бүлгүүдэд тавигдсан шаардлагыг <u>хангасан байна</u>.</p>	<p>- Үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэхийн тулд “монгол хэлээр” биш, “шаардлагатай хэлээр” харилцах гэж залруулсан</p> <p>АС 61.1-д заасан</p> <p>- үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь холбогдох Бүлгийн шаардлагыг бүрэн хангасан байх <u>үүрэгтэй</u> байхаар өөрчилсөн</p>
<p>61.13 Нөөц</p>	<p>61.13. Нөөц</p>	
<p>61.15 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хугацаа</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу олгодог нисгэгчийн үнэмлэхийг хугацаагүй олгоно.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн</p>	<p>61.15. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хугацаа</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу олгогдох нисгэгчийн үнэмлэх нь нисгэгчийн үнэмлэх эзэмших этгээдэд хугацаагүй олгогдоно.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, нисэхийн аюулгүй ажиллагааны ашиг сонирхолын үүднээс ИНЕГ-ын</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p>

<p>нөхцөлд нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийг түр хугацаагаар олгож болно.</p>	<p>дарга шаардлагатай гэж үзвэл, түр зуурын нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгож болно.</p> <p>(в) Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн, түүнчлэн тухайн төрлийн бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох үзлэгт орохоос татгалзсан этгээдийн үнэмлэх, зэрэглэл эзэмших эрхийг түр түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.</p>	<p>-Үндэслэлгүй нэмсэн</p>
<p>61.17 Бичгийн шалгалтад тавих урьдчилсан шаардлага болон үнэлгээ</p> <p><u>(a) Энэ Дүрэмд шаардсан бичгийн шалгалт өгөх хүсэлт гаргагч нь өөрийгөө нотлох дараах баримттай байх үүрэгтэй:</u></p> <p><u>(1) Монгол Улсын иргэний үнэмлэх; эсхүл</u> <u>(2) Монгол Улсын жолооны үнэмлэх; эсхүл</u> <u>(3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, фото зурагтай дүйцэх бусад бичиг баримт.</u></p> <p>(b) Энэ Дүрэмд шаардсан бичгийн шалгалт өгөх хүсэлт гаргагч нь бичгийн шалгалтдаа тэнцэхийн тулд боломжит үнэлгээний <u>70%-иас доошгүйг</u> авсан байх үүрэгтэй.</p> <p>(c) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл хэрэглэлийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн бичгийн шалгалтын кредит цуглуулах анхны шалгалт өгснөөс хойш 3 жилийн дотор тухайн нисгэгчийн үнэмлэх, эсхүл хэрэглэлийн зэрэглэлд шаардлагатай зөвшөөрөгдсөн бүх бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.</p> <p>(d) Энэ зүйлийн (c)-д заасан бичгийн шалгалтын кредит нь:</p> <p>(1) хувийн нисгэгчийн үнэмлэх, коммерийн нисгэгчийн үнэмлэх, сонирхогч нисгэгчийн үнэмлэх болон хэрэглэлийн зэрэглэлийн хувьд, <u>3 жилийн</u> хугацаанд хүчинтэй;</p>	<p>61.17. Бичгийн шалгалт – урьдчилсан нөхцөл, дүн</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу бичгийн шалгалт өгөхөөр өргөдөл гаргагч нь биеийн байцаалтаа авч ирнэ.</p> <p>(б) Энэ дүрмийн дагуу өргөдөл гаргагч нь бичгийн шалгалтандаа тэнцэхийн тулд 80-аас дээш хувийн кредит авсан байх шаардлагатай.</p> <p>(в) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл хэрэглэлийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь батлагдсан бүх бичгийн шалгалтыг өгнө. Тухайн нисгэгчийн үнэмлэх, эсхүл хэрэглэлийн зэрэглэл авахад шаардлагатай тэрхүү бичгийн шалгалтын кредит цуглуулахад тогтоосон дараах хугацаанд өгнө:</p> <p>1/ хувийн нисгэгчийн үнэмлэхний хувьд 1 жил; 2/ коммерийн нисгэгчийн үнэмлэх, агаарын тээвэрлэгчийн үнэмлэх болон хэрэглэлийн зэрэглэлийн хувьд 2 жил;</p> <p>(г) Энэ зүйлийн (в)-д заасан бичгийн шалгалтын кредит нь дараах хугацаанд хүчинтэй байна:</p> <p>1/ хувийн нисгэгчийн үнэмлэх, коммерийн нисгэгчийн үнэмлэх болон хэрэглэлийн зэрэглэлийн хувьд 3 жил;</p>	<p>- 10 April 2006 Amend.7-оор орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан</p> <p>- Бичгийн шалгалтад тэнцэх оноог 80% болгож дүрмийн шаардлагыг чангаруулсныг ICAO болон олон улсын жишигт нийцүүлэн 70% болгосон</p> <p>-ATPL, эсхүл зэрэглэл авахаар хүсэлт гаргагчийн бичгийн шалгалтын кредитийн хүчинтэй байх хугацаа 10 жил /нисэхийн хууль дүрмийн шалгалтын хувьд 5 жил/ байсныг 2 жил болгож өөрчилсөн нь бичгийн шалгалт авах давтамжийг нэмэгдүүлж, хүсэлт</p>

<p>(2) агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний хувьд, <u>10 жилийн</u> хугацаанд хүчинтэй (гэхдээ агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний нисэхийн хууль, дүрмийн шалгалтад тэнцсэн дүн нь <u>5 жилээс</u> хэтрэхгүй байх ёстой).</p> <p>(е) Бичгийн шалгалтад 3 сарын дотор 3 удаа хангалтгүй дүн үзүүлсэн этгээд нь сүүлчийн шалгалтыг амжилтгүй өгсөн өдрөөс хойш 3 сарын хугацаанд тухайн сэдвээр шалгалт өгөхгүй.</p>	<p>2/ агаарын тээвэрлэгчийн үнэмлэхний хувьд 3 жил (агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний хувьд нисэхийн хуулийн шалгалтын дүн 1 жилээс хэтрэхгүй).</p> <p>(д) Бичгийн шалгалтаа 3 сарын туршид 3 удаа хангалтгүй дүн үзүүлсэн бол сүүлчийн шалгалт авсан өдрөөс хойш тухайн шалгалтыг 3 сарын турш өгөх эрхгүй.</p>	<p>гаргагч болон шалгалт авч байгаа байгууллагад аль алинд нь хүндрэл учруулдаг байсныг өөрчилсөн.</p>
<p>61.19 Бичгийн шалгалтад хориглох зүйл</p> <p>(а) Энэ Дүрэмд шаардсан бичгийн шалгалтын үед аливаа этгээд нь дараах аль нэг үйлдлийг хийхгүй, эсхүл завдахгүй, эсхүл бусдыг ийм үйлдэл хийхэд хүргэхгүй байх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) бусад этгээдээс хуулах; (2) зөвшөөрөгдөөгүй мэдээллийн эх үүсвэр ашиглах; (3) шалгалт авч байгаа этгээдээс өөр бусад этгээдтэй аливаа арга замаар харьцах; (4) бусад этгээдийн өмнөөс шалгалт өгөх; (5) шалгалт авч байгаа этгээд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, бичгийн, эсхүл хэвлэмэл материалыг шалгалтын өрөөнөөс авч гарах; <p><u>(6) шалгалтын өрөөнд зөвшөөрөгдөөгүй материал авч орох;</u></p> <p>(7) тухайн шалгалтын үед түгээсэн цахим, бичгэн, эсхүл хэвлэмэл материалыг аливаа арга хэлбэрээр, эсхүл хэрэгсэл ашиглан хуулбарлах.</p> <p>(б) Хэрэв аливаа этгээд энэ зүйлийн (а)-д хориглосон үйлдлийг хийсэн, эсхүл бусад этгээдийг ийм үйлдэл хийхэд хүргэсэн байж болох бодит үндэслэл байна гэж Дарга үзвэл тухайн этгээдийн шалгалтын үр дүнг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно:</p> <ol style="list-style-type: none"> <u>(1) шалгаж дууссаны дараа, хэрэв байгаа бол, энэ зүйлийн (с)-гийн дагуу авч болох арга хэмжээг Дарга тогтоох хүртэл: эсхүл</u> <u>(2) хэрэв тухайн этгээд Даргад бичгээр хүсэлт</u> 	<p>61.19. Бичгийн шалгалт – хориглох зүйлс</p> <p>(а) Энэ дүрмийн дагуу авч буй бичгийн шалгалтын үед дараах зүйлсийг хориглоно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ бусдаас хуулах; эсхүл 2/ мэдээллийн ямар нэгэн эх үүсвэр ашиглах; эсхүл 3/ шалгалт авч буй хүнээс өөр хүнтэй ярих; эсхүл 4/ бусдын өмнөөс шалгалт өгөх; 5/ шалгалт авч буй хүний зөвшөөрөлгүйгээр шалгалтын материалыг гадагш авч гарах; <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасныг зөрчсөн этгээдийн талаар ИНЕГ-ын даргад үндэслэлтэй шалтгаан байвал магадлан шинжилсний дараа энэ зүйлийн (в)-д заасан үйлдлийг хийх хүртэл шалгалтын дүнг түр түдгэлзүүлж болно.</p>	<p>-Amend. 11-ээр орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан</p> <p>- Amend.7-оор орсон нэмэлтүүдийг нэмж тусгасан</p>

<p>гаргасан бол, 61.19(а)-г зөрчсөн байж болох үйлдлийг шалгасны дараа, хэрэв байгаа бол, энэ зүйлийн (с)-гийн дагуу авч болох арга хэмжээг Дарга тогтоох хүртэл.</p> <p>(с) Хэрэв тухайн этгээд нь энэ зүйлийн (а)-д хориглосон үйлдлийг хийсэн, эсхүл бусад этгээдийг ийм үйлдэл хийхэд хүргэсэн байж болох бодит үндэслэл байна гэж Дарга үзвэл, дараах арга хэмжээг авч болно:</p> <p>(1) тухайн этгээдийн шалгалтын үр дүнг хүчингүйд тооцох;</p> <p>(2) тухайн этгээдийг 12 сараас ихгүй тогтоосон хугацаанд шалгалтад оруулахгүй байх.</p> <p>(d) Дарга, энэ зүйлийн (b), эсхүл (с)-гийн дагуу арга хэмжээ авахын өмнө, энэ зүйлийн (а)-д заасан хориглосон үйлдлийг хийсэн байж болох мэдээллийн дэлгэрэнгүйг тухайн этгээдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>(e) Хэрэв Дарга, энэ зүйлийн (с)-гийн дагуу арга хэмжээ авахаар санал болгосон бол тухайн арга хэмжээг хуулийн хүрээнд авна.</p>	<p>(в) Энэ зүйлийн (а)-д заасныг зөрчсөн этгээдийн талаар ИНЕГ-ын дарга дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:</p> <p>1/ тухайн шалгалтанд тэнцээгүйд тооцох;</p> <p>2/ аливаа шалгалтанд орох эрхийг нь 12 сар хүртэл хугацаагаар хасах;</p> <p>(г) ИНЕГ-ын дарга энэ зүйлийн (б) эсхүл (в)-д заасан үйлдлийг хийхээс өмнө, тухайн этгээдэд энэ зүйлийн (а)-д заасан зүйлийг зөрчсөн тухай нь бичгээр дэлгэрэнгүй мэдэгдэнэ.</p> <p>(д) ИНЕГ-ын дарга энэ зүйлийн (в)-д заасан үйлдлийг хийхдээ хууль дүрмийн үндэслэлийг сайтар зааж, аливаа эргэлзээгүй гэдгийг бататгана.</p>	
<p>61.21 Нислэгийн шалгалт</p> <p>(а) Хүсэлт гаргагч нь нислэгийн шалгалт өгөхийн тулд дараах баримтыг бүрдүүлсэн байх үүрэгтэй:</p> <p>(1) 61.17(а)-д заасан, өөрийгөө тодорхойлох хангалттай нотлох баримт;</p> <p>(2) шалгуулах үнэмлэх, эсхүл зэрэглэлд шаардсан нислэгийн туршлагыг нотлох баримтыг агуулсан, тухайн өдрийн байдлаар бүрэн гүйцэд бөглөж, нэгтгэн баталгаажуулсан нисгэгчийн дэвтэр;</p> <p>(3) шалгуулах үнэмлэхэд хамаарах, хүчинтэй ЭМГ;</p> <p>(4) шалгуулах үнэмлэх, эсхүл зэрэглэлийн бичгийн шалгалтын кредит;</p> <p>(5) А, эсхүл В-Категорийн багш нисгэгчийн баталгаажуулсан, энэ зүйлийн (а)(4)-т шаардсан бичгийн шалгалтын кредитийн “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-г бичгийн шалгалт тус бүрээр гаргаж, дэлгэрэнгүй заагдсан дутуу мэдлэгийн сэдвийг нөхөж сурсан баримт,</p>	<p>61.21. Нислэгийн шалгалт</p> <p>(а) Өргөдөл гаргагч нь нислэгийн шалгалтанд орохдоо дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:</p> <p>1/ энэ дүрмийн 61.17(а)-д заасны дагуу биеийн байцаалт авч ирэх;</p> <p>2/ шалгуулах гэж буй үнэмлэх, зэрэглэлд шаардлагатай нислэгийн цагийн тэмдэглэл бүхий нислэгийн дэвтэр;</p> <p>3/ шалгуулах гэж буй үнэмлэхэнд шаардагдах эрүүл мэндийн гэрчилгээг авч ирэх;</p> <p>4/ шалгуулах гэж буй үнэмлэх, зэрэглэлд шаардагдах бичгийн шалгалтын кредит авч ирэх;</p> <p>5/ энэ зүйлийн (а)(4)-т заагдсан кредитний хувьд бичиг шалгалтын “хангалтгүй” гэж дүгнэгдсэн бүх сэдвүүдээр мэдлэгээ дээшлүүлсэн талаар “А”, эсхүл “В” ангиллын багш нисгэгчээр баталгаа гаргуулсан байх;</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p> <p>-“тухайн өдрийн байдлаар бүрэн гүйцэд бөглөж, нэгтгэн баталгаажуулсан” байх шаардлагыг нэмсэн</p> <p>-“хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан” гаргах, мөн дутуу мэдлэгийн сэдвийг нөхөж суралцсан байх шаардлагыг дэлгэрэнгүй заасан</p>

<p>(6) хувийн нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалтаас бусад тохиолдолд, нислэгийн шалгалтад ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг байх.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу шаардсан нислэгийн шалгалт нь, тухайн шалгалтыг амжилттай өгсөн өдрөөс хойш 3 сарын хугацаанд хүчинтэй байна.</p>	<p>6/ хувийн нисгэгчийн үнэмлэх олгох шалгалтаас бусад тохиолдолд шалгалтанд ашиглах агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй байх.</p> <p>(б) Энэ дүрмийн дагуу шаардагдах нислэгийн шалгалт нь нислэгийн шалгалт амжилттай өгсөн өдрөөс хойш 3 сарын хугацаанд хүчинтэй.</p>	
<p>61.23 Нөөц</p>	<p>61.23. Нөөц</p>	
<p>61.25 Нислэгийн <u>сургалт</u> болон шалгалтад тавих ерөнхий шаардлага</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу олгодог нисгэгчийн үнэмлэх, <u>эсхүл</u> зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) <u>шаардсан нислэгийн шалгалт авах зорилгод тохирох</u> агаарын хөлгийг бэлтгэх;</p> <p>(2) тухайн нислэгийн шалгалтын өмнө болон дараа <u>нислэгийн яриа хийхэд тохиромжтой, тусгаарлагдсан өрөөгөөр хангах.</u></p> <p>(b) Энэ Дүрэмд шаардсан нислэгийн шалгалт, <u>эсхүл хамтарсан нислэгийн зааварчилгааг</u> дараах байдлаар тоноглогсон агаарын хөлгөөр гүйцэтгэх ёстой:</p> <p>(1) бүрэн ажиллагаатай хосолсон <u>нислэгийн</u> удирдлагатай;</p> <p>(2) <u>тухайн нислэгийн үед шалгуулахаар төлөвлөсөн маневрт зайлшгүй шаардлагатай,</u> хоёр нисгэгчид харагдахуйц, хөндлөнгөөс харах харааны алдаагүй (parallax error) хэрэглэлтэй;</p> <p>(3) нисэх багийн гишүүдийн суудал нь хос мөрөвчит даруулга, эсхүл ганц хөндлөн мөрөвчит даруулгатай бүс;</p> <p>(4) зөвшөөрөгдсөн маягийн дотоод холбооны төхөөрөмжтэй.</p> <p>(c) Нисгэгч нь дараахаас бусад тохиолдолд, ил харааны нислэгийн цаг уурын нөхцөлийн (VMC) хэрэглэлийн нислэгийн туршлагаа хэрэглэлийн зэрэглэл авах, эсхүл туршлага хадгалах шаардлагатай хэрэглэлийн нислэгийн цагт оруулж тооцохгүй:</p>	<p>61.25. Нислэгийн <u>дадлага</u>, шалгалтанд тавигдах ерөнхий шаардлага</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах зүйлсийг бүрдүүлнэ:</p> <p>1/ <u>нислэгийн шалгалтыг гүйцэтгэх</u> агаарын хөлөг;</p> <p>2/ шалгалтын өмнө болон дараа <u>ярилцлага хийх байр.</u></p> <p>(б) Энэ дүрмийн дагуу шаардсан нислэгийн дадлага, шалгалтыг дараах зүйлсээр тоноглогдсон агаарын хөлгөөр гүйцэтгэнэ:</p> <p>1/ бүрэн ажиллагаатай хос удирдлага;</p> <p>2/ хоёр нисгэгчид харагдахуйц суурилагдсан, нислэгийн үед шаардагдах үйлдлүүдийг гүйцэтгэх чадвартай хэрэглэлүүд, тухайн хэрэглэлүүдийн заалтын зөрүү тогтоосон хязгаарлалтад байх;</p> <p>3/ нисэх багийн гишүүн бүрийн суудлын даруулга, эсхүл нэг дан хөндлөн суудлын даруулга бүс.</p> <p>4/ зөвшөөрөгдсөн төрлийн, хоорондын холбооны төхөөрөмж.</p> <p>(в) Ил харааны нислэгийн цаг агаарын нөхцөлд гүйцэтгэсэн хэрэглэлийн нислэгийн дадлагын цагийг дараах тохиолдолд хэрэглэлийн зэрэглэлийн ур чадвараа хадгалах, эсхүл шинээр олгоход шаардагдах дадлага авсанд тооцохгүй:</p>	<p>- Орчуулга, найруулга зассан</p> <p>- “training”-“дадлага” гэснийг сургалт гэж өөрчилсөн</p>

<p>(1) тухайн агаарын хөлөгт бүрэн ажиллагаатай хосолсон нислэгийн удирдлага суурилуулсан бол;</p> <p>(2) тухайн нисгэгчийн хэрэглэлийн нислэгийн дадлага авах зорилгоор ашиглаж байгаа дуураймал хэрэглэлийн нислэгийн тоноглол нь хүлээн зөвшөөрөхүйц бол;</p> <p>(3) аюулгүй байдлын нисгэгч (safety pilot) нь тухайн агаарын хөлөгт урд болон хоёр хажуу тал нь саадгүй харагддаг жолоодлоготой нисгэгчийн суудалд суусан ба дараах бүх шаардлагыг хангасан бол:</p> <p>(i) хүчинтэй нисгэгчийн үнэмлэхтэй байх;</p> <p>(ii) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй байх;</p> <p>(iii) хэрэв тухайн агаарын хөлөг шөнийн цагаар нислэг үйлдэж байгаа бол, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй байх.</p> <p>(d) Нисгэгч нь дараахаас бусад тохиолдолд, хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөлд (IMC) гүйцэтгэсэн хэрэглэлийн нислэгийн туршлагаа хэрэглэлийн зэрэглэл авах цагт, эсхүл хэрэглэлийн нислэгийн туршлага хадгалах шаардлагад оруулж тооцохгүй:</p> <p>(1) тухайн агаарын хөлөг нь IFR-ийн нислэгт зөвшөөрөгдсөн,</p> <p>(2) хоёр нисгэгч нисэх шаардлагатай агаарын хөлөгт <u>бүрэн ажиллагаатай хосолсон нислэгийн удирдлага суурилуулсан</u>;</p> <p>(3) тухайн нисгэгч нь:</p> <p>(i) тохирох <u>категорийн</u> агаарын хөлгийн хувьд, <u>хүчинтэй</u> хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч; эсхүл</p> <p>(ii) тохирох <u>категорийн</u> агаарын хөлгийн хувьд, <u>хүчинтэй</u> багш-нисгэгчийн зэрэглэл болон хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг хөлгийн даргын хяналтад хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа авч байгаа.</p>	<p>1/ тухайн агаарын хөлөгт бүрэн ажиллагаатай хос удирдлага суурилуулаагүй бол;</p> <p>2/ хэрэглэлийн нислэгийг дуураймал нөхцөлд гүйцэтгээгүй бол;</p> <p>3/ аюулгүй ажиллагаанд хяналт тавьж буй нисгэгч нь агаарын хөлгийн хоёр тал руу тод харагдах суудалд байхаас гадна дараах тохиолдолд;</p> <p>3.1 хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэхгүй бол;</p> <p>3.2 тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлгүй бол;</p> <p>3.3 шөнийн нислэг үйлдэх агаарын хөлгийн хувьд, хэрэглэлийн хүчин төгөлдөр зэрэглэлгүй бол.</p> <p>(г) Хэрэглэлийн нислэгийн цаг агаарын нөхцөлд гүйцэтгэсэн хэрэглэлийн нислэгийн дадлагын цагийг дараах тохиолдолд хэрэглэлийн зэрэглэлийн ур чадвараа хадгалах, эсхүл шинээр олгоход шаардагдах дадлага авсанд тооцохгүй:</p> <p>1/ тухайн агаарын хөлөг нь ХНД-ээр нислэг үйлдэхэд зөвшөөрөгдөөгүй бол;</p> <p>2/ хэрэв хоёр нисгэгч бүхээгт байлгах шаардлагатай агаарын хөлөгт, хос удирдлага суурилуулаагүй бол;</p> <p>3/ тухайн нисгэгч нь:</p> <p>3.1 тухайн агаарын хөлгийн <u>ангиллын</u> хувьд, хэрэглэлийн нислэгийн зэрэглэлгүй бол; эсхүл</p> <p>3.2 хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгч буй агаарын хөлгийн дарга болох багш нисгэгч нь тухайн агаарын хөлгийн ангиллын хувьд багш нисгэгч болон хэрэглэлийн нислэгийн зэрэглэлгүй бол.</p>	<p>- “Category-ангилал” гэснийг “категори” гэж өөрчилсөн</p>
<p>61.27 Шалгагч-нисгэгчийн үүрэг Шалгагч-нисгэгч нь дараах нөхцөлд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх ёстой:</p>	<p>61.27. Шалгах-нисгэгч (а) Шалгах-нисгэгч нь дараах тохиолдолд агаарын хөлгийн даргын үүргийг гүйцэтгэнэ:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(1) хэрэглэлийн зэрэглэл анх олгох нислэгийн шалгалтын үед;</p> <p>(2) тухайн шалгагч-нисгэгч, аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн үед.</p>	<p>1/ хэрэглэлийн нислэгийн зэрэглэл анхлан олгох шалгалтын нислэгт;</p> <p>2/ аюулгүй ажиллагааг хангах үүднээс, шалгах-нисгэгч өөрөө шаардлагатай гэж үзвэл.</p>	
<p>61.29 Нисгэгчийн дэвтэрт тавих ерөнхий шаардлага</p> <p>(a) Сурагч-нисгэгч болон энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь <u>дараах мэдээллийг нисгэгчийн дэвтэртээ тогтмол шинэчлэн нямбай хөтлөх үүрэгтэй:</u></p> <p>(1) тухайн нисгэгчийн нэр, агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн дэлгэрэнгүй мэдээлэл болон эзэмшиж байгаа гэрчилгээ, эрх болон зэрэглэл;</p> <p>(2) энэ зүйлийн (b)-д заасан мэдээллийг багтаасан дараах тэмдэглэл:</p> <p>(i) тухайн нисгэгч, агаарын хөлгийн нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэсэн нислэг бүрийн;</p> <p>(ii) нислэгийн <u>цаг тооцох</u>, эсхүл энэ Дүрэмд заасан нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хүчинтэй байх шаардлагыг хангах зорилгоор үйлдсэн дуураймал нислэг бүрийн,</p> <p>(3) дараах мэдээллийг багтаасан, нислэгийн шалгалт, нислэгийн дүгнэлт, ур чадварын шалгалт болон нисэх багийн ур чадварын шалгалтын тэмдэглэл:</p> <p>(i) тухайн нислэгийн зорилго;</p> <p>(ii) тухайн нислэг үйлдсэн огноо;</p> <p>(iii) нислэгийн шалгалт, нислэгийн дүгнэлт, ур чадварын шалгалт, эсхүл шалгалтын дуусах хугацаа;</p> <p>(iv) нислэгийн шалгалт, нислэгийн дүгнэлт, ур чадварын шалгалт, эсхүл шалгалт авсан этгээдийн нэр, үйлчлүүлэгчийн дугаар болон гарын үсэг.</p> <p>(b) Тухайн нисгэгчийн дэвтэрт нислэгийн болон хэрэглэлийн нислэгийн <u>дараах дэлгэрэнгүй мэдээллийг бичиж оруулдаг байх үүрэгтэй:</u></p> <p>(1) тухайн нислэг үйлдсэн огноо;</p> <p>(2) агаарын хөлгөөр үйлдсэн нислэгийн хувьд:</p> <p>(i) тухайн агаарын хөлгийн <u>категи</u>, маяг болон</p>	<p>61.29. <u>Нислэгийн</u> дэвтэрт тавигдах ерөнхий шаардлага</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч болон сурагч нисгэгч нь <u>дараах зүйлсийг багтаасан нислэгийн дэвтэртэй байна:</u></p> <p>1/ нисгэгчийн нэр, агаарын хөлгийн маягийн зэрэглэл, гэрчилгээ, зөвшөөрөл, зэрэглэлийн мэдээлэл.</p> <p>2/ дараах зүйлсийн бүртгэл (энэ зүйлийн (б)-д заасан зүйлсийн мэдээллийг мөн оруулна)</p> <p>2.1 агаарын хөлгийн нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэн үйлдсэн нислэгүүд;</p> <p>2.2 энэ дүрмийн дагуу нислэгийн <u>цаг цуглуулах</u> эсхүл ур чадвар хадгалалтанд тавигдах шаардлагыг биелүүлэхийн тулд дуураймал нөхцөлд гүйцэтгэсэн аливаа нислэгүүд.</p> <p>3/ дараах зүйлсийг багтаасан аливаа нислэгийн шалгалт, нислэгийн үзлэг, ур чадварын үзлэг болон нисэх багийн ур чадварын шалгалтын бүртгэл:</p> <p>3.1 нислэгийн зорилго;</p> <p>3.2 нислэгийн огноо;</p> <p>3.3 нислэгийн шалгалт, нислэгийн <u>үзлэг</u>, ур чадварын үзлэг, ур чадварын шалгалтын дуусах хугацаа;</p> <p>3.4 нислэгийн шалгалт, нислэгийн үзлэг, ур чадварын үзлэг, ур чадварын шалгалт авсан хүний нэр, гарын үсэг.</p> <p>(б) Нисгэгчийн нислэгийн дэвтэрт нислэгийн болон хэрэглэлийн нислэгийн <u>дараах мэдээллүүд зайлшгүй байна:</u></p> <p>1/ нислэгийн огноо;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“Pilot log book”- Нислэгийн дэвтэр гэснийг “Нисгэгчийн дэвтэр” гэж өөрчилсөн</p> <p>-“crediting time”- цаг цуглуулах гэснийг “цаг тооцох” гэж өөрчилсөн</p>

<p>бүртгэлийн дугаар;</p> <p>(ii) нислэгийн цаг;</p> <p>(iii) дуураймал болон бодит хэрэглэлийн нислэгийн цаг;</p> <p>(iv) хосолсон нислэгийн зааварчилгаа болон хөлгийн даргын дадлагыг багтаасан сургалтын төрөл;</p> <p>(v) хэрэв хамааралтай бол, тухайн багш-нисгэгч, эсхүл аюулгүй байдлын нисгэгчийн (safety pilot) нэр;</p> <p>(3) синтетик дадлагажуурт үйлдсэн нислэгийн хувьд:</p> <p>(i) тухайн синтетик нислэгийн дадлагажуурын дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(ii) хэрэглэлийн газрын цаг;</p> <p>(iii) бусад газрын цаг;</p> <p>(4) тухайн нисгэгчийн гүйцэтгэсэн дараах ажил үүрэг:</p> <p>(i) хөлгийн дарга (PIC);</p> <p>(ii) хяналтад байгаа хөлгийн дарга (PIC/US), гэхдээ зөвхөн ИНД-135.505-ын шаардлага хангахаар;</p> <p>(iii) хамтран нисгэгч;</p> <p>(iv) сурагч-нисгэгч;</p> <p>(5) нисэн гарсан газар, завсрын буулт болон нисэн хүрэх газрыг багтаасан тухайн нислэгийн зорилго;</p> <p>(6) тухайн нислэгийг өдөр, эсхүл шөнийн алинд нь үйлдсэн;</p> <p>(7) IFR нислэгийн хувьд хэрэглэлийн ойртолтын журмын дагуу үйлдсэн нислэгийн тоо болон төрөл;</p> <p>(8) сургалтын нислэгийн хувьд, тухайн дасгал сургуулилтын дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(9) глайдерын нислэгийн хувьд, тухайн нислэгт хөөргөсөн арга;</p> <p>(10) бөмбөлгийн нислэгийн хувьд, тухайн нислэгт ашигласан хийлэх арга, эсхүл төрөл.</p> <p>(c) Энэ зүйлийн (a)-д шаардсан нисгэгчийн дэвтэр нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p>	<p>2/ агаарын хөлөгт нислэг үйлдсэн бол:</p> <p>2.1 агаарын хөлгийн ангилал, маяг, бүртгэлийн дугаар;</p> <p>2.2 нислэгийн цаг;</p> <p>2.3 дуураймал нөхцөлд болон бодит хэрэглэлийн нислэгийн цаг;</p> <p>2.4 аливаа сургалт, нислэгийн дадлага болон агаарын хөлгийн даргаар ажиллах дадлага;</p> <p>2.5 шаардлагатай гэж үзвэл багш нисгэгч эсхүл аюулгүй ажиллагаанд хяналт тавьсан нисгэгчийн нэр;</p> <p>3/ дадлагажуурын нислэг бол:</p> <p>3.1 дадлагажуурын мэдээлэл;</p> <p>3.2 хэрэглэлийн газрын цаг;</p> <p>3.3 бусад газрын цаг;</p> <p>4/ дараах аль нэгээр нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн бол;</p> <p>4.1 агаарын хөлгийн дарга;</p> <p>4.2 зөвхөн ИНД-135-ын шаардлагыг хангахын тулд, агаарын хөлгийн даргын хяналтан дор агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;</p> <p>4.3 хамтран нисгэгч;</p> <p>4.4 сурагч нисгэгч.</p> <p>5/ нислэгийн зорилго болон хөөрсөн газар, аливаа засварын буулт үйлдсэн газар, очсон газрын мэдээлэл;</p> <p>6/ өдөр, шөнийн цагийн нислэгийн алинд үйлдсэн талаарх мэдээлэл;</p> <p>7/ ХНД-ээр ниссэн бол хэрэглэлийн ойртолтын журмын төрөл болон хэдэн удаа ойртолт үйлдсэн талаарх мэдээлэл;</p> <p>8/ хэрэв сургалтын нислэг бол энэ талаарх мэдээлэл;</p> <p>9/ хэрэв планерын нислэг бол хэрхэн чирч, хөөргөсөн талаарх мэдээлэл;</p> <p>10/ хэрэв хийн бөмбөлгийн нислэг бол хэрхэн хийлсэн</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
--	---	------------------------------------

- (1) зөвшөөрөгдсөн дэвтэрт дэлгэрэнгүй мэдээллийг арилдаггүй бэхээр бичсэн байх;
- (2) нислэг бүрийг дараах байдлаар бичиж тэмдэглэсэн байх:
- (i) тусад нь оруулах; эсхүл
 - (ii) компьютерт хөтөлдөг нислэгийн бүртгэлийг нисгэгчийн дэвтэрт байнга хадгалагдах хэлбэрээр бичиж оруулах; эсхүл
 - (iii) нэг өдөр үйлдсэн, дараалсан нислэгийн (series of flights) хувьд, хэрэв хөөрөлт, завсрын буулт болон хүрэх газрыг багтаасан нислэгийн зорилго ижил бол, дараалсан нислэгийг нэмж нислэгийн нийт цагийг нэг мөрөнд нэгтгэн оруулах;
- (3) оруулсан мэдээлэл нь үнэн зөв болохыг хуудас бүрийн төгсгөлд тухайн нисгэгч баталгаажуулсан байх;
- (4) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байнга хадгалах, хэрэв нисгэгчийн үнэмлэхийг хуулийн дагуу хүчингүй болгосон бол, хүчингүй болгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хадгалах ёстой.
- (d) Хэрэв компьютерт хөтөлсөн нислэгийн мэдээллийг энэ зүйлийн (c)(2)(ii)-ын дагуу нисгэгчийн дэвтэрт хавсаргасан бол тухайн нисгэгч нь нислэгийн жагсаалт, нислэгийн нийлбэр цагийн мэдээллийг энэ зүйлийн (b)-гийн дагуу ажил үүрэг тус бүрээр нисгэгчийн дэвтэртээ бичиж оруулах үүрэгтэй.
- (e) Нисгэгчийн дэвтэрт алдаатай оруулсан мэдээллийг зөвхөн дээрээс нь зураасаар дарж, зөв мэдээллийг араас нь, эсхүл шинэ мөрөнд нэмж оруулж болно.
- (f) Нисгэгчийн дэвтрийг Даргад ямар нэг шалтгаанаар хүргүүлэхийн өмнө тухайн нисгэгч нь дараах үүрэгтэй:
- (1) хуудас бүрд оруулсан мэдээллийг багана тус бүрээр нэгтгэх;
 - (2) тухайн зориулагдсан зайд, нийт ниссэн цагийг тэмдэглэх;
 - (3) хамгийн сүүлд оруулсан мэдээллийн төгсгөлд дээр оруулсан мэдээллүүд нь үнэн зөв болохыг гарын үсэг зурж баталгаажуулах.
- (g) Нисгэгч нь нисгэгчийн дэвтэрт оруулах мэдээллийг

- талаарх мэдээлэл.
- (в) Энэ зүйлийн (а)-д заасны дагуу шаардсан нислэгийн дэвтэр нь:
- 1/ батлагдсан загвартай байх бөгөөд түүнд хийх бичилтийг арилдаггүй балаар бичсэн байна;
 - 2/ нислэгийн бүртгэл бүрийг:
 - 2.1 тус тусад нь тэмдэглэсэн байна; эсхүл
 - 2.2 компьютерт оруулдаг бол нислэгийн мэдээллийг нислэгийн дэвтэрт тогтмол оруулдаг байх; эсхүл
 - 2.3 нэг өдөр хэд хэдэн нислэг үйлдсэн бол, тэрхүү нислэгийн зорилго болон хөөрсөн, завсрын буулт үйлдсэн, очсон газрууд ижил тохиолдолд нислэгийн мэдээллүүдийг тус тусд нь тэмдэглэж, нислэгийн цагийг нэгтгэн дүгнэсэн байна;
 - 3/ хуудас бүрийн доод хэсэгт тэмдэглэсэн бүх мэдээлэл үнэн, зөвийг баталж нисгэгч гарын үсэг зурна;
 - 4/ нисгэгч нь нислэгийн дэвтрээ сүүлийн нислэгийн цагийг тэмдэглэсэн өдрөөс хойш наад зах нь 12 сарын хугацаанд хадгална.
- (г) Хэрэв энэ зүйлийн (в)-гийн (2)-ын (2.2)-ын дагуу компьютерээс гаргасан нислэгийн мэдээллийг нислэгийн дэвтэрт оруулсан бол энэ зүйлийн (б)-д заасан мэдээллийг нислэгийн дэвтэртээ оруулан нислэгийн цагийн нийлбэрийг гараар тэмдэглэнэ.
- (д) Нислэгийн дэвтэрт бичсэн аливаа буруу зүйлсийг зөвхөн дээгүүр нь зураас татаж, хажууд нь, эсхүл шинэ мөрнөөс дахин тэмдэглэж өөрчилнө.
- (ж) Нисгэгч нислэгийн дэвтрээ ИНЕГ-ын даргад үзүүлэх тохиолдолд;
- 1/ нислэгийн цагийг хуудас бүр дээр нэгтгэн дүгнэсэн байна;
 - 2/ нислэг үйлдсэн нийт цаг зориулалтын зайд тэмдэглэсэн байна;
 - 3/ сүүлчийн тэмдэглэлийн дор тухайн тэмдэглэл нь

-series of flights-“хэд хэдэн нислэг” гэснийг “дараалсан нислэг” гэж өөрчилсөн

<p>тухайн нислэг дууссанаас хойш 7 хоногийн дотор олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд, тухайн нислэг дууссанаас хойш 14 хоногийн дотор, нислэгийн мэдээллийг заавал оруулах үүрэгтэй. Хэрэв нисгэгч нь нисгэгчийн дэвтрээ ихэвчлэн хадгалдаг үндсэн баазаас өөр газар үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол, үндсэн бааздаа буцаж ирснээс хойш 48 цагийн дотор мэдээллийг нисгэгчийн дэвтэртээ оруулдаг байх үүрэгтэй.</p>	<p>үнэн зөв болохыг батлан гарын үсэг зурсан байна.</p> <p>(з) Нислэгийг гүйцэтгэж дууссанаас хойш, нислэгийн мэдээллийг 7 хоногийн дотор, харин олон улсын нислэгийн мэдээллийг 14 хоногийн дотор нислэгийн дэвтэрт заавал тэмдэглэнэ. Хэрэв нисгэгч нь нислэгийн дэвтрээ хадгалдаг газраас өөр газар байгаа бол буцаж ирээд 48 цагийн дотор мэдээллийг нислэгийн дэвтэртээ оруулна.</p>	
<p>61.31 Нисгэгчийн дэвтэрт нислэгийн цаг тооцох</p> <p>(а) Хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хамтран нисгэгчтэй үйл ажиллагаа эрхлэхийг шаарддаг агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн бол, хамтран нисгэгчээр ниссэн цагийн 50%-иас ихгүйг агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх авахад шаардсан <u>НИЙТ НИСЛЭГИЙН ЦАГИЙН</u> туршлагад оруулж тооцох эрхтэй.</p> <p>(б) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хамтран нисгэгчтэй үйл ажиллагаа эрхлэхийг шаарддаг агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож, тухайн зорилгоор агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон хөлгийн даргын хяналтад хөлгийн даргын ажил үүргийг гүйцэтгэсэн бол, энэхүү нислэгийн цагийг хөлгийн даргын дадлагын нислэгийн цагийн туршлагад тооцох эрхтэй гэхдээ зөвхөн дараах тохиолдолд: хэрэв</p> <p>(1) хамтран нисгэгч нь түлшний тооцоог багтаасан санал болгосон нислэгийн төлөвлөгөө, ачааллын манифест үнэн зөвийг шалгах үүрэг хариуцлага хүлээдэг бол;</p> <p>(2) хамтран нисгэгч нь, үйл ажиллагааны заавар, эсхүл холбогдох бусад баримт бичигт агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн тогтоосон шалгалтын системийн дагуу, багийн гишүүд бүх холбогдох шалгалтыг дараах нислэгийн үе шатанд гүйцэтгэснийг бататгадаг бол:</p> <p>(i) хөөрөлтийн өмнө;</p> <p>(ii) хөөрөлтийн үед;</p> <p>(iii) нислэгт;</p>	<p>61.31. Нислэгийн дэвтэрт нислэгийн цагийг тооцох</p> <p>(а) Хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хамтран нисгэгч шаардлагатай агаарын хөлгөөр хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн бол хамтран нисгэгчээр ниссэн нийт цагийн 50%-иас дээшгүй цагийг нь агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх авахад шаардлагатай <u>НИСЛЭГИЙН ЦАГТ</u> тооцно.</p> <p>(б) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хамтран нисгэгч шаардлагатай агаарын хөлгөөр хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцохдоо, агаарын тээвэрлэгчийн зөвшөөрлөөр, агаарын хөлгийн даргын хяналтан дор агаарын хөлгийн даргын үүргийг гүйцэтгэж байгаа бол энэхүү нислэгийн цагийг дараах тохиолдолд агаарын хөлгийн даргаар ажиллах дадлагын нислэгийн цагт тооцно:</p> <p>1/ хамтран нисгэгч нь тухайн нислэгийн төлөвлөгөө, ачааллын хуудас, түлшний тооцооны үнэн, зөв эсэхийг шалгах үүрэг хүлээж байгаа;</p> <p>2/ хамтран нисгэгч нь нислэгийн дараах үе шатуудад багийн гишүүд тогтсон журмын дагуу үйл ажиллагаа эрхлэгчийн зүгээс гаргасан үйл ажиллагааны заавар эсхүл бусад холбогдох бичиг, баримтууд, шалгах хуудсыг ашиглаж буй эсэхийг хянаж байгаа:</p> <p>2.1 хөөрөлтийн өмнө;</p> <p>2.2 хөөрөлтийн үед;</p> <p>2.3 нислэгийн үед;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“total flight time- нислэгийн цаг” гэснийг “нийт нислэгийн цаг” гэж өөрчилсөн</p> <p>-Орчуулга, найруулга зассан</p>

(iv) буултын үед;

(v) онцгой нөхцөлд;

(3) хамтран нисгэгч нь тухайн нислэгийн турш хөлгийн даргын гүйцэтгэж болох боломжит бүх ажил үүргийг хамтран нисгэгчийн суудлаас гүйцэтгэдэг бол, гэхдээ 6 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх нислэгийн хувьд, хамтран нисгэгчийг тухайн нислэгийн турш бүх үүргийг гүйцэтгэхийг шаардахгүй;

(4) автопилот ашиглан гүйцэтгэж байгаа нислэгийн үйл ажиллагааны хувьд хамтран нисгэгч нь нислэгийн болон газрын систем ашиглахтай холбоотой бүх шийдвэрийг гаргадаг бол;

(5) хамтран нисгэгч нь цаг уурын нөхцөл, холбоо болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын журмаас үүссэн хүндрэлийг шийдвэрлэснийг бататгадаг бол;

(6) хамтран нисгэгчид хяналт тавихаар томилогдсон хөлгийн дарга хамтран нисгэгчийн дэвтэрт тухайн нислэгийн талаар зохих мэдээллийг оруулж баталгаажуулсан, эсхүл агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нислэгийн байнгын бүртгэлийг хөтөлдөг бол.

(c) Бодит, эсхүл дуураймал хэрэглэлийн нислэгийн нөхцөлд гадны хяналтын цэггүйгээр, зөвхөн хэрэглэл ашиглан агаарын хөлгийн удирдлагыг гардан гүйцэтгэж байгаа нисгэгч нь энэ аргаар цуглуулсан хэрэглэлийн нислэгийн цагийг дараах зорилгоор шаардсан нийт хэрэглэлийн нислэгийн цагийн туршлагад тооцох эрхтэй:

(1) дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх авах; эсхүл

(2) хэрэглэлийн зэрэглэл эзэмших; эсхүл

(3) эзэмшиж байгаа хэрэглэлийн зэрэглэлийн туршлага хадгалах шаардлагыг хангах.

(d) Хөлгийн дарга, бодит ИМС-д олон нисгэгчтэй агаарын хөлгийн нислэгийн удирдлагыг гардан гүйцэтгэж байгаа хамтран нисгэгчид хяналт тавьсан бол, тухайн цагийг хэрэглэлийн нислэгийн цагтаа оруулж тооцох эрхтэй.

(e) Багш-нисгэгч, бодит ИМС-д агаарын хөлгийн нислэгийн удирдлагыг гардан гүйцэтгэж байгаа нисгэгчид

2.4 буултын үед;

2.5 онцгой тохиолдлын үед;

3/ 6 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх нислэгээс бусад нислэгт хамтран нисгэгчийн суудлаас агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж байгаа;

4/ хамтран нисгэгч автомат системийн тусламжтайгаар нислэг үйлдэж буй үед нислэгийн болон газрын системийг ашиглахтай холбогдсон бүх шийдвэрийг гаргаж байгаа;

5/ хамтран нисгэгч нислэг бүрт цаг агаарын нөхцөл, холбоо, нислэгийн хөдөлгөөний удирдлагаас үүдэн гарсан аливаа асуудлыг шийдвэрлэж байгаа;

6/ агаарын хөлгийн дарга нь хамтран нисгэгчийн нислэгийн дэвтэрт нислэгийг гүйцэтгэсэн тухай холбогдох тэмдэглэл хийж байгаа, эсхүл агаарын тээвэрлэгч нь нислэгийн тухай бүртгэл тогтмол хөтөлж байгаа.

(в) Дараах тохиолдолд бодит болон дуураймал хэрэглэлийн нислэгийн нөхцөлд гаднах хяналтын цэггүйгээр, зөвхөн хэрэглэлийн хянах самбараар агаарын хөлгийг удирдаж байгаа нисгэгчийн нислэгийн цагийг хэрэглэлийн нислэгийн цагт тооцож, дараах зүйлийг авахад шаардагдах хэрэглэлийн нислэгийн цагт оруулна:

1/ нисгэгчийн үнэмлэхний эрэмбэ ахиулах; эсхүл

2/ хэрэглэлийн нислэгийн зэрэглэл авах; эсхүл

3/ эзэмшиж буй хэрэглэлийн нислэгийн зэрэглэлийг хадгалахад тавигдах дадлага туршлагын шаардлагыг хангах.

(г) Хэрэглэлийн нислэгийн цаг агаарын бодит нөхцөлд нэгээс илүү нисгэгчтэй агаарын хөлгийг удирдаж байгаа хамтран нисгэгчид хяналт тавьж буй агаарын хөлгийн даргын нислэгийн цагийг түүний хэрэглэлийн нислэгийн цагт тооцно.

(д) Хэрэглэлийн нислэгийн цаг агаарын бодит нөхцөлд агаарын хөлгийг удирдаж байгаа нисгэгчид хяналт тавьж

<p>хяналт тавьсан бол, тухайн цагийг хэрэглэлийн нислэгийн цагтаа оруулж тооцох эрхтэй.</p> <p>(f) Шалгагч-нисгэгч нь нислэгийн шалгалт авсан цагийг хөлгийн даргын нислэгийн цагтаа оруулж тооцох эрхтэй.</p> <p>(g) А, эсхүл В-Категорийн багш-нисгэгч нь коммерийн нисгэгчийн үнэмлэхний нутаг дамнасан (cross country) нислэгийн шалгалт авсан цагийг хөлгийн даргын нислэгийн цагт оруулж тооцох эрхтэй.</p> <p>(h) Нисгэгч нь хэрэглэлийн, <u>нутаг дамнасан</u>, эсхүл шөнийн нислэгийн, эсхүл эдгээрийн хосолсон цагийг дээд эрэмбийн үнэмлэх, <u>эсхүл</u> зэрэглэл авах туршлагын шаардлага хангах зорилгоор давхардуулан тооцохгүй.</p> <p>(i) Нисгэгч нь, хяналтад байгаа хөлгийн даргаар (PIC/US) бүртгэгдсэн нислэгийн цагийг агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний нислэгийн цагийн туршлагын шаардлагад оруулж тооцохгүй.</p> <p>(j) ИНД-<u>135.505(b)(3)</u>-ын зорилгоор, үйл ажиллагааны дадлага авч байгаа нисгэгчид хяналт тавихаар хөлгийн даргаар томилогдсон нисгэгч нь, хэрэв тухайн хяналтыг ИНД-<u>135.505(c)(2)</u>-ын дагуу ганц нисгэгчтэй агаарын хөлөг дээр гүйцэтгэсэн бол, тухайн хөлгийн даргын нислэгийн цагийг агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний нислэгийн цагийн туршлагын шаардлагад оруулж тооцохгүй.</p>	<p>буй багш нисгэгчийн нислэгийн цагийг түүний хэрэглэлийн нислэгийн цагт тооцно.</p> <p>(ж) Нислэгийн шалгалт авч буй шалгах-нисгэгчийн нислэгийн цагийг агаарын хөлгийн даргаар ниссэнд тооцно.</p> <p>(з) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг <u>алсын зайн</u> нислэгт шалгаж байгаа “А”, эсхүл “В” ангиллын багш нисгэгчийн нислэгийн цагийг агаарын хөлгийн даргаар ниссэнд тооцно.</p> <p>(и) Нисгэгчийн гүйцэтгэсэн аливаа <u>алсын зайн</u>, эсхүл шөнийн хэрэглэлийн нислэгийн цагийг, эсхүл дээрхийг зэрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийг, дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн нислэгийн цагт шаардагдах нислэгийн дадлага, туршлагын цагт тооцож болохгүй.</p> <p>(к) Агаарын хөлгийн даргын хяналтан дор агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийг Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхэнд шаардагдах нислэгийн дадлага туршлагын цагт тооцож болохгүй.</p> <p>(л) Хэрэв ИНД-<u>135-ын</u> дагуу нэг нисгэгчтэй агаарын хөлөг дээр нислэгийн дадлага хийж байгаа нисгэгчид ИНД-<u>135-д</u> заасны дагуу хяналт тавихаар агаарын хөлгийн даргаар томилогдсон нисгэгчийн нислэгийн цагийг агаарын тээвэрлэгчийн үнэмлэхэнд шаардагдах нислэгийн дадлагын цагт тооцож болохгүй.</p>	<p>-cross country-алсын зайн” гэснийг “нутаг дамнасан” гэж өөрчилсөн</p>
<p>61.33 <u>Нисгэгчийн дэвтэрт</u> дадлагажуурын цаг тооцох</p> <p>(a) Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмших, эсхүл зэрэглэл сунгах хүсэлт гаргагч нь, зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчийн хяналтад, зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуурт үйлдсэн цагийг нислэгийн цагт тооцох эрхтэй гэхдээ зөвхөн хэрэв багш-нисгэгч тухайн цагийг нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан бол,.</p> <p>(b) Хэрэв энэ зүйлийн (a)-д заасан цаг нь хэрэглэлийн цаг бол, үүнийг хэрэглэлийн газрын цагт оруулж тооцох</p>	<p>61.33. <u>Нислэгийн дэвтэрт</u> дадлагажуурын цагийг тооцох</p> <p>(a) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл авах, эсхүл зэрэглэл ахиулахаар өргөдөл гаргагч нь багш нисгэгчийн хяналтан дор, нислэгийн зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр нислэг үйлдсэн тохиолдолд тухайн нислэгийн цагийг тухайн багш нисгэгчээр баталгаажуулан нислэгийн дэвтэртээ тэмдэглүүлсэн байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан цаг хэрэглэлийн нислэгийн цаг бол түүнийг газарт үйлдсэн, хэрэглэлийн нислэгийн</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>үүрэгтэй.</p>	<p>цаг гэж тэмдэглүүлнэ.</p>	
<p>61.35 Эрүүл мэндийн шаардлага</p> <p>(a) Дараахаас бусад тохиолдолд сонирхогч нисгэгчийн үнэмлэхнээс бусад нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь тухайн үнэмлэхний эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн этгээд нь:</p> <p>(i) хувийн нисгэгчийн үнэмлэхний хувьд ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх;</p> <p>(ii) коммерийн нисгэгчийн үнэмлэх болон агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний хувьд ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 1-р ангиллын ЭМГ эзэмшдэг байх;</p> <p>(iii) ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх; эсхүл</p> <p>(2) Хэрэв тухайн этгээдэд Дарга гадаадын нисгэгчийн үнэмлэхийг нь үндэслэн 61.153 (b)-гийн дагуу хувийн нисгэгчийн үнэмлэх олгосон бол, тухайн этгээд нь:</p> <p>(i) хувийн нисгэгчийн үнэмлэх олгохдоо Даргын үндэслэл болгосон гадаадын нисгэгчийн үнэмлэхэд дагалдах ЭМГ эзэмшдэг ба тухайн ЭМГ-ний хугацаа дуусаагүй байх;</p> <p>(ii) тухайн ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх,</p> <p><u>(b) Дараахаас бусад тохиолдолд сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь тухайн үнэмлэхний эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</u></p> <p><u>(1) В болон С ангиллын жолооны үнэмлэхэд хамаарах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгосон дараах эрүүл мэндийн тодорхойлолттой байх:</u></p> <p><u>(i) өмнөх 5 жилийн дотор олгосон; эсхүл</u></p> <p><u>(ii) хэрэв тухайн этгээд нь 40, эсхүл түүнээс дээш настай бол, өмнөх 24 сарын дотор олгосон;</u></p>	<p>61.35.Эрүүл мэндэд тавигдах ерөнхий шаардлага</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах тохиолдлоос бусад үед нисгэгчийн үнэмлэхэнд олгогдсон эрх эдлэхгүй:</p> <p>1/ тухайн нисгэгч нь:</p> <p>1.1 хувийн нисгэгчийн үнэмлэхний хувьд, ИНД-67-гийн дагуу олгогдсон 2 дугаар ангиллын эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээ эзэмшиж байгаа бол;</p> <p>1.2 коммерийн нисгэгчийн үнэмлэх болон агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний хувьд, ИНД-67-гийн дагуу олгогдсон 1 дүгээр ангиллын эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээ эзэмшиж байгаа бол;</p> <p>1.3 эрүүл мэндийн гэрчилгээний нөхцөл, хязгаарлалт, нэмэлт нөхцлийг мөрдөж байгаа бол;</p> <p>2/ энэ дүрмийн 61.35 (б)-д заасны дагуу гадаадын нисгэгчийн үнэмлэхийг үндэслэн ИНЕГ–ын даргаас хувийн нисгэгчийн үнэмлэх олгосон бол тухайн үнэмлэх эзэмшигч нь:</p> <p>2.1 тухайн гадаадын хувийн нисгэгчийн үнэмлэх авахад олгогдсон эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна;</p> <p>2.2 эрүүл мэндийн гэрчилгээний нөхцөл, хязгаарлалт, нэмэлт нөхцлийг дагаж мөрдөнө;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Энэ зүйлд 2002 оны Amend.6, 2008 оны</p> <p>-“Доод тал нь 2-р ангиллын болон түүнээс дээш ангиллын гэрчилгээтэй байж болох” шаардлагыг “зөвхөн 2-р ангиллын гэрчилгээтэй байх” болгож өөрчилсөн</p> <p>-Amend.9-өөр нэмэлт, өөрчлөлт оруулсан</p>

<p><u>(2) эрүүл мэндийн тодорхойлолтын бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх.</u></p> <p>(с) Дараахаас бусад тохиолдолд гадаадын нисгэгчийн үнэмлэхний баталгаажуулсан <u>зөвшөөрөл</u> эзэмшдэг этгээд нь тухайн зөвшөөрлийн эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) баталгаажуулсан зөвшөөрөл олгосон гадаадын нисгэгчийн үнэмлэхэд хамаарах хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;</p> <p>(2) тухайн ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх.</p> <p><u>(d) Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгодог эрүүл мэндийн тодорхойлолтыг энэ зүйлийн (b), эсхүл 61.355(a)(2)-ын дагуу эзэмших шаардлагатай этгээд нь эрүүл мэндийн тодорхойлолт олгосноос хойш 7 хоногийн дотор хуулбарыг Даргад хүргүүлэх үүрэгтэй.</u></p>	<p>(б) Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрч олгосон <u>гэрчилгээг</u> эзэмшигч нь дараах зүйлээс бусад тохиолдолд гэрчилгээний эрхийг эдлэхгүй:</p> <p>1/ хүлээн зөвшөөрч олгосон гэрчилгээг олгохдоо харгалзан үзсэн гадаадын нисгэгчийн үнэмлэхтэй хэрэглэгдэж байгаа хүчин төгөлдөр эрүүл мэндийн гэрчилгээтэй байх;</p> <p>2/ эрүүл мэндийн гэрчилгээний нөхцөл, хязгаарлалт, зөвшөөрлийг дагаж мөрдөж байгаа бол.</p> <p><u>(в) Үнэмлэх эзэмшигч нь өөрийн эрүүл мэндийн байдал муудсан тохиолдолд үнэмлэхээр олгогдох эрхээ эдлэхээс татгалзах ёстой.</u></p>	
<p>61.37 Нислэгийн <u>туршлага хадгалах</u></p> <p>(a) Агаарын тээврийн нисгэгч: Тухайн нислэгийн өмнө үргэлжилсэн 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь, <u>тухайн хөлгийн даргыг агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй байхыг шаарддаг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй:</u></p> <p>(1) тухайн этгээд нь:</p> <p>(i) <u>3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буулт</u> үйлдсэн байх (агаарын хөлгийн даргаар, эсхүл ижил маягийн зөвшөөрөгдсөн нислэгийн синтетик дадлагажуур дээр); эсхүл</p> <p>(ii) зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгчид ур чадварын хадгалалтаа ижил маягийн агаарын хөлгөөр амжилттай шалгуулсан байх; эсхүл</p> <p>(iii) зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид,</p>	<p>61.37. Нислэгийн <u>дадлага, туршлага</u> / Recent flight experience</p> <p>(a) Агаарын тээвэрлэгчийн нисгэгч: Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэхийн тулд өмнөх 90 хоногт нь дараах шаардлагын аль нэгийг хангасан байх шаардлагатай:</p> <p>1/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөг, эсхүл зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр агаарын хөлгийн даргаар <u>3-аас доошгүй хөөрөлт, буулт</u> үйлдсэн байх; эсхүл</p> <p>2/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөгт ур чадварын шалгалтаа шалгах-нисгэгчид амжилттай шалгуулсан байх; эсхүл</p> <p>3/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөг дээр өдрийн цагаар</p>	<p>-Энэ зүйлд 2008 оны Amend.9-өөр нэмэлт, өөрчлөлт оруулсан</p> <p>-“flight experience- дадлага туршлага” гэснийг “туршлага хадгалах” гэж өөрчилсөн</p>

хөөрөлт болон буултын маневр хийх ур чадвараа ижил маягийн агаарын хөлгөөр, өдрийн цагаар амжилттай шалгуулсан байх; гэхдээ

(2) нэг буулт нь автопилотын автоматаар буулт үйлдэх горим ашигласан хяналттай буулт байж болно.

(b) Коммерийн нисгэгч (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг), хувийн нисгэгч, сонирхогч нисгэгч - өдрийн нислэг: Тухайн нислэгийн өмнө үргэлжилсэн 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь өдрийн цагаар, арилжааны нислэгийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй, мөн коммерийн нисгэгчийн, эсхүл хувийн нисгэгчийн, эсхүл сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь өдрийн цагаар, зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй:

(1) өдрийн цагаар 3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буулт үйлдсэн байх (агаарын хөлгийн даргаар, эсхүл ижил маягийн зөвшөөрөгдсөн нислэгийн синтетик дадлагажуур дээр); эсхүл

(2) зохих ёсоор мэргэшсэн А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчид хөөрөлт, буултын маневр хийх ур чадвараа ижил маягийн агаарын хөлгөөр, өдрийн цагаар амжилттай шалгуулсан байх; эсхүл

(3) энэ Дүрмийн дагуу тохирох нисгэгчийн үнэмлэх олгоход тавих ур чадвараа ижил маягийн агаарын хөлөгт амжилттай шалгуулсан байх.

(c) **Коммерийн нисгэгч, хувийн нисгэгч - шөнийн нислэг:** Тухайн нислэгийн өмнө үргэлжилсэн 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь шөнийн цагаар, арилжааны нислэгийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй, мөн коммерийн

хөөрөх болон буух ур чадвараа багш нисгэгчид шалгуулсан байх; гэхдээ

4/ энэ зүйлийн 1/ болон 3/-т шаардсан буултын нэг буултыг нь автомат жолоодлого ашиглан гүйцэтгэсэн байж болно.

(б) Коммерийн нисгэгч, хувийн нисгэгч, спортын нисгэгчийн үнэмлэх эзэмшигч – өдрийн цагийн нислэг: коммерийн нисгэгч, хувийн нисгэгч, спортын нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь агаарт өдрийн цагаар агаарын хөлгийн даргаар зорчигч тээвэрлэн нислэг үйлдэхийн тулд өмнөх 90 хоногт нь дараах шаардлагын аль нэгийг хангасан байх шаардлагатай (энэ зүйлийн (з) хамаарахгүй). Үүнд:

1/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөг, эсхүл зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр өдрийн цагаар агаарын хөлгийн даргаар 3-с доошгүй хөөрөлт, буулт үйлдсэн байх; эсхүл

2/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөгт өдрийн цагаар ур чадвараа “А” эсхүл “В” ангиллын багш нисгэгчид амжилттай шалгуулсан байх; эсхүл

3/ энэ дүрмийн дагуу тухайн нисгэгчийн үнэмлэх авахдаа тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөгт ур чадвараа амжилттай шалгуулсан байх.

(в) коммерийн нисгэгч, хувийн нисгэгч– шөнийн цагийн нислэг: коммерийн нисгэгч, хувийн нисгэгч нь шөнийн цагаар агаарын хөлгийн даргаар зорчигч тээвэрлэн нислэг үйлдэхийн тулд өмнөх 90 хоногт нь дараах аль нэгийг гүйцэтгэсэн байх шаардлагатай (энэ зүйлийн (з) хамаарахгүй).

-....нислэг үйлдэхийн “өмнөх 90” хоног нь тасраагүй байх гэсэн шаардлагыг орхигдуулсныг “өмнөх үргэлжилсэн” гэж өөрчилсөн

нисгэгчийн, эсхүл хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь шөнийн цагаар, зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй:

(1) шөнийн цагаар 3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буулт үйлдсэн байх (агаарын хөлгийн даргаар, эсхүл ижил маягийн зөвшөөрөгдсөн нислэгийн синтетик дадлагажуур дээр); эсхүл

(2) зохих ёсоор мэргэшсэн А, эсхүл В -Категорийн багш-нисгэгчид хөөрөлт болон буултын маневр хийх үр чадвараа ижил маягийн агаарын хөлгөөр, шөнийн цагаар амжилттай шалгуулсан байх.

(са) Коммерийн нисгэгч (бөмбөлөг): Тухайн нислэгийн өмнө үргэлжилсэн 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх (бөмбөлөг) эзэмшигч нь зорчигч тээвэрлэж байгаа бөмбөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй:

(1) 150 м-ээс (500 ft) доошгүй өндөрт гарах бүрдээ, хөлгийн даргаар 3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буултыг өдрийн цагаар гүйцэтгэсэн байх; эсхүл

(2) ижил маягийн бөмбөлгөөр хөөрөлтийн болон буултын маневр хийх үр чадвараа Даргын хүлээн зөвшөөрөхүйц зохих ёсоор мэргэшсэн этгээдэд амжилттай шалгуулсан байх; эсхүл

(3) энэ Дүрмийн дагуу коммерийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих үр чадвараа ижил маягийн бөмбөлөг дээр амжилттай шалгуулсан байх.

(d) Энэ зүйлийн (a)(1), (b)(1), эсхүл (c)(1)-ийн шаардлага хангахын тулд, нисдэг тэрэгний нисгэгч нь шаардлагатай хөөрөлт болон буултын хооронд шилжих хайрцгаар нисэх үүрэгтэй.

(e) [Хүчингүй]

(f) Энэ зүйлийн (b)(1)-д заасан шаардлагыг хангахын тулд, глайдерын нисгэгч нь хөөргөлтийн тохирох аргаар 3 удаа

1/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөг, эсхүл зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр шөнийн цагаар агаарын хөлгийн даргаар 3-с доошгүй хөөрөлт, буулт үйлдсэн байх; эсхүл

2/ нислэг үйлдэх тухайн агаарын хөлөг болон түүнтэй ижил маягийн агаарын хөлөгт шөнийн цагаар үр чадвараа “А” эсхүл “В” ангиллын багш нисгэгчид амжилттай шалгуулсан байх;

(г) Энэ зүйлийн (a)1/, (б)1/, эсхүл (в)1/-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд нисдэг тэрэгний нисгэгч хөөрөлт ба буултын хооронд хайрцаг нислэг хийх шаардлагатай.

(д) Энэ зүйлийн (б)1/-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд хийн бөмбөлөгийн нисгэгч хөөрөлт ба буултын хооронд газраас 150 м (500 фут) хөөрөх шаардлагатай.

(ж) Энэ зүйлийн (б)1/-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд планерын нисгэгч 3 удаа чирүүлэн хөөрөх шаардлагатай.

(з) Энэ зүйлийн (б)1/, (в)1/-д заасан шаардлагыг

-Коммерийн нисгэгч (бөмбөлөг)- шаардлага Amend.9-өөр нэмэгдсэн

-Орчуулга, найруулга зассан
- “планерын нисгэгч” гэснийг “глайдерын нисгэгч” гэж өөрчлөгдсөн.

-2 жил гэсэн нь 5 жил эсхүл түүнээс дээш өөрчлөгдсөн.
-“хууль, тогтоомжийн шалгалт” гэснийг “нисэхийн хууль,

<p>гүйцэтгэсэн байх үүрэгтэй.</p> <p>(g) Энэ зүйлийн (b)(1) болон (c)(1)-д шаардсан <u>3 хөөрөлт болон 3 буулт</u> үйлдэх шаардлагыг хангах зорилгоор <u>хүчинтэй А-Категорийн</u> багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь өдөр, эсхүл шөнийн алинд ч үйлдсэн хөөрөлт болон буултыг тооцож болно.</p> <p><u>(h) Багш-нисгэгч нь нислэгийн зааварчилгаа өгөхийн өмнө өдрийн, эсхүл шөнийн нислэгийн туршлага хадгалах шаардлагын аль хамааралтайг нь хангасан байх үүрэгтэй.</u></p> <p>(i) Хэрэв энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь 61.39-ийн шаардлагыг <u>5 жил, эсхүл түүнээс дээш хугацаанд</u> хангаагүй бол, дараахаас бусад тохиолдолд, тухайн нисгэгчийн үнэмлэхний эрхийг дахин хэрэгжүүлэхгүй:</p> <p>(1) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь <u>нисэхийн хууль, дүрмийн зөвшөөрөгдсөн шалгалтыг</u> амжилттай өгсөн ба тухайн үнэмлэхэд холбогдох, хүчинтэй байх шаардлагыг хангасан байх (хэрэв тухайн эзэмшигч нь өөр категорийн агаарын хөлгийн хувьд хүчинтэй нисгэгчийн үнэмлэхтэй бөгөөд 61.39(a)-д заасан категорид тавих шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд); эсхүл</p> <p>(2) агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний хувьд, тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь ИНД-121, 125, эсхүл 135-д шаардсан, аль хамааралтай, тохирох үйл ажиллагааны ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн байх.</p>	<p>биелүүлэхийн тулд <u>А ангиллын</u> багш нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь <u>3 хөөрөлт, буултыг</u> өдрийн эсхүл шөнийн цагаар үйлдэж болно.</p> <p>(и) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн 61.39-ын шаардлагыг <u>2 жил</u> биелүүлээгүй бол дахин тухайн нисгэгчийн үнэмлэхний эрх эдлэхийн тулд:</p> <p>1/ тухайн нисгэгчийн үнэмлэхний ур чадварын хадгалалтанд тавигдах шаардлагыг биелүүлэхээс гадна <u>хууль, ТОГТООМЖИЙН ШАЛГАЛТ</u>ыг амжилттай өгсөн байх (хэрэв үнэмлэх эзэмшигч өөр ангиллын агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэхтэй байгаад энэ дүрмийн 61.39 (a)-д заасан ангилалд тавигдах шаардлагыг биелүүлсэн бол хамаарахгүй); эсхүл</p> <p>2/ агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний хувьд нисгэгчийн үнэмлэх эзэмшигч ИНД-119, ИНД-121-д заасны дагуу ур чадварын шалгалтаа амжилттай өгсөн байх.</p>	<p>дүрмийн зөвшөөрөгдсөн шалгалт” гэж өөрчлөгдсөн.</p>
<p>61.39 Хоёр жилийн <u>нислэгийн дүгнэлт</u></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, Хууль болон энэ Дүрмийн дагуу Даргын олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах шаардлагыг хангаагүй бол <u>нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалт өгснөөс хойш</u> 24 сараас урт хугацаагаар тухайн нисгэгчийн үнэмлэхний эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) өмнөх 24 сарын дотор энэ зүйлийн (c)-гийн</p>	<p>61.39. Хоёр жил тутмын <u>нислэгийн үзлэг</u> / Biennial flight review</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд 24 сарын дотор дараах нислэгийн шалгалт өгөөгүй бол үнэмлэхээр олгогдсон эрх эдлэхгүй:</p> <p>1/ энэ зүйлийн (b)-д заасны дагуу өмнөх 24 сард 2 жил</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Энэ зүйлд 2011 оны Amend.10-аар нэмэлт, өөрчлөлт оруулсан</p>

<p>дагуу хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг амжилттай хийлгэсэн байх; эсхүл</p> <p>(2) <u>глайдерын</u> нисгэгчийн үнэмлэхний хувьд, өмнөх 24 сарын дотор глайдерын байгууллагаар хоёр жилийн нислэгийн үнэлгээг амжилттай хийлгэсэн байх.</p> <p>(b) Хууль болон энэ Дүрмийн дагуу Даргын олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигчээс энэ зүйлийн (а)-д заасан хоёр жилийн нислэгийн дүгнэлт хийлгэхийг шаардахгүй хэрэв үнэмлэх эзэмшигч нь:</p> <p>(1) тухайн нисгэгчийн үнэмлэхэд хамааралтай, ИНД-<u>115</u>, эсхүл 119, болон 121, <u>125</u>, эсхүл 135-д заасан нисэх багийн ур чадварын шалгалтын шаардлагыг хангасан бол; эсхүл</p> <p>(2) 61.707-д заасан ХАА-н зэргийн хүчинтэй байх шаардлагыг хангасан бол; эсхүл</p> <p>(3) хүчинтэй А, В, эсхүл С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг бол.</p> <p>(c) Хоёр жилийн <u>нислэгийн дүгнэлт</u> нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <p>(1) зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчээр хийгдсэн байх;</p> <p>(2) тухайн эзэмшигчийн хэрэгжүүлэхийг хүсэж байгаа нисгэгчийн үнэмлэхний эрхтэй хамааралтай маневр болон журмын гүйцэтгэлийг шалгах нислэгийн зааварчилгаанаас бүрдсэн байх;</p> <p>(3) <u>Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу байх.</u></p> <p>(d) Хоёр жилийн <u>нислэгийн дүгнэлт</u> хийж байгаа багш-нисгэгч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) нислэгийн дүгнэлтийг амжилттай хийсний дараа тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдээллийг багтаасан зохих тэмдэглэлийг нэн даруй оруулах:</p> <p>(i) тухайн нислэгийн дүгнэлтэд хамаарах нисгэгчийн үнэмлэхний төрөл;</p> <p>(ii) тухайн нислэгийн дүгнэлтийг хийсэн огноо;</p>	<p>тутмын нислэгийн үзлэг амжилттай өгсөн байх; эсхүл</p> <p>2/ <u>планерын</u> нисгэгчийн үнэмлэхний хувьд өмнөх 24 сард планерийн нисэх клубээс зохион байгуулдаг 2 жил тутмын нислэгийн үзлэгийг амжилттай өгсөн байх.</p> <p>(б) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах тохиолдлуудад энэ зүйлийн (а)-д заасан 2 жил тутмын нислэгийн үзлэгийг өгөх шаардлагагүй:</p> <p>1/ ИНД-119 болон ИНД121, ИНД-135–ын дагуу шаардсан нисэх багийн ур чадварын шалгалтыг хангаж байвал; эсхүл</p> <p>2/ энэ дүрмийн 61.707–ын дагуу шаардсан хөдөө аж ахуйн зэрэглэлийн ур чадварын хадгалалтанд тавигдах шаардлагыг хангасан бол; эсхүл</p> <p>3/ хүчин төгөлдөр “А”, “В”, эсхүл “С” ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй бол.</p> <p>(в) Хоёр жил тутмын <u>нислэгийн үзлэг</u> нь:</p> <p>1/ зохих түвшинд бэлтгэгдсэн багш нисгэгчээр хийгдэнэ;</p> <p>2/ нисгэгчийн үнэмлэхний эрхийн дагуу үнэмлэх эзэмшигч хийхийг хүссэн тухайн маневр, үйл ажиллагааны журмын дасгал, зааварчилгаанаас бүрдэнэ;</p> <p>3/ <u>стандартын дагуу ИНЕГ–ын даргад хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.</u></p> <p>(г) Хоёр жил тутмын <u>нислэгийн үзлэгийг</u> авч байгаа багш нисгэгч нь:</p> <p>1/ нислэгийн үзлэг амжилттай явагдсаны дараа нислэгийн дэвтэрт нь дараах мэдээллүүдийг тэмдэглэнэ:</p> <p>1.1 нислэгийн үзлэгт хамаарагдах нисгэгчийн үнэмлэхний төрөл;</p> <p>1.2 нислэгийн үзлэгт хийсэн огноо;</p> <p>1.3 нислэгийн үзлэгийн хүчинтэй хугацаа нь дуусах огноо;</p>	<p>-“планерын нисгэгч” гэснийг “глайдерын нисгэгч” гэж</p> <p>- “нислэгийн үзлэг” гэснийг “нислэгийн үнэлгээ” гэж</p>
---	--	---

<p>(iii) тухайн нислэгийн дүгнэлтийн хүчинтэй байх хугацаа дуусах огноо;</p> <p>(iv) тухайн нислэгийн дүгнэлтийг хийсэн багш-нисгэгчийн нэр, категори болон ИНЕГ-ын үйлчлүүлэгчийн дугаар,</p> <p>(2) ИНЕГ-ын Хоёр жилийн нислэгийн дүгнэлтийн гүйцэд бөглөсөн маягтын хуулбарыг Дарга болон тухайн нисгэгчид хүргүүлэх.</p> <p>(е) Энэ зүйлийн (а)-д шаардсан хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг шаардсан хугацаанаас өмнө <u>60 хоногийн дотор</u> амжилттай хийлгэсэн нисгэгчийг хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг шаардсан хугацаанд хийлгэсэнд тооцно.</p>	<p>1.4 багш нисгэгчийн нэр, ангилал.</p> <p>2/ ИНЕГ-аас гаргасан 2 жилийн нислэгийн үзлэгийн маягтыг бөглөж хуулбарыг нь ИНЕГ-ын дарга болон нисгэгчид өгнө.</p> <p>(д) Энэ зүйлийн (а)-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд 2 жилийн нислэгийн үзлэгийг өгөх өдрөөс <u>60 хоногийн өмнө</u> 2 жилийн нислэгийн үзлэгээ шалгуулсан бол цаг хугацаанд нь шалгуулсанд тооцно.</p>	<p>-“60 хоногийн өмнө” гэснийг “60 хоногийн дотор” гэж</p>
<p>61.41 Доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэх, <u>эсхүл</u> зэрэглэл ашиглах</p> <p>(а) Энэ Дүрмийн дагуу олгосон агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх, <u>эсхүл</u> коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 1-р ангиллын ЭМГ эзэмшдэггүй, гэхдээ ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллын ЭМГ эзэмшдэг бол, хувийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлж болно, хэрэв тухайн нисгэгч нь хувийн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг хангаж байгаа бол.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн нисгэгчийн үнэмлэхний хувьд, 61.207, эсхүл 61.257-гийн хүчинтэй байх шаардлагыг хангаагүй боловч доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг хангаж байгаа бол, доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлж болно.</p>	<p>61.41. Доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл ашиглах / Use of lower pilot licence or rating</p> <p>(а) Энэ дүрмийн дагуу агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч ИНД-67-гийн дагуу олгогдсон 1 дүгээр ангиллын эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээ байхгүй боловч 2 дугаар ангиллын эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй бөгөөд хувийн нисгэгчийн үнэмлэхний ур чадварын хадгалалтанд тавигдах шаардлагыг хангаж байгаа бол хувийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг эдэлж болно.</p> <p>(б) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн 61.35, 61.257-д заасны дагуу нисгэгчийн үнэмлэхний хүчин төгөлдөр байх шаардлагыг хангаагүй боловч доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэхний хүчин төгөлдөр байх шаардлагыг хангаж байгаа бол доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэхэнд олгогдох эрхийг эдлэж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Энэ зүйлд 2008 оны Amend.9-өөр нэмэлт, өөрчлөлт оруулсан</p>
<p><u>61.43 Мэргэжлийн үр чадварын шалгалт</u></p> <p>(а) Хэрэв Даргад энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь хэрэгжүүлж байгаа тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхээ ур чадваргүй хэлбэрээр гүйцэтгэсэн гэж үзэх бодит үндэслэл байгаа бол, Дарга бичгээр мэдэгдэл өгч, тухайн эзэмшигчийг шалгалт, эсхүл нислэгийн шалгалт өгөхийг шаардаж болно.</p>	<p>61.43. <u>Ур чадвар хадгалалтын шалгалт</u> / Examination for proficiency</p> <p>(а) ИНЕГ-ын даргад энэ дүрмийн дагуу олгогдсон нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч тухайн үнэмлэх, зэрэглэлийн дагуу олгогдсон эрхээ эдлэх чадваргүй гэсэн үндэслэлтэй шалтаг байвал албан бичгээр мэдэгдэл өгөн үнэмлэх, зэрэглэл эзэмшигчийг дахин шалгалт өгөхийг шаардаж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Энэ зүйлд 2002 оны</p>

<p>(b) Энэ зүйлийн (а)-ийн дагуу Даргын шаардаж болох шалгалт, эсхүл нислэгийн шалгалт нь тухайн эзэмшигч хэрэгжүүлж байгаа нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хувьд, энэ Дүрмийн дагуу шаарддаг шалгалт, эсхүл нислэгийн шалгалтын хэсэг, эсхүл хэсгүүдээс бүрдэнэ.</p> <p>(c) Энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) энэ зүйлийн (а)-ийн дагуу Даргын шаардаж болох шалгалт, эсхүл нислэгийн шалгалтыг өгөх;</p> <p>(2) шалгалт, эсхүл нислэгийн шалгалтыг Даргын тогтоосон хугацаанд өгсөн байх.</p>	<p>(б) Энэ зүйлийн (а)-д заасны дагуу ИНЕГ–ын даргын дахин өгөхийг шаардсан шалгалт нь энэ дүрмийн дагуу тухайн нисгэгчийн үнэмлэх авахад шаардагдах аливаа шалгалт, эсхүл тухайн шалгалтын тодорхой хэсэг байж болно.</p> <p>(в) Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч нь дараах шаардлагыг заавал биелүүлнэ:</p> <p>1/ энэ зүйлийн (а)-д заасны дагуу ИНЕГ–ын даргын шаардсан шалгалтыг өгөх;</p> <p>2/ ИНЕГ–ын даргын тодорхойлсон, шалгалт өгөх хугацаанд шалгалтыг өгөх.</p>	<p>Amend.6-аар өөрчлөлт оруулсан</p>
<p>В Бүлэг. Агаарын хөлгийн маягийн зэрэглэл</p>	<p>Б БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН МАЯГИЙН ЗЭРЭГЛЭЛ / AIRCRAFT TYPE RATINGS</p>	
<p>61.51 Зорилго Энэ Бүлэг нь агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавих зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>61.51. Зорилго / Purpose (а) Энэхүү бүлгээр агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавигдах шаардлагыг тодорхойлно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>61.53 Нөхцөл хангах шаардлага</p> <p>(а) Агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) тохирох <u>категорийн</u> агаарын хөлгийн хувьд, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;</p> <p>(2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц шилжих сургалтын зааварчилгааны нислэгийн туршлагатай байх;</p> <p>(3) турбинт-хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд, турбинт-хөдөлгүүрийн онолын суурь мэдлэгийн зөвшөөрөгдсөн шалгалтыг амжилттай өгсөн байх;</p> <p>(4) тухайн зэрэглэл шаардсан агаарын хөлгийн маягийн техникийн хангалттай мэдлэгээ зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид амжилттай шалгуулсан байх;</p> <p>(5) тухайн зэрэглэл шаардсан агаарын хөлгийн маягт хамаарах хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн маневрыг өндөр түвшинд гүйцэтгэх ур чадвараа маягийн ур чадварын шалгалтаар зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид шалгуулсан байх;</p>	<p>61.53. Тавигдах шаардлага / Eligibility requirements</p> <p>(а) Агаарын хөлгийн маягийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ агаарын хөлгийн <u>зохих ангиллын</u> хувьд нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;</p> <p>2/ ИНЕГ–ын дарга хүлээн зөвшөөрөхүйц зөөлтийн нислэгийн дадлага авсан байх;</p> <p>3/ турбинт хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд турбинт хөдөлгүүрийн талаар мэдлэгтэй байх;</p> <p>4/тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлд шаардлагатай техникийн мэдлэгээ багш нисгэгчид шалгуулсан байх;</p> <p>5/тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлд шаардлагатай нислэгийн хэвийн, хэвийн бус үйл ажиллагаа болон онцгой тохиолдлын жолоодлогыг өндөр түвшинд гүйцэтгэх ур чадвараа багш нисгэгчид шалгуулсан байх;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(6) хэрэв МСТOW нь 5700 кг-аас дээш жинтэй агаарын хөлгийн маягийн зэрэглэл, эсхүл олон хөдөлгүүртэй нисдэг тэрэгний маягийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргаж байгаа бол:</p> <p>(i) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл шаардсан агаарын хөлөг дээр зөвшөөрөгдсөн техникийн сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх;</p> <p>(ii) тухайн агаарын хөлгийн системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журам болон тухайн агаарын хөлгийн үзүүлэлт, жин, төвлөрөлтийг багтаасан зөвшөөрөгдсөн бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх;</p> <p>(7) хэрэв МСТOW нь 5700 кг-аас хэтрэхгүй жинтэй, ганц хөдөлгүүртэй нисдэг тэрэгний маягийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргаж байгаа бол, тухайн нисдэг тэрэгний системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журам, нисдэг тэрэгний үзүүлэлт, жин, төвлөрөлтийг багтаасан, зөвшөөрөгдсөн бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх. Гэхдээ МСТOW нь 1500 кг-аас ихгүй жинтэй нисдэг тэрэгний хувьд, зөвхөн аман шалгалт өгнө.</p>	<p>6/ хэрэв <u>хөөрөлтийн дээд жин</u> нь 5700 кг-аас дээш жинтэй агаарын хөлөг, эсхүл олон хөдөлгүүрт нисдэг тэрэгний хувьд бол:</p> <p>6.1 тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлд шаардагдах техникийн сургалтанд хамрагдсан байх;</p> <p>6.2 тухайн агаарын хөлгийн системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын болон агаарын хөлгийн үзүүлэлт, жин, төвлөрөлтийг багтаасан бичгийн шалгалт өгсөн байх;</p> <p>7/ хэрэв <u>хөөрөлтийн дээд жин</u> нь 5700 кг-аас доош жинтэй нэг хөдөлгүүрт нисдэг тэрэгний хувьд бол тухайн агаарын хөлгийн системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын болон агаарын хөлгийн үзүүлэлт, жин, төвлөрөлтийг багтаасан бичгийн шалгалт өгсөн байх.</p> <p>Хэрэв хөөрөлтийн дээд жин нь 1500 кг-аас доош жинтэй нисдэг тэрэг бол зөвхөн аман шалгалт өгсөн байж болно.</p>	<p>- “хөөрөлтийн дээд жин” гэснийг “МСТOW” гэж өөрчлөгдсөн</p>
<p>61.55 Зэрэглэл олгох</p> <p>(a) Хэрэв тухайн нисгэгч, 61.53-ын нөхцөл хангах шаардлагыг хангасан бол, маягийн ур чадварын шалгалтыг хариуцсан багш-нисгэгч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн нисгэгчийн дэвтэрт агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр тэмдэглэх;</p> <p>(2) тухайн маягийн зэрэглэлийн сургалтын бүртгэлийн бүрэн гүйцэд хувийг Даргад хүргүүлэх.</p> <p>(b) Энэ дүрмийн 61.53-ыг үл харгалзан, Дарга дараах тохиолдолд энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэхэд агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэл хийж болно, хэрэв:</p> <p>(1) нисгэгчийн үнэмлэх эзэмшигчид ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас агаарын хөлгийн</p>	<p>61.55.Зэрэглэл олгох / Issue</p> <p>(a) Хэрэв нисгэгч нь энэ дүрмийн 61.53-т заасны дагуу тавигдах шаардлагыг хангасан бол ур чадварыг тодорхойлох багш нисгэгч нь:</p> <p>1/ ИНЕГ–ын даргаас хүлээн зөвшөөрсөн маягтын дагуу нислэгийн дэвтэрт агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг тэмдэглэнэ.</p> <p>2/ агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн сургалт, дадлагын бүрэн гүйцэт тайлан бүртгэлийн хуулбарыг ИНЕГ–ын даргад өгнө.</p> <p>(б) Энэ дүрмийн 61.53-т заасныг үл харгалзан, энэ дүрмийн дагуу олгогдсон нисгэгчийн үнэмлэхэнд ИНЕГ–ын дарга дараах тохиолдлуудад агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгож болно:</p> <p>1/ Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч</p>	

маягийн зэрэглэл олгосон ба тухайн үнэмлэх эзэмшигч нь агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр эзэмшдэг болохоо нотлох баримтаар харуулсан бол; эсхүл

(2) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь ИНД 21-ийн Хавсралт E(1)-ийн дагуу тухайн маягийн агаарын хөлгийн туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр зөвшөөрөгдсөн ба Даргын хүлээн зөвшөөрөхүйц агаарын хөлгөөр шалгах нислэг хийх туршлагатай болсон бол; эсхүл

(3) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч ба тодорхой нисэх онгоцны конфигурацийн хувьд, 61.5(о)-д заасан агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэх онгоцоор нислэгийн туршлагатай болсон бол; эсхүл

(4) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь 61.57-гийн дагуу тухайн маягийн агаарын хөлөгт нисгэгч, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээр зөвшөөрөгдсөн бөгөөд Даргын хүлээн зөвшөөрөхүйц агаарын хөлөг дээр нислэгийн туршлагатай болсон бол.

(с) Нисгэгч нь Даргад хүсэлт гарган, зохих төлбөрийн баримт хүргүүлж (нисгэгчийн дэвтэрт мэдээлэл оруулахаас гадна) агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг нисгэгчийн үнэмлэхдээ баталгаажуулсан тэмдэглэл хийлгэж болно.

(d) Хэрэв тухайн багш нь нэмэлт шилжих нислэгийн зааварчилгаа, эсхүл тухайн маягийн ур чадварын шалгалт шаардлагагүй гэж үзвэл, энэ Дүрмийн 61.55(а)-г үл харгалзан, зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч нь тухайн нисгэгчийн эзэмшиж байгаа агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй маш төстэй агаарын хөлгийн маягийн хувьд, агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгож болох ба:

(1) тухайн нисгэгчийн дэвтэрт зохих мэдээллийг

улсаас олгосон нисгэгчийн үнэмлэх, агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй этгээд нь энэ талаар ИНЕГ–ын дарга хүлээн зөвшөөрөхүйц нотлох баримтыг үзүүлэх; эсхүл

2/ нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь “А” ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй, мөн тодорхой онгоцны хувьд энэ дүрмийн 61.53-т заасны дагуу агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, бөгөөд тухайн онгоцон дээр ИНЕГ–ын даргаас хүлээн зөвшөөрсөн нислэгийг үйлдэж байгаа бол; эсхүл

3/ нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн 61.53-т заасны дагуу тухайн маягийн агаарын хөлгийн нисгэгч, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээр эрх олгогдсон бөгөөд тухайн агаарын хөлөг дээр ИНЕГ–ын дарга хүлээн зөвшөөрсөн нислэгийг үйлдэж байгаа бол.

(в) ИНЕГ–ын даргад өргөдөл гаргаснаар болон холбогдох төлбөрийг хийснээр агаарын хөлгийн маягийн зэрэглэлээ (нислэгийн дэвтэрийн тэмдэглэлээс гадна) нисгэгчийн үнэмлэх дээрээ тэмдэглүүлнэ.

(г) Энэ дүрмийн 61.55(а)-г үл харгалзан, үнэмлэх эзэмшигчийн эзэмшиж байгаа агаарын хөлгийн маягийн зэрэглэлд хамаарах агаарын хөлгийн маягтай ижил төстэй агаарын хөлгийн маягийн хувьд шилжих нислэгийн зааварчилгаа шаардлагагүй, эсхүл тухайн маягийн хувьд ур чадварыг нь шалгах шаардлагагүй гэж үзвэл багш нисгэгч нь агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгох ба :

1/ ИНЕГ–ын даргын хүлээн зөвшөөрсөн нислэгийн дэвтэрт тэмдэглэл хийх, ба

2/ тухайн нислэгийн дэвтэрийн баталгаажсан

-Орхигдуулсныг заалыг нэмж оруулсан

<p>Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр оруулна; (2) тухайн багш-нисгэгч нь нисгэгчийн дэвтэрт оруулсан холбогдох мэдээллийн баталгаажуулсан хувийг Даргад хүргүүлнэ.</p>	<p>хуулбарыг ИНЕГ–ын даргад хүргүүлнэ.</p>	
<p>61.57 Анхдагч маягийн эрх Дарга, энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч багш-нисгэгчид, маягийн зэрэглэл эзэмшдэггүй агаарын хөлөгт нисгэгчийн, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх эрх олгож болно. Дарга эрх олгохдоо, нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг зааж өгч болно</p>	<p>61.57. Түр эрх олгох (а) Энэ дүрмийн дагуу олгогдсон багш нисгэгчийн хүчин төгөлдөр зэрэглэл эзэмшигч нь агаарын хөлгийн маягийн зэрэглэлгүй агаарын хөлөг дээр нисгэгч, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх эрхийг ИНЕГ–ын дарга олгож болно. ИНЕГ–ын дарга нисэхийн аюулгүй ажиллагааны үүднээс эрх олгохдоо нэмэлт нөхцөл зааж болно.</p>	<p>-“First of type authorization”-г түр эрх гэснийг Анхдагч маягийн эрх гэж өөрчилсөн</p>
<p>С Бүлэг. Сурагч-нисгэгч</p>	<p>В БҮЛЭГ. СУРАГЧ НИСГЭГЧ / STUDENT PILOTS</p>	
<p>61.101 Зорилго Энэ Бүлэг нь, энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй байх үедээ, агаарын хөлгийн нисгэгчийн (хэт хөнгөн <u>агаарын хөлөг, ханг-глайдер, глайдер, моторт-глайдер, эсхүл бөмбөлөгөөс</u> бусад) үүрэг гүйцэтгэх этгээдэд тавих шаардлага болон хязгаарлалтыг тогтооно.</p>	<p>61.101. Зорилго / Purpose (а) Агаарын хөлөг (<u>хэт хөнгөн агаарын хөлөг, дельтаплан, планер болон хийн бөмбөлөгөөс</u> бусад)-ийн нисгэгчийн үнэмлэх эзэмших зорилгоор нислэг үйлдэх сурагч нисгэгчид хамаарах шаардлага, хязгаарлалтуудыг тодорхойлоход энэ бүлгийн зорилго оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -“хэт хөнгөн агаарын хөлөг, дельтаплан, планер болон хийн бөмбөлөг” гэснийг хэт хөнгөн агаарын хөлөг, ханг-глайдер, глайдер, моторт-глайдер, эсхүл бөмбөлөг” гэж</p>
<p>61.103 Ерөнхий зүйл (а) Энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй этгээд нь дараахаас бусад тохиолдолд, агаарын хөлгийн удирдлагыг гардан гүйцэтгэхгүй, (1) тухайн этгээд нь нисгэгчийн суудалд сууж байгаа, зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчээс хамтарсан <u>нислэгийн зааварчилгаа</u> авч байгаа ; эсхүл (2) тухайн этгээд нь 61.105-ын дагуу хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж байгаа. (б) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу хамтарсан нислэгийн зааварчилгаа авч байгаа этгээд нь тухайн цагийг хамтарсан нислэгийн цагаар бүртгэж болно.</p>	<p>61.103. Ерөнхий зүйл / General (а) Энэ дүрмийн дагуу олгогдсон, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй бол дараах тохиолдлуудаас бусад үед агаарын хөлгийн удирдлаган дээр сууж болохгүй: 1/ нисгэгчийн суудал дээр сууж байгаа багш нисгэгчийн хамт <u>нислэгийн дадлага</u> үйлдэж байгаа бол; эсхүл 2/ энэ дүрмийн 61.105-д заасны дагуу агаарын хөлгийн даргаар нисэж байгаа бол; (б) энэ зүйлийн (а)1/-т заасан нислэгийн дадлагын цагийг хосолсон нислэгийн цагаар нислэгийн дэвтэрт бүртгэнэ.</p>	<p>-“нислэгийн дадлага” гэснийг “нислэгийн зааварчилгаа” гэж</p>
<p>61.105 Бие даасан нислэгийн шаардлага</p>	<p>61.105. Бие даасан нислэгт тавигдах шаардлага /Solo</p>	

(а) Энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй этгээд нь дараахаас бусад тохиолдолд агаарын хөлгөөр бие даасан нислэг үйлдэхгүй:

(1) тухайн этгээд нь 16 нас хүрсэн байх;

(2) тухайн этгээд нь:

(i) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх; эсхүл

(ii) В болон С ангиллын жолооны үнэмлэхэд хамаарах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгосон дараах эрүүл мэндийн тодорхойлолттой байх:

(A) өмнөх 5 жилийн дотор олгосон; эсхүл

(B) хэрэв тухайн этгээд 40, эсхүл түүнээс дээш настай бол, өмнөх 24 сарын дотор олгосон;

(3) тухайн этгээд нь ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийн шаардлагыг хангасан байх;

(4) тухайн этгээд нь агаарын хөлгийн даргын үүрэг, хариуцлагыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлээр унших, ярих, ойлгох болон холбоо барих хангалттай чадвартай байх;

(5) өдөр, эсхүл шөнийн цагаар үйлдэх анхны бие даасан нислэгийг А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч зөвшөөрснөөс бусад тохиолдолд, тухайн нислэгийг хүчинтэй А, В, эсхүл С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч зөвшөөрсөн байх;

(6) энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, хүчинтэй А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч тухайн этгээдийн нисгэгчийн дэвтэрт зааварчилгаа авсан ба дараах ур чадвараа шалгуулсан тухай бичиж баталгаажуулсан байх:

flight requirements

(а) Энэ дүрмийн дагуу олгогдсон, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй хүн дор дурьдсан шаардлагуудыг хангаагүй бол бие даасан нислэгт гарахгүй:

1/ 16 нас хүрсэн байх;

2/ ИНД-67 дагуу олгогдсон 2 дугаар ангиллын эрүүл мэндийн гэрчилгээтэй байх;

3/ агаарын хөлгийн даргын үүрэг, хариуцлагыг хүлээх чадвартай байхын тулд англи, эсхүл монгол хэлээр унших, ярих, ойлгох чадвартай байх;

4/ “А”, “В”, эсхүл “С” ангиллын хүчин төгөлдөр зэрэглэлтэй багш нисгэгчээс бие даасан нислэгт гарах зөвшөөрөл авсан байх, хэрэв анхны бие даасан нислэгт өдрийн, шөнийн цагаар гарах бол “А”, эсхүл “В” ангиллын зэрэглэлтэй багш нисгэгчээс нислэгт гарах зөвшөөрөл заавал авсан байх;

5/ энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд дараах зүйл дээр зааварчилгаа авч, ур чадварын шалгалт өгсөн тухай тэмдэглэлийг “А”, эсхүл “В” ангиллын зэрэглэлтэй багш нисгэгчээр нислэгийн дэвтэртээ хийлгэсэн байх:

-Орчуулга, найруулга зассан

-Энэ зүйлд 2002 оны Amend.6-аар нэмэлт өөрчлөлт оруулсан

<p>(i) нислэгийн бэлтгэл; (ii) хөдөлгүүр асаах болон горим шалгах ажиллагаа; (iii) явгалах; (iv) чиг шулуун нисэх; (v) өндөр авах болон өндөр алдах; (vi) түвшин хадгалах, эргэлтийн үед өндөр авах болон өндөр алдах; (vii) тухайн маягийн агаарын хөлгөөр хөөрөлт, хайрцгаар нисэх болон буулт үйлдэх; (viii) нислэгийн радио холбоо ашиглах; (ix) 2-т гарах журам; (x) нисэх онгоцны хувьд, тухайн маягийн нисэх онгоцоор хурдны нуралтыг таньж мэдрэх (stall) болон түүнээс гарах; (xi) нисэх онгоцны хувьд, хөөрөлтийн үед болон хөөрсний дараа хөдөлгүүр татгалзсан үеийн онцгой нөхцөлийн журам; (xii) нисдэг тэрэгний хувьд, угтах салхи, арын салхи болон хажуугийн салхинд агаарт тогтох нислэг үйлдэх(hovering); (xiii) нисдэг тэрэгний хувьд, тухайн маягийн нисдэг тэрэгний (авторотацаар ойртолт болон буулт үйлдэхийг багтаасан) онцгой нөхцөлийн журам.</p> <p>(7) хүчинтэй А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, тухайн этгээд нислэгийн туршлагын сүүлийн 5 цагт нь хосолсон нислэгийн зааварчилгаа авсан байх;</p> <p>(8) тухайн этгээд нь өмнө үргэлжилсэн 30 хоногийн дотор тохирох агаарын хөлгөөр ниссэн нислэгийн туршлагатай байх;</p> <p>(9) хэрэв тухайн нислэг нь нутаг дамнасан (cross country) бие даасан нислэг бол:</p> <p>(i) тухайн нислэгийг хүчинтэй А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч</p>	<p>5.1 нислэгийн өмнөх бэлтгэл; 5.2 хөдөлгүүр асаалт ба хөдөлгүүрийн горимын ажиллагаа; 5.3 агаарын хөлгийг явгалах; 5.4 чиг шулуун нислэг; 5.5 өндөр авах ба өндөр алдах; 5.6 өндрөө барих, өндөр авах болон өндөр алдах үеийн эргэлтүүд; 5.7 тухайн маягийн агаарын хөлгөөр хөөрөлт, хайрцаг нислэг, буулт үйлдэх; 5.8 нислэгийн радио холбоо ашиглалт; 5.9 ойртолтоос 2 дугаар хайрцагт гарах журам; 5.10 онгоцны хувьд - тухайн маягийн онгоцон дээр хурдны уналтыг мэдрэх, түүнээс гарах; 5.11 онгоцны хувьд - хөөрөх үед болон хөөрсний дараа хөдөлгүүр татгалзсан тохиолдолд гүйцэтгэх онцгой тохиолдлын журам; 5.12 нисдэг тэрэгний хувьд - угтах салхи, арын болон хажуугийн салхитай үед дүүжин нислэг хийх; 5.13 нисдэг тэрэгний хувьд- тухайн маягийн нисдэг тэргэн дээр онцгой тохиолдлын журам, авторотацаар ойртолт ба буулт үйлдэх.</p> <p>6/ “А”, эсхүл “В” ангиллын хүчин төгөлдөр зэрэглэлтэй багш нисгэгч өөрөөр зөвшөөрөөгүй бол, дадлагын нислэгийн сүүлийн 5 цагт нь хосолсон нислэгийн дадлага авсан байна;</p> <p>7/ өмнөх 30 хоногийн хугацаанд зохих агаарын хөлөг дээр нислэгийн жолоодлого гүйцэтгэсэн дадлагатай байна;</p> <p>8/ хэрэв бие даасан нислэг нь алсын зайн нислэг бол:</p> <p>8.1 тухайн нислэгийг “А”, эсхүл “В”</p>	<p>-“алсын зайн” гэснийг “нутаг дамнасан” гэж</p>
--	--	---

<p>зөвшөөрсөн байх; (ii) тухайн этгээд нь хувийн нисгэгчийн үнэмлэх авахад шаардагдах бичгийн шалгалтын хүчинтэй кредитийг цуглуулсан байх.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)(5)-д заасан бие даасан нислэгийг зөвшөөрсөн багш-нисгэгч нь бие даасан нислэгийн турш тухайн нисгэгчийн үйлдлийг хянах үүрэгтэй.</p> <p>(c) Өдрийн цагаар үйлдэх анхны бие даасан нислэгийн хувьд, анхны бие даасан нислэг дууссаны дараа хэрэв багш-нисгэгч нь энэ зүйлийн (a)(6)(i) - (a)(6)(xiii)-ын шаардлагыг хангасан гэж үзвэл, тухайн этгээдийн энэ зүйлийн (a)(6)-д шаардсан нисгэгчийн дэвтэрт баталгаажуулалт хийж болно.</p>	<p>ангиллын хүчин төгөлдөр зэрэглэлтэй багш нисгэгч зөвшөөрсөн байх; 8.2 сурагч нисгэгч нь хувийн нисгэгчийн үнэмлэх авахад шаардагдах бичгийн шалгалт өгсөн байх.</p> <p>(б) Багш нисгэгч нь энэ зүйлийн (a) 4/-т заасан бие даасан нислэгийг зөвшөөрсөн бол бие даасан нислэгийн явц дахь нисгэгчийн үйлдлүүдийг хянана.</p> <p>(в) Анхны бие даасан нислэгийг өдрийн цагаар үйлдэх тохиолдолд аливаа этгээдийг энэ зүйлийн (a) 5/ (5.1)-ээс (5.13) хүртэл тавигдах шаардлагаыг хангасан гэж үзвэл бие даасан нислэгийн дараа багш нисгэгч нь энэ зүйлийн (a)(5)-д заасны дагуу нислэгийн дэвтэрт тэмдэглэл хийж болно.</p>	
<p>61.107 Хязгаарлалт</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу олгодог хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй этгээд нь дараах тохиолдолд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй:</p> <p>(1) цалинтай ажилтнаар; эсхүл</p> <p>(2) хэрэв тухайн агаарын хөлгөөр хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол; эсхүл</p> <p>(3) олон улсын нислэг үйлдэж байгаа; эсхүл</p> <p>(4) хэрэв тухайн агаарын хөлөгт багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчээс бусад этгээдийг тээвэрлэж байгаа бол.</p> <p>(b) <u>Энэ зүйлийн (a)-ийн шаардлага дээр нэмж, 61.105(a)(2)(ii)-ын дагуу ЭМГ эзэмшдэг этгээд нь дараах үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй:</u></p> <p>(1) <u>шөнийн цагаар; эсхүл</u></p> <p>(2) <u>хяналттай аэродром руу, эсхүл хяналттай аэродромоос, тухайн үнэмлэх эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц өнгө ялгах харааны тестийг амжилттай өгснийг нотлох баримтыг Даргад хүргүүлснээс бусад тохиолдолд; эсхүл</u></p> <p>(3) <u>бүүлт болон хөөрөлт үйлдэхээс бусад тохиолдолд.</u></p>	<p>61.107. Хязгаарлалтууд / Limitations</p> <p>(a) Сурагч нисгэгчийг дараах тохиолдолд агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэхийг хориглоно:</p> <p>1/ төлбөрт нислэг үйлдэх үед; эсхүл</p> <p>2/ хэрэв тухайн агаарын хөлөг нь хөлсөөр, эсхүл урамшуулалтай нислэг үйлдэх үед; эсхүл</p> <p>3/ багш нисгэгч, эсхүл шалгагч нисгэгчээс бусад аливаа этгээдийг тээвэрлэх үед;</p> <p>4/ олон улсын нислэгт.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Энэ зүйл 2007 оны Amend.7-оор өөрчлөгдсөн</p>

хот, сум, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр.		
D Бүлэг - Хувийн нисгэгчийн үнэмлэх	Г БҮЛЭГ. ХУВИЙН НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ	
61.151 Зорилго Энэ Бүлэг нь, хувийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт болон хүчинтэй байх зохицуулалтын шаардлагыг тогтооно.	61.151. Зорилго / Purpose (a) Энэ бүлгээр хувийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага болон <u>үнэмлэхний хүчин төгөлдөр байхад шаардагдах зүйлс</u> , эрх, хязгаарлалтуудыг тодорхойлно.	-Орчуулга, найруулга зассан
61.153 Нөхцөл хангах шаардлага (a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй: (1) 17 нас хүрсэн байх; (2) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх; (3) туршлагын хувьд: (i) <u>Даргын хүлээн зөвшөөрөхүйц</u> бие даасан нислэгийн цаг, <u>хамтарсан</u> нислэгийн цаг, хэрэглэлийн цаг болон нутаг дамнасан нислэгийн(cross country) цагийг багтаасан, тохирох категорийн агаарын хөлгийн нисгэгчийн минимум 50 цагийн нислэгийн туршлагатай байх; эсхүл (ii) хэрэв тухайн этгээд нь хувийн нисгэгчийн эрхийг нутаг дамнасан нислэгт (cross country) хэрэгжүүлэхийг зориогүй бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц бие даасан нислэгийн цаг хэрэглэлийн цаг болон хамтарсан нислэгийн цагийг багтаасан, тохирох категорийн агаарын хөлгийн нисгэгчийн минимум 40 цагийн нислэгийн туршлагатай байх,	61.153. Тавигдах шаардлага / Eligibility requirements (a) Энэ зүйлийн (б), (в)-д зааснаас бусад тохиолдолд хувийн нисгэгчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ 17 нас хүрсэн байх; 2/ ИНД-67 дагуу олгогдсон 2 дугаар ангиллын эрүүл мэндийн гэрчилгээтэй байх; 3/ туршлагын хувьд: 3.1 бие даасан, <u>хосолсон</u> , хэрэглэлийн болон алсын зайн нислэгийг багтаасан 50 цагийн нислэгийг зохих ангиллын агаарын хөлгийн хувьд үйлдсэн байх; эсхүл 3.2 хэрэв тухайн этгээд нь алсын зайн нислэг үйлдэх хувийн нисгэгчийн эрхийг эдлэхгүй гэвэл бие даасан, хэрэглэлийн болон хосолсон нислэгийг багтаасан 40 цагийн нислэгийг зохих ангиллын агаарын хөлгийн хувьд үйлдсэн байх, 3.3 <u>10–аас багагүй цагийн бие даасан нислэгийг багш нисгэгчийн хяналтан дор гүйцэтгэсэн байхаас 5 цаг нь алсын зайн нислэг байх бөгөөд уг алсын зайн нислэгийн нэгээс доошгүй нислэг нь, хоёр өөр нисэх буудал дээр бүрэн зогсолттой, 270 км-ээс багагүй (онгоцны хувьд), эсхүл 180 км-ээс багагүй (нисдэг тэрэгний хувьд) алсын зайн нислэг байх.</u> 4/ хэрэв шөнийн нислэгийн эрх эдлэхээр хүсэлт	-“dual flight”- хосолсон нислэг гэснийг “хамтарсан нислэг” гэж өөрчлөгдсөн

(4) хэрэв тухайн этгээд нь хувийн нисгэгчийн эрхийг шөнийн цагаар хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн туршлагатай байх;

(5) хэрэв тухайн этгээд нь нисдэг тэрэгний хувийн нисгэгчийн эрхийг татлагат ачаа тээвэрлэхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц татлагат ачаа тээвэрлэх нислэгийн сургалтад хамрагдсан байх;

(6) хувийн нисгэгчийн үнэмлэхэд хамаарах дараах сэдвээр бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх:

(i) нисэхийн хууль, дүрэм;

(ii) агаарын навигаци болон нислэгийн төлөвлөлт;

(iii) цаг уур;

(iv) агаарын хөлгийн техникийн мэдлэг (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг), аль хамааралтайг;

гаргаж байгаа бол шөнийн нислэгийн дадлага авсан байх ;

5/ хэрэв татлагаар ачаа зөөвөрлөх нисдэг тэрэгний хувийн нисгэгчийн үнэмлэх авахаар хүсэлт гаргаж байгаа бол татлагаар ачаа зөөвөрлөх сургалтанд хамрагдсан байх;

6/ хувийн нисгэгчийн мэдлэгийн хүрээнд дараах сэдвүүдээр мэдлэгийн түвшингээ шалгуулж, бичгийн шалгалт өгсөн байх:

6.1 нисэхийн хууль тогтоомж: хувийн нисгэгчид хамаарах журам, заавар; нислэг үйлдэх журам; нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд хамаарах журам;

6.2 нислэгийн үзүүлэлтүүд ба төлөвлөлт: жин ба ачааллын хуваарилалт, нислэгийн үзүүлэлтэд нөлөөлөх нь; жин ба төвлөрөлтийн тооцоо; нислэгийн өмнөх, төлөвлөлт ба ИХНД-ээр үйлдэгдэх нислэгийн төлөвлөлт; нислэгийн хөдөлгөөнд хамаарах журам; байрлалаа мэдээлэх журам; өндөр тодорхойлох журам; хөдөлгөөний идэвхжилттэй бүсэд нислэг үйлдэх;

6.3 цаг уур: нисэхийн цаг уурын талаарх ерөнхий ойлголт, цаг уурын мэдээллийг хүлээн авах ба ашиглах журам;

6.4 агаарын хөлгийн ашиглалтын талаарх ерөнхий мэдлэг: онгоцны хүчний төхөөрөмжүүд, систем, хэрэглэлийн ажиллах зарчим; онгоц болон хүчний төхөөрөмжүүдийн ашиглалтын хязгаарлалт, нислэг ашиглалтын болон бусад бичиг баримтанд тусгагдсан ашиглалтын холбогдолтой бусад мэдээлэл; (тухайн онгоц эсхүл нисдэг тэрэг);

6.5 хүний хүчин зүйл: нислэгийн үйл ажиллагаан дахь хүний боломж ба хязгаарлалт;

-АС 61-3 гараагүй байсан тул дүрэмд оруулсныг хассан

(v) хүний хүчин зүйл;

(vi) нислэгийн радио холбоо;

(7) дараах мэдлэг болон ур чадвараа шалгагч-нисгэгчид нислэгийн шалгалтаар амжилттай харуулсан байх: “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-д

(i) заасан дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, энэ зүйлийн (а)(б)-д заасан газрын-бэлтгэл шалгалтын сэдвийн мэдлэг;

(ii) хувийн нисгэгчийн үнэмлэхний эрх хязгаарлалтын мэдлэг;

(iii) тухайн нислэгийн шалгалтад ашиглах агаарын хөлгийн маягтай холбоотой техникийн болон үйл ажиллагааны мэдлэг; бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн

(iv) журмын үед нөхцөл байдлыг тодорхойлон зөв шийдвэр гарган удирдах зохих түвшний дадлага хийж байхдаа тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу, түүний үзүүлэлтийн чадал болон хязгаарлалтын хүрээнд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх ур чадвар;

(v) радио холбоо болон фразеолог /стандарт хэллэгийн ур чадвар;

6.6 навигаци: нислэгийн үед навигацийн тооцоо хийх аргачлалууд; агаарын навигацийн карт ашиглах;

6.7 үйл ажиллагааны журмууд: AIP, NOTAM зэрэг агаарын навигацийн бичиг баримт, товчлол ба тэмдэглэгээ; ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ ба ослын нөхцөлд ажиллах журмын ашиглалт;

6.8 нислэгийн үндсүүд /онгоц, нисдэг тэрэг/

6.9 радио холбоо: радио холбоо барих журам ба ИХНД-ээр үйлдэх нислэгийн хэллэг, холбоо тасарсан үед авах арга хэмжээ;

7/ дараах зүйлсээр зөвшөөрөгдсөн багш нисгэгчээс нислэгийн зааварчилга авсан байх:

7.1 аюул занал, алдааг олж, залруулах;

7.2 нислэгийн өмнөх үйл ажиллагаа, үүнд жин ба төвлөрөлтийн тооцоо, агаарын хөлгийн үзлэг болон үйлчилгээ;

7.3 аэродромын хайрцаг нислэг, мөргөлдөхөөс зайлсхийх урьдчилсан сэргийлэх арга, журам;

7.4 онгоцыг гаднах цэгийн тусламжтайгаар ил харааны нислэгээр удирдах;

7.5 онгоцны хувьд: аюултай бага хурдны нислэг, хурдны уналтанд орох, түүний эхэлж байгааг мэдрэх болон түүнээс гарах; эсхүл нисдэг

(vi) бүх нислэгийн туршид нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлийг бататгах хэлбэрээр тухайн агаарын хөлгийг итгэлтэйгээр удирдах.

тэрэгний хувьд: хөдөлгүүрийн чадлыг тохируулах, хөдөлгүүрийн ажиллагааны хэвийн горимд даах сэнсний эргэлт удаашрахыг мэдрэх, тухайн байдлаас гарах арга, техник;

7.6 аюултай өндөр хурдны нислэг, мушгиа уналтанд орох, түүнийг мэдрэх болон түүнээс гарах;

7.7 онгоцны хувьд: хэвийн болон хөндлөнгийн салхитай хөөрөлт буулт; нисдэг тэрэгний хувьд: хөдөлгүүрийн горимыг шалгах; талбай дээр маневрлах, дүүжин нислэг хийх, хэвийн нөхцөлд, салхитай болон налуу газар буулт, хөөрөлт үйлдэх

7.8 онгоцны хувьд: богино зайн болон саадыг чөлөөлөх хөөрөлт, богино зайн буулт; нисдэг тэрэгний хувьд : хамгийн бага хүчээр хөөрөх, буух, хамгийн дээд үзүүлэлтээр хөөрөх, буух техник, хязгаарлагдмал орчны үйл ажиллагаа, яаралтай зогсох;

7.9 зөвхөн хэрэглэлийн хянах самбарыг ашиглан өндрөө хадгалан 180° эргэх, нислэг үйлдэх;

7.10 ил хараагаар, тооцоолол хийн алсын зайн нислэг үйлдэх, боломжит газраа радио-навигацийн төхөөрөмж ашиглах;

7.11 онцгой нөхцөл байдлын үйл ажиллагаа, үүнд онгоцны зарим төхөөрөмжийг зохиомолоор ажиллагаагүй болгон гүйцэтгэх нислэгийн дадлага багтсан байх; нисдэг тэрэгний хувьд авторотацаар ойртолт үйлдэх;

7.12 хяналттай аэродром руу орох, гарах, дайран өнгөрөх үйл ажиллагаа, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний журмыг даган мөрдөх;

7.13 холбооны журам, хэвшмэл үг хэллэгийн талаарх мэдлэг;

8/ дараах чадвараа шалгах-нисгэгчид нислэгийн шалгалтын явцад харуулсан байх:

8.1 энэ зүйлийн (а) 6/-д заасан бичгийн шалгалтын сэдвүүдээс “хангалтгүй” гэж дүгнэгдсэн сэдэвтэй

(b) Хуулийн дагуу, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх болон холбогдох ЭМГ эзэмшдэг этгээд нь, ижил категорийн агаарын хөлгийн хувьд, Дарга тухайн этгээдэд хувийн нисгэгчийн үнэмлэх олгох зорилгод нийцсэн үнэмлэх болон ЭМГ-тэй байж болно.

(c) Даргын шилжүүлсэн эрхийн хүрээнд, глайдерын байгууллагаас олгосон хүчинтэй глайдерын нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь хэрэв дараах шаардлагыг хангасан бол хувийн нисгэгчийн үнэмлэх (глайдер) эзэмших эрхтэй:

- (1) 17 нас хүрсэн байх;
- (2) нислэгийн радио холбооны шалгалтын кредиттэй байх;

(3) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх.

(d) Нислэгийн туршлагаа хадгалан, Монгол Улсын зэвсэгт хүчний хөлгийн дарга, эсхүл 2-р нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа этгээдийг Дарга дараах шаардлагыг хангасанд

хлбоотой ур чадвараа тодорхой харуулах;
8.2 хувийн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын талаарх мэдлэг;

8.3 нислэгийн шалгалтанд хэрэглэж байгаа агаарын хөлгийн маягтай хамааралтай үйл ажиллагааны болон техникийн мэдлэг;

8.4 тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу түүний ашиглалтын хязгаарлалтын хүрээнд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн нөхцөл байдалд бодиттой кредит өгч, зөв шийдвэр гаргах чадвар;

8.5 радио холбооны журам болон хэвшмэл үг, хэллэгийн талаарх чадвар;

8.6 нислэгийн маневр, эсхүл журмын гүйцэтгэлд эргэлзэх зүйлгүйгээр, нислэгийн бүх хугацаанд агаарын хөлгийг удирдах.

(б) ИНЕГ-ын дарга Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй этгээдэд түүний нисгэгчийн үнэмлэхийг үндэслэн хувийн нисгэгчийн үнэмлэх олгож болно.

(в) ИНЕГ-ын даргаас шилжигдсэн эрхийн хүрээнд, планерийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага\нисэх клубээс олгосон хүчин төгөлдөр планерийн нисгэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан этгээдэд хувийн нисгэгчийн үнэмлэх (планерийн) олгоно:

- 1/ 17 нас хүрсэн байх;
- 2/ нислэгийн радио холбооны шалгалт өгсөн байх;
- 3/ ИНД-67 дагуу олгогдсон 2 дугаар ангиллын эрүүл мэндийн гэрчилгээтэй байх.

(г) Энэ зүйлийн (а)-гийн 3/-ын (3.1) болон (3.2)-т шаардсан нислэгийн цагт, тухайн өргөдөл гаргагчийн зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр гүйцэтгэсэн

-Энэ зүйлийн (а)-д 2002 оны Amend.6-аар нэмэлт өөрчлөлт оруулсан

<p><u>тооцож болно:</u></p> <p>(1) <u>энэ зүйлийн (а)(6), хэрэв тухайн этгээд, хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 5 жилд холбогдох нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг амжилттай өгсөн бол;</u></p> <p>(2) <u>энэ зүйлийн (а)(7).</u></p>	<p><u>нислэгийн цагаас, 5 хүртэлх цагийг нь тооцно.</u></p>	
<p>61.155 Эрх, хязгаарлалт</p> <p>(а) Энэ зүйлийн (b)(3)-ыг харгалзан, хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах эрхтэй:</p> <p>(1) тухайн нисгэгч маягийн зэрэглэл эзэмшдэг ба нисгэгчийн үнэмлэхэнд зөвшөөрсөн категорийн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх ба агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэж болно;</p> <p>(2) хамтран нисгэгчтэй үйл ажиллагаа эрхлэхийг шаарддаг, тухайн нисгэгч маягийн зэрэглэл эзэмшдэг ба нисгэгчийн үнэмлэхэнд зөвшөөрсөн категорийн агаарын хөлгийн хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх.</p> <p>(b) Дараах тохиолдолд, хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй:</p> <p>(1) <u>цалинтай ажилтнаар; эсхүл</u> хэрэв тухайн агаарын хөлгөөр <u>хөлс, эсхүл шан</u></p> <p>(2) <u>урамшуулалтай</u> үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол; эсхүл</p> <p>(3) зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч, нисгэгчийн дэвтэрт нь тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай нислэгийн сургалтыг амжилттай дүүргэснийг тэмдэглэснээс бусад тохиолдолд, тухайн агаарын хөлгөөр:</p> <p>(i) шөнийн цагаар, үйл ажиллагаа гүйцэтгэхийг; эсхүл</p> <p>(ii) нутаг дамнасан нислэгийн (cross country) үйл ажиллагаа гүйцэтгэхийг; эсхүл</p>	<p>61.155. Эрх, хязгаарлалт / Privileges and limitations</p> <p>(а) Энэ зүйлийн (б) 3/-ын хүрээнд хувийн нисгэгч нь дараах эрх эдэлнэ:</p> <p>1/ тухайн ангиллын агаарын хөлгийн хувьд нисгэгчийн үнэмлэх олгогдсон, мөн тухайн ангиллын хувьд агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг бол, тухайн ангиллын агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэн зорчигч тээвэрлэж болно;</p> <p>2/ тухайн ангиллын агаарын хөлгийн хувьд нисгэгчийн үнэмлэх олгогдсон, мөн тухайн ангиллын хувьд агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг бол, хамтран нисгэгч шаардлагатай тухайн ангиллын агаарын хөлөг дээр хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх.</p> <p>(б) Шаардлагатай нислэгийн сургалт, дадлагад хамрагдсан тухай багш нисгэгч нислэгийн дэвтэрт нь тэмдэглээгүй бол хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах тохиолдолд агаарын хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй:</p> <p>1/ <u>ашиг олох зорилгоор;</u></p> <p>2/ <u>хөлсөөр болон урамшуулалттай</u> нислэг үйлдэх</p> <p>3/ хэрэв агаарын хөлөг нь:</p> <p>3.1 шөнийн цагаар нислэг үйлдэж байгаа бол;</p> <p>3.2 алсын зайн нислэг үйлдэж байгаа бол;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Энэ зүйлд 2011 оны Amend.10-аар нэмэлт өөрчлөлт оруулсан</p> <p>-“remuneration”-ашиг олох зорилгоор гэснийг “цалинтай ажилтнаар” гэж өөрчилсөн</p>

<p>(iii) нисдэг тэргээр татлагат ачаа тээвэрлэхийг.</p> <p>(c) Энэ зүйлийн (b)(2)-ыг үл харгалзан, хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь глайдерыг нислэгт чирэх хөлс, эсхүл шан урамшуулалтай гэхдээ цалингүй ажилтнаар үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно гэхдээ зөвхөн <u>хэрэв тухайн үйл ажиллагаа нь глайдерын байгууллагын шууд хяналтад, эсхүл ИНД-115-ын дагуу Даргын олгосон чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд хийгдэж байгаа бол</u>, .</p>	<p>3.3 татлагаар ачаа зөөвөрлөх нисдэг тэргэнд.</p> <p>(в) Энэ зүйлийн (б)1/-д заасныг үл харгалзан хувийн нисгэгч нь ашиг олох зорилгоор биш бол дараах нислэгт хөлсөөр болон урамшууллаар агаарын хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно:</p> <p>1/ хэрэв нислэгийн үйл ажиллагаа нь планерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага\нисэх клубын шууд хяналтанд байвал планер чирэх нислэгт;</p> <p>2/ хэрэв нислэгийн үйл ажиллагаа нь шүхрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага\нисэх клубын шууд хяналтанд байвал шүхэрчид буулгах нислэгт.</p>	
<p>61.157 Хүчинтэй байх шаардлага</p> <p>Хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь эзэмшиж байгаа хувийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.35 (Эрүүл мэндийн шаардлага), 61.37 (Нислэгийн туршлага хадгалах) болон 61.39-д (Хоёр жилийн нислэгийн дүгнэлт) заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.</p>	<p>61.157. Ур чадварын хадгалалтад тавигдах шаардлага / Currency requirements</p> <p>(а) Хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь үнэмлэхээр олгогдсон эрхийг эдлэхийн өмнө энэ дүрмийн 61.35 (эрүүл мэндэд тавигдах шаардлага), 61.37 (нислэгийн дадлага, туршлага), 61.39-д (2 жил тутмын нислэгийн үзлэг) заасан шаардлагыг хангасан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -“Currency requirements”- ур чадварын хадгалалтад тавигдах шаардлага гэснийг хүчинтэй байх шаардлага гэж өөрчилсөн</p>
<p>Е Бүлэг. Коммерийн нисгэгчийн үнэмлэх</p>	<p>Д БҮЛЭГ. КОММЕРИЙН НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ</p>	
<p>61.201 Зорилго</p> <p>Энэ Бүлэг нь, коммерийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт болон хүчинтэй байх зохицуулалтын шаардлагыг тогтооно</p>	<p>61.201. Зорилго / Purpose</p> <p>(а) Энэ бүлгээр коммерийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага болон үнэмлэхний хүчин төгөлдөр байхад шаардагдах зүйлс, эрх, хязгаарлалтуудыг тодорхойлно.</p>	
<p>61.203 Нөхцөл хангах шаардлага</p> <p>(а) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) <u>18 нас</u> хүрсэн байх;</p> <p>(2) нисэх онгоц болон нисдэг тэрэгний хувьд тохирох категорийн агаарын хөлгийн хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;</p> <p>(3) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 1-р ангиллын ЭМГ эзэмшдэг байх;</p> <p>(4) тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, <u>Даргын</u></p>	<p>61.203. Тавигдах шаардлага / Eligibility requirements</p> <p>(а) Коммерийн нисгэгчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ <u>21</u> нас хүрсэн байх;</p> <p>2/ онгоц, нисдэг тэрэгний хувьд агаарын хөлгийн зохих ангиллын хүчин төгөлдөр хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;</p> <p>3/ ИНД-67 дагуу олгогдсон 1 дүгээр ангиллын эрүүл мэндийн гэрчилгээтэй байх;</p> <p>4/ агаарын хөлгийн зохих ангиллын хувьд</p>	<p>-Энэ зүйлд 2002 оны Amend.6-аар нэмэлт өөрчлөлт оруулсан</p> <p>-“Даргын хүлээн зөвшөөрөхүйц” гэсэн</p>

хүлээн зөвшөөрөхүйц тодорхой нислэгийн туршлагаас бүрдсэн нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн дараах минимум ерөнхий нислэгийн цагийн туршлагатай байх:

(i) нисэх онгоцны хувьд, 200 цагийн, эсхүл хэрэв зөвшөөрөгдсөн сургалтын курсийг төгссөн бол, 150 цагийн;

(ii) нисдэг тэрэгний хувьд, 150 цагийн, эсхүл хэрэв зөвшөөрөгдсөн сургалтын курсийг төгссөн бол, 125 цагийн;

(iii) глайдерын хувьд, 150 цагийн;

(iv) бөмбөлгийн хувьд, 50 цагийн;

(5) хэрэв тухайн этгээд нь коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг шөнийн цагаар хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн цагийн туршлагатай байх;

(6) коммерийн нисгэгчийн үнэмлэхэд хамаарах дараах

нислэгийн дараах туршлагатай байх:

4.1 онгоцны хувьд, 200 цагийн нислэг үйлдсэн байхаас 100 цагт нь агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн байх, эсхүл зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагын сургалтанд суралцаж 150 цагийн нислэг үйлдсэн байхаас 70 цагт нь агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн байх;

4.2 нисдэг тэрэгний хувьд, 150 цагийн нислэг үйлдсэн байх, эсхүл зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагын сургалтанд суралцаж 125 цагийн нислэг үйлдсэн байхаас 35 цагт нь агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн байх;

4.3 планерийн хувьд - 150 цаг, 20 –оос доошгүй хөөрөлт буулт үйлдсэн байх;

4.4 хийн бөмбөлгийн хувьд - 50 цаг, 8-аас доошгүй хөөрч буусан байх;

4.5 онгоцны хувьд: 20 цаг агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн алсын зайн нислэг байх бөгөөд уг алсын зайн нислэгийн нэгээс доошгүй нислэг нь, хоёр өөр нисэх буудал дээр бүрэн зогсолттой, 540 км-ээс багагүй алсын зайн нислэг байх.

4.6 нисдэг тэрэгний хувьд: хоёр өөр нисэх буудал дээр буулт үйлдсэн, агаарын хөлгийн даргын үүргийг 10 цаг гүйцэтгэсэн алсын зайн нислэг байх.

4.7 10 цагийн хэрэглэлийн нислэг үйлдсэн байхаас 5-аас ихгүй цагийн нислэг нь хэрэглэлийн газрын цаг байх.

5/ хэрэв коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь шөнийн нислэгийн эрх эдлэхийг хүсвэл, 5 хөөрөлт 5 буултыг багтаасан 10 цагийн шөнийн нислэгийн дадлагатай байх;

6/ коммерийн нисгэгчийн мэдлэгийн хүрээнд дараах

шаардлагыг орхигдуулсныг нөхөж оруулсан

-“Нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн байх” гэсэн шаардлагыг “агаарын хөлгийн даргаар ниссэн байх” гэж дүрмийн шаардлагыг хүндрүүлсэн

сэдвээр бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх:

(i) нисэхийн хууль, дүрэм;

(ii) нислэгийн навигацийн ерөнхий мэдлэг;

(iii) цаг уур;

(iv) нислэгийн зарчим болон агаарын хөлгийн үзүүлэлт (нисэх онгоц, нисдэг тэрэг, эсхүл глайдерын аль хамааралтайг);

(v) агаарын хөлгийн техникийн ерөнхий мэдлэг (нисэх онгоц, нисдэг тэрэг, эсхүл глайдерын аль хамааралтайг);

(vi) бөмбөлгийн техникийн мэдлэг болон аэростатик (бөмбөлөг);

(vii) хүний хүчин зүйл;

сэдвүүдээр мэдлэгийн түвшингээ шалгуулж, бичгийн шалгалт өгсөн байх:

6.1 нисэхийн хууль тогтоомж: нислэг үйлдэх журам; нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд хамаарах журам;

6.2 навигаци: нислэгийн үед навигацийн тооцоо хийх аргачлалууд; агаарын навигацийн карт ашиглах;

6.3 цаг уур: нисэхийн цаг уурын талаарх ерөнхий ойлголт, цаг уурын мэдээллийг хүлээн авах ба ашиглах журам;

6.4 нислэгийн үндсүүд /(онгоц), (нисдэг тэрэг), эсхүл (планер)/;

6.5 хүний хүчин зүйл: нислэгийн үйл ажиллагаан дахь хүний боломж ба хязгаарлалт;

6.6 агаарын хөлгийн ашиглалтын талаарх ерөнхий мэдлэг: онгоцны хүчний төхөөрөмжүүд, систем, хэрэглэлүүдийн ажиллах зарчим; онгоц болон хүчний төхөөрөмжүүдийн ашиглалтын хязгаарлалт, нислэг ашиглалтын болон бусад бичиг баримтанд тусгагдсан ашиглалтын холбогдолтой бусад мэдээлэл

6.7 нислэгийн үзүүлэлтүүд ба төлөвлөлт: жин ба ачааллын хуваарилалт нислэгийн үзүүлэлтэд нөлөөлөх нь; жин ба төвлөрөлтийн тооцоо; нислэгийн өмнөх төлөвлөлт ба ИХНД-ээр үйлдэгдэх нислэгийн төлөвлөлт; нислэгийн хөдөлгөөнд хамаарах журам; байрлалаа мэдээлэх болон нислэгийн өндөр тодорхойлох журам; хөдөлгөөний идэвхжилттэй бүсэд нислэг үйлдэх;

6.8 ашиглалтын журам: AIP, NOTAM зэрэг агаарын навигацийн бичиг баримт, товчлол ба тэмдэглэгээ, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ ба ослын нөхцөлд ажиллах журам; аюултай ачаа тээвэрлэх журам, зорчигчдод аюулгүй ажиллагааны талаар мэдээлэх журам;

-Amend.3-аар өөрчлөгдсөн

-“планер” гэснийг “глайдер” гэж өөрчлөгдсөн

АС 61-5 гараагүй байсан тул дүрэмд оруулсныг хассан

(7) нислэгийн шалгалтаар дараах мэдлэг, үр чадвараа Даргад амжилттай харуулсан байх:

- (i) “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-д дэлгэрэнгүй заасан мэдээллийг багтаасан, энэ зүйлийн (а)(б)-д заасан газрын бэлтгэлийн шалгалтын сэдвийн мэдлэг;
- (ii) коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрх хязгаарлалтын мэдлэг;
- (iii) тухайн нислэгийн шалгалтад ашиглах агаарын хөлгийн маягт хамаарах техникийн болон үйл ажиллагааны мэдлэг;
- (iv) бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журмын үед нөхцөл байдлыг тодорхойлон зөв шийдвэр гарган удирдах зохих түвшний дадлага хийж байхдаа тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу, түүний үзүүлэлтийн чадал болон хязгаарлалтын хүрээнд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх ур чадвар;
- (v) радио холбоо болон фразеолог /стандарт хэллэгийн ур чадвар;
- (vi) бүх нислэгийн туршид нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлийг бататгах хэлбэрээр тухайн агаарын хөлгийг итгэлтэйгээр удирдах.

(b) Нислэгийн туршлагаа хадгалан, Монгол Улсын зэвсэгт хүчний хөлгийн дарга, эсхүл 2-р нисгэгчийн үүрэг гүйцэтгэж, мэргэшлээ хадгалж байгаа этгээдийг Дарга дараах шаардлагыг хангасанд тооцож болно:

(1) энэ зүйлийн (а)(2);

(2) энэ зүйлийн (а)(б), хэрэв тухайн этгээд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 5 жилд холбогдох нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг амжилттай өгсөн бол;

(3) энэ зүйлийн (а)(7).

6.9 радио холбоо: радио холбоо барих журам ба ИХНД-ээр үйлдэх нислэгийн хэллэг, холбоо тасарсан үед авах арга хэмжээ.

8/ дараах чадвараа ИНЕГ–ын даргад нислэгийн шалгалтын явцад амжилттай харуулсан байх:

8.1 энэ зүйлийн (а) 6/-д заасан бичгийн шалгалтын сэдвүүдээс “хангалтгүй” гэж дүгнэгдсэн сэдвийг улам дэлгэрэнгүйгээр;

8.2 коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын талаарх мэдлэг;

8.3 нислэгийн шалгалтанд хэрэглэж байгаа агаарын хөлгийн маягтай хамааралтай үйл ажиллагааны болон техникийн мэдлэг;

8.4 тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу түүний ашиглалтын хязгаарлалтын хүрээнд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн нөхцөл байдалд бодитой кредит өгч, зөв шийдвэр гаргах чадвар;

8.5 радио холбооны журам болон хэвшмэл үг, хэллэгийн талаарх чадвар;

8.6 нислэгийн маневр, эсхүл журмын гүйцэтгэлд эргэлзэх зүйлгүйгээр, нислэгийн бүх хугацаанд агаарын хөлгийг удирдах.

-“хэвшмэл үг, хэллэг” гэснийг “фразеолог /стандарт хэллэг/” гэж

Amend.3-аар нэмэгдсэн

7/ дараах зүйлсээр зөвшөөрөгдсөн багш нисгэгчээс нислэгийн зааварчилга авсан байх:

7.1 аюул занал, алдааг олж, залруулах;

7.2 нислэгийн өмнөх үйл ажиллагаа, үүнд жин ба төвлөрөлтийн тооцоо, агаарын хөлгийн үзлэг болон үйлчилгээ;

7.3 аэродромын хайрцаг нислэг, мөргөлдөхөөс зайлсхийх урьдчилсан сэргийлэх арга, журам;

7.4 онгоцыг гаднах цэгийн тусламжтайгаар ил харааны нислэгээр удирдах;

7.5 онгоцны хувьд: аюултай бага хурдны нислэг, хурдны уналтанд орох, түүний эхэлж байгааг мэдрэх болон түүнээс гарах; эсхүл нисдэг тэрэгний хувьд: хөдөлгүүрийн чадлыг тохируулах, хөдөлгүүрийн ажиллагааны хэвийн горимд даах сэнсний эргэлт удаашрахыг мэдрэх, тухайн байдлаас гарах арга, техник;

7.6 аюултай өндөр хурдны нислэг, мушгиа уналтанд орох, түүнийг мэдрэх болон түүнээс гарах;

7.7 онгоцны хувьд: хэвийн болон хөндлөнгийн салхитай хөөрөлт буулт; нисдэг тэрэгний хувьд : хөдөлгүүрийн горимыг шалгах; талбай дээр маневрлах, дүүжин нислэг хийх, хэвийн нөхцөлд, салхитай болон налуу газар буулт, хөөрөлт үйлдэх, огцом ойртолт үйлдэх;

7.8 онгоцны хувьд: богино зайн болон саадыг чөлөөлөх хөөрөлт, богино зайн буулт; нисдэг тэрэгний хувьд: хамгийн бага хүчээр хөөрөх, буух, хамгийн дээд үзүүлэлтээр хөөрөх, буух техник, хязгаарлагдмал орчны үйл ажиллагаа, яаралтай зогсох;

7.9 зөвхөн хэрэглэлийн тусламжтайгаар энгийн нислэгийн маневр үйлдэх болон нислэгийн хэвийн бус байдлаас гарах;

7.10 ил хараагаар, тооцоолол хийн алсын зайн нислэг үйлдэх, боломжит газраа радио-навигацийн төхөөрөмж ашиглах; чиглэлээ өөрчлөх журам;

	<p><u>7.11 онцгой нөхцөл байдлын үйл ажиллагаа, үүнд онгоцны зарим төхөөрөмжийг зохиомолоор ажиллагаагүй болгон гүйцэтгэх нислэгийн дадлага багтсан байх; нисдэг тэрэгний хувьд авторотацаар ойртолт үйлдэх;</u></p> <p><u>7.12 хяналттай аэродром руу орох, гарах, дайран өнгөрөх үйл ажиллагаа, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний журмыг даган мөрдөх;</u></p> <p><u>7.13 холбооны журам, хэвшмэл үг хэллэгийн талаарх мэдлэг;</u></p> <p><u>7.14 онгоцны хувьд: сөөлжсөн чадалтай олон хөдөлгүүрт онгоцны нислэг, нисдэг тэрэгний хувьд: газрын нөлөөнөөс гарч дүүжин нислэг үйлдэх, хэрэв боломжтой бол гадна ачаалалтай нислэг үйлдэх, хэт өндрийн нислэг.</u></p> <p><u>(б) Энэ зүйлийн (а)–гийн 4/-ын (4.1) болон (4.2) -т шаардсан нислэгийн цагт, тухайн өргөдөл гаргагчийн зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр гүйцэтгэсэн нислэгийн цагаас 10 хүртэлх цагийг нь тооцно.</u></p>	
<p>61.205 Эрх, хязгаарлалт</p> <p>(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх нь түүнийг эзэмшигчид, тухайн үнэмлэх олгосон ижил категорийн болон тухайн нисгэгч маягийн зэрэглэл эзэмшдэг агаарын хөлгөөр дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:</p> <p>(1) хувийн нисгэгчийн үнэмлэхний холбогдох эрх;</p> <p>(2) хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд ашиглаж байгаа ганц-нисгэгчтэй гэрчилгээжсэн агаарын хөлгийн үйл ажиллагаанд хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;</p> <p>(3) агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд ашиглаж байгаа олон нисгэгчтэй гэрчилгээжсэн агаарын хөлгийн үйл ажиллагаанд хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;</p> <p>(4) хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд ашиглаж байгаа олон-нисгэгчтэй гэрчилгээжсэн агаарын</p>	<p>61.205. Эрх, хязгаарлалт / Privileges and limitations</p> <p>(а) Хэрэв тухайн ангиллын агаарын хөлгийн хувьд нисгэгчийн үнэмлэх олгогдсон болон тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй бол энэ зүйлийн (б)–гын хүрээнд коммерийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч нь ижил ангиллын агаарын хөлөг дээр дараах эрх эдэлнэ:</p> <p>1/ хувийн нисгэгчийн эдлэх аливаа эрхийг;</p> <p>2/ <u>нэг нисгэгчтэй</u> агаарын хөлгөөр, хөлсөөр болон урамшуулалтай нислэг үйлдэх бол тухайн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;</p> <p>3/ олон нисгэгчтэй агаарын хөлгөөр, хөлсөөр болон урамшуулалтай нислэг үйлдэх бол тухайн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх (гэхдээ агаарын тээврийн үйл ажиллагаанд биш);</p> <p>4/ олон нисгэгчтэй агаарын хөлгөөр, хөлсөөр болон урамшуулалтай нислэг үйлдэх бол тухайн агаарын</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>хөлгийн үйл ажиллагаанд хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх.</p> <p>(b) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь шаардлагатай шөнийн нислэгийн сургалтыг амжилттай дүүргэсэн болохыг зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч нисгэгчийн дэвтэрт тэмдэглэл хийснээс бусад тохиолдолд, шөнийн цагаар агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй.</p>	<p>хөлгийн хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх.</p> <p>(b) Шаардлагатай нислэгийн сургалт, дадлагад хамрагдсан тухай багш нисгэгч нислэгийн дэвтэрт нь тэмдэглээгүй бол коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь агаарын хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй.</p>	
<p>61.207 Хүчинтэй байх шаардлага</p> <p>Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь эзэмшиж байгаа коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.35 (Эрүүл мэндийн шаардлага), 61.37 (Нислэгийн туршлага хадгалах) болон 61.39-д (Хоёр жилийн нислэгийн дүгнэлт) заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.</p>	<p>61.207. Ур чадварын хадгалалтад тавигдах шаардлага / Currency requirements</p> <p>(a) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь үнэмлэхээр олгогдсон эрхийг эдлэхийн өмнө 61.35 (эрүүл мэндэд тавигдах шаардлага), 61.37 (нислэгийн дадлага, туршлага), 61.39-д (2 жил тутмын нислэгийн үзлэг) заасан шаардлагыг хангасан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>F Бүлэг. Агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх</p>	<p>E БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ / AIRLINE TRANSPORT PILOT LICENCES</p>	
<p>61.251 Зорилго</p> <p>Энэ Бүлэг нь агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага тухайн үнэмлэхний эрх болон хүчинтэй байх зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>61.251. Зорилго / Purpose</p> <p>(a) Энэ бүлгээр агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавигдах шаардлага болон үнэмлэхний хүчин төгөлдөр байхад шаардагдах зүйлс, эрх, хязгаарлалтуудыг тодорхойлно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>61.253 Нөхцөл хангах шаардлага</p> <p>(a) Агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) 21 нас хүрсэн байх; (2) тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх; (3) хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байх; (4) тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц тодорхой нислэгийн туршлагаас бүрдсэн нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн дараах минимум ерөнхий нислэгийн цагийн туршлагатай байх: <ol style="list-style-type: none"> (i) нисэх онгоцны хувьд, 1500 цагийн; (ii) нисдэг тэрэгний хувьд, 1000 цагийн; 	<p>61.253. Тавигдах шаардлага / Eligibility requirements</p> <p>(a) Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ 21 нас хүрсэн байх; 2/ тухайн агаарын хөлгийн зохих ангиллын коммерийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигч байх; 3/ хүчин төгөлдөр хэрэглэлийн зэрэглэлтэй байх; 4/ тухайн агаарын хөлгийн ангиллын хувьд нислэгийн дараах туршлагатай байх: <ol style="list-style-type: none"> 4.1. онгоцны хувьд: <ol style="list-style-type: none"> 4.1.1. нисгэгчээр нийт 1500 цаг ниссэн; 4.2. нисдэг тэрэгний хувьд: <ol style="list-style-type: none"> 4.2.1. нийт нислэгийн 1000 цаг; 	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

(5) агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхэд хамаарах дараах сэдвээр бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх:

(i) нисэхийн хууль, дүрэм;

(ii) нислэгийн навигацийн ерөнхий мэдлэг;

(iii) нислэгийн төлөвлөгөө (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний аль хамааралтайг)

(iv) цаг уур;

(v) хэрэглэл болон навигацийн туслах төхөөрөмж (зөвхөн нисэх онгоц)

(vi) хүний хүчин зүйл;

(vii) гүнзгийрүүлсэн аэродинамик, техникийн үзүүлэлт болон системийн талаарх мэдлэг (зөвхөн нисэх онгоц);

(viii) аэродинамик болон агаарын хөлгийн систем (зөвхөн нисдэг тэрэг);

(ix) техникийн үзүүлэлт болон ачаалалт (зөвхөн нисдэг тэрэг);

5/ агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн мэдлэгийн хүрээнд дараах сэдвүүдээр мэдлэгийн түвшингээ шалгуулж, бичгийн шалгалт өгсөн байх:

5.1 нисэхийн хууль тогтоомж: агаарын тээвэрлэгчийн нисгэгчид хамаарах журам, заавар; нислэг үйлдэх журам; нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд хамаарах журам;

5.2 навигаци: нислэгийн үед навигацийн тооцоо хийх аргачлалууд; агаарын навигацийн карт ашиглах; алсын зайн нислэгт тавигдах навигацийн тусгай шаардлага; навигацийн хэрэглэлүүдийн ашиглалт, тэдгээрийн хязгаарлалт;

5.3 нислэгийн үзүүлэлтүүд ба төлөвлөлт: жин ба ачааллын хуваарилалт нислэгийн үзүүлэлтэд нөлөөлөх нь; жин ба төвлөрөлтийн тооцоо; нислэгийн өмнөх төлөвлөлт ба ИХНД-ээр үйлдэгдэх нислэгийн төлөвлөлт; нислэгийн хөдөлгөөнд хамаарах журам; байрлал мэдээлэх журам; өндөр тодорхойлох журам; хөдөлгөөний идэвхжилтэй бүсэд нислэг үйлдэх;

5.4 цаг уур: нисэхийн цаг уурын талаарх ерөнхий ойлголт; цаг уурын мэдээллийг хүлээн авах ба ашиглах журам; агаарын хөлгийн их биений болон хөдөлгүүрийн мөсдөлт; цаг агаарын аюултай үзэгдлийн бүсээс зайлсхийх, түүнийг нэвтрэн өнгөрөх журам;

5.5 хүний хүчин зүйл: нислэгийн үйл ажиллагаан дахь хүний боломж ба хязгаарлалт;

5.6 нислэгийн зарчмууд: агаарын хөлгийн хэв загвар, тэдгээрийн аэродинамикийн үзүүлэлтүүд, өргөх болон эсэргүүцэх хүчинд үзүүлэх нөлөө

-АС 61-7-д туссан

-АС 61-7-д туссан

(6) энэ зүйлийн (b)-г харгалзан, дараах мэдлэг, ур чадвараа нислэгийн шалгалтаар Даргад, эсхүл ИНД-119-ийн дагуу олгосон шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний, эсхүл ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа, зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгчид амжилттай харуулсан байх, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол:

(i) “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-д заасан дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, энэ зүйлийн (a)(5)-д заасан газрын бэлтгэлийн шалгалтын сэдвийн мэдлэг;

(ii) агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхний эрх хязгаарлалтын мэдлэг;

(iii) нислэгийн шалгалтад ашиглах агаарын хөлгийн маягтай холбоотой техникийн болон үйл ажиллагааны мэдлэг;

(iv) бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журмын үед нөхцөл байдлыг тодорхойлон зөв шийдвэр гарган удирдах зохих түвшний дадлага хийж байхдаа тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу, түүний үзүүлэлтийн чадал болон хязгаарлалтын хүрээнд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх ур чадвар;

(v) НХҮ-ний журам болон [фразеолог/стандарт хэллэгийн](#) ур чадвар;

(vi) бүх нислэгийн туршид нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлийг бататгах хэлбэрээр тухайн агаарын хөлгийг итгэлтэйгээр удирдах;

(b) Энэ зүйлийн (a)(6)-д шаардсан нислэгийн шалгалт нь IFR-ийн дагуу үйлдэх [нутаг дамнасан](#) нислэг (cross country) байх ёстой ба агаарын хөлөг нь дараах шаардлага хангасан байна:

(1) МСТOW нь **5700 кг, эсхүл түүнээс дээш** жинтэй олон хөдөлгүүртэй агаарын хөлөг; эсхүл

6/ энэ зүйлийн (б)–гын хүрээнд дараах чадвараа ИНЕГ–ын даргад, эсхүл ИНД-141 ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагад, эсхүл ИНД-119–ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэр эрхлэгчийн үйл ажиллагааны шалгах-нисгэгчид нислэгийн шалгалтын явцад амжилттай харуулсан байх:

6.1 энэ зүйлийн (a) 5/-д заасан бичгийн шалгалтын сэдвүүдээс “хангалтгүй” гэж дүгнэгдсэн сэдвийг улам дэлгэрэнгүйгээр;

6.2 агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын талаарх мэдлэг;

6.3 нислэгийн шалгалтанд хэрэглэж байгаа агаарын хөлгийн маягтай хамааралтай үйл ажиллагааны болон техникийн мэдлэг;

6.4 тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу түүний ашиглалтын хязгаарлалтын хүрээнд хэвийн, хэвийн бус, онцгой тохиолдлын үеийн нөхцөл байдалд бодитой кредит өгч, зөв шийдвэр гаргах чадвар;

6.5 агаарын хөдөлгөөний үйлчилгээний журам болон [хэвшмэл үг, хэллэгийн](#) талаарх чадвар;

6.6 нислэгийн маневр, эсхүл журмын гүйцэтгэлд эргэлзэх зүйлгүйгээр, нислэгийн бүх хугацаанд агаарын хөлгийг удирдах;

(б) Энэ зүйлийн (a) 6/-д шаардсан нислэгийн шалгалт нь хэрэглэлийн нислэгийн дүрэм (ХНД)-ийн дагуу үйлдэгдэх [алсын зайн](#) нислэг байх ба тухайн агаарын хөлөг нь:

1/ хөөрөлтийн **дээд жин нь 5700 кг-аас** дээш жинтэй

-“хэрэв гэрчилгээнд нь тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрсөн бол” гэсэн нөхцөлийг орхигдуулсан

-“5700-аас дээш” гэснийг “5700 кг, эсхүл түүнээс дээш” гэж залруулсан

(2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц олон хөдөлгүүртэй агаарын хөлөг; эсхүл

(3) агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалтад зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуур байж болно.

(с) Дарга, өмнө үргэлжилсэн 12 сарын дотор тохирох категорийн 2 нисгэгчтэй агаарын хөлгийн даргаар, өдөр/шөнийн цагаар нислэгийн цаг хуримтлуулан ниссэн туршлагатай Монгол Улсын зэвсэгт хүчний алба хаагч этгээдийг дараах шаардлагыг хангасанд тооцож болно:

(1) энэ зүйлийн (а)(2);

(2) энэ зүйлийн (а)(3), хэрэв тухайн этгээд, агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 3 сард Монгол Улсын зэвсэгт хүчний хэрэглэлийн нислэгийн үнэлгээг амжилттай хийлгэсэн бол;

(3) энэ зүйлийн (а)(5), хэрэв тухайн этгээд, агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 5 жилд холбогдох нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг амжилттай өгсөн бол;

(4) энэ зүйлийн (а)(6).

3/ агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалт авахад зөвшөөрөгдсөн дадлагажуур байна.

4.1.2. агаарын хөлгийн даргын хяналтанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн 500 цаг, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн 250 цаг, үүний 70-аас багагүй цаг нь зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэг, үлдсэн цаг нь агаарын хөлгийн даргын хяналтан дор агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цаг байна;

4.1.3. алсын зайн нислэгийн 200 цаг, үүний 100-аас багагүй цаг нь агаарын хөлгийн даргаар эсхүл агаарын хөлгийн даргын хяналтанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цаг;

4.1.4. хэрэглэлийн нислэгийн 75 цаг, үүний 30 хүртэлх цаг нь хэрэглэлийн газрын цаг;

4.1.5. агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн шөнийн нислэгийн 100 цаг.

4.2.2. агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн

-AC61-7-д туссан

нислэгийн 250 цаг, үүний 70-аас багагүй цаг нь зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэг, үлдсэн цаг нь агаарын хөлгийн даргын хяналтан дор агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цаг байна;

4.2.3. алсын зайн нислэгийн 200 цаг, үүний 100-аас багагүй цаг нь агаарын хөлгийн даргаар эсхүл агаарын хөлгийн даргын хяналтанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цаг;

4.2.4. хэрэглэлийн нислэгийн 30 цаг, үүний 10 хүртэлх цаг нь хэрэглэлийн газрын цаг;

4.2.5. агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн шөнийн нислэгийн 50 цаг олон хөдөлгүүрт агаарын хөлөг байна; эсхүл

5.2 агаарын хөлгийн ашиглалтын талаарх ерөнхий мэдлэг: агаарын хөлгийн хүчний төхөөрөмжүүд; удирдлагын, даралтын, шингэний, цахилгааны болон бусад системийн техникийн үзүүлэлтүүд, тэдгээрийн ашиглалтын хязгаарлалтууд; нислэгийн болон навигацийн хэрэглэлүүдийн ажиллах зарчим, ашиглалтын хязгаарлалтууд; нислэг ашиглалтын болон бусад бичиг баримтанд тусгагдсан ашиглалтын холбогдолтой бусад мэдээлэл;

5.7 ашиглалтын журам: AIP, NOTAM зэрэг агаарын навигацийн бичиг баримт, товчлол ба тэмдэглэгээ; ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ ба ослын нөхцөлд ажиллах журмын ашиглалт; аюултай ачаа тээвэрлэх журам, зорчигчдод аюулгүй ажиллагааны талаар мэдээлэх журам;

5.9 Радио холбоо: радио холбоо барих журам ба ИХНЖ-аар үйлдэх нислэгийн хэллэг, холбоо тасарсан үед авах арга хэмжээ;

6.7 нислэгийн явцад нисэх багийн гишүүн хөдөлмөрийн чадвараа алдахад мөрдөх журам ба хяналтын хуудсыг ашиглах, багийн хамтын ажиллагаа болон нисгэгчийн ажлын ачааллыг хуваарилах зэргээр нисэх багийг

	<p><u>удирдан зохион байгуулах.</u></p> <p><u>2/ олон хөдөлгүүрт агаарын хөлөг байна; эсхүл</u></p> <p><u>(в) Энэ зүйлийн (а)-гийн 4/-ын (4.1) болон (4.2) -т шаардсан нислэгийн цагт, зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр гүйцэтгэсэн тухайн өргөдөл гаргагчийн нислэгийн цагаас, 100 хүртэлх цагийг нь тооцно. Үүний 25 хүртэлх цагийг нислэгийн ерөнхий дадлага өгөх дадлагажуур дээр гүйцэтгэсэн нислэгийн газрын цагийг тооцно.</u></p>	
ОС Бүлэг - Агаараас мэргэчийн хор цацах зэрэглэл

61.731. Нөхцөл хангах шаардлага

Нисгэгч нь агаараас мэргэчийн хор цацах зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) тохирох категорийн агаарын хөлгийн хувьд 2-р Зэргийн ХАА-н зэрэглэл эзэмшдэг байх;

(2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын

байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас мэрэгчийн хор цацах сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд зохион байгуулсан агаараас мэрэгчийн хор цацах үйл ажиллагааны газрын бэлтгэл сургалт болон нислэгийн зааварчилгаанаас бүрдсэн сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх;

(3) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас мэрэгчийн хор цацах ур чадварын үнэлгээ хийхийг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа E-Категорийн багш-нисгэгчид, эсхүл ХАА-н шалгагч-нисгэгчид агаараас мэрэгчийн хор цацах ур чадвараа амжилттай шалгуулсан байх.

61.733. Зэрэглэл олгох

(a) Хэрэв ИНД-61.731(3)-т шаардсан ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч нь тухайн нисгэгчийг 61.731-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл олгож, тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулж болно:

Би, (үнэлгээ хийсэн огноо) [нисгэгчийн нэр болон үйлчлүүлэгчийн дугаар] нь агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл (нисэх онгоц)* (нисдэг тэрэг)* олгоход тавих ИНД-61-ийн шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.

Зэрэглэл олгосон багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчийн нэр, гарын үсэг..... / /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

(* хамааралгүйг нь хасах)

(b) Агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхдээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэд агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэлийг

<p>баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.</p> <p>61.735. Эрх Тухайн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтаас хамааран, хүчинтэй ХАА-н зэрэглэл болон агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшигч нь агаараас мэрэгчийн хор цацах үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохирох категорийн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.</p> <p>61.737. Хүчинтэй байх шаардлага (a) Тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор ИНД-61.731(3)-ын дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан ба ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч, тухайн шалгалтыг амжилттай өгснийг нислэгийн дэвтэрт нь баталгаажуулснаас бусад тохиолдолд агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>(b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.</p> <p>61.739. ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн зохицуулалт (a) Энэ зүйл нь 2019 оны 7 сарын 30-наас өмнө олгосон хүчинтэй ХАА-н зэрэглэлд хамаарна.</p> <p>(b) Энэ зүйлд хамаарах зэрэглэл эзэмшдэг нисгэгч нь хэрэв хүчинтэй химийн зэрэглэл эзэмшдэг бол ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусах хүртэл 61.735-д заасан эрхийг хэрэгжүүлж болно.</p> <p>(c) Энэ дүрмийн 61.737(b)-д заасан, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ур чадварын шалгалтаа амжилттай өгсөн нисгэгчийг дараах шаардлага хангасанд тооцно: (1) 61.731(2)-ын шаардлага; (2) агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл олгох.</p>		
<p>P Бүлэг. Нисгэгчийн химийн зэрэглэл</p>	<p>P БҮЛЭГ. ХИМИЙН ЗЭРЭГЛЭЛ / PILOT CHEMICAL RATING</p>	
<p>61.751 Нөхцөл хангах шаардлага (a) Нисгэгч нь химийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p>	<p>61.751. Тавигдах шаардлага / Eligibility requirements (a) Химийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(1) тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй хувийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;</p> <p>(2) дараах эрхийн хүрээнд хийсэн ХАА-н химийн бодис хэрэглэх сургалтын курсийг амжилттай дүүргэж, үнэлгээ хийлгэсэн байх:</p> <p>(i) гэрчилгээ нь үйл ажиллагаа эрхлэгчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний; эсхүл</p> <p>(ii) гэрчилгээ нь байгууллагад тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний.</p>	<p>1/ зохих агаарын хөлгийн ангиллын хувьд хувийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;</p> <p>2/ хөдөө аж ахуйн химийн бодисын талаар сургалтанд хамрагдсан байх.</p>	<p>-Amend.11-ээр нэмэгдсэн</p>
<p>61.753 Зэрэглэл олгох</p> <p>(a) Хэрэв тухайн нисгэгч 61.751-ийн нөхцөл хангах шаардлагыг хангасан бол, 61.751-д шаардсан үнэлгээ хийсэн этгээд нь нисгэгчийн химийн зэрэглэл олгож, 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулж болно:</p> <p>Би [нисгэгчийн нэр] нь ИНД-61-д заасан нисгэгчийн химийн зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон химийн зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхдээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.</p> <p>(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэд химийн зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.</p>	<p>61.753. Зэрэглэл олгох / Issue</p> <p>(a) Өргөдөл гаргагчийг энэ дүрмийн 61.751-д заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл, 61.751-д заасны дагуу шаардагдах шалгалт авсан эрх бүхий этгээд энэ дүрмийн 61.29-д заасны дагуу дараах тэмдэглэлийг нислэгийн дэвтэрт нь хийн, химийн зэрэглэл олгож болно:</p> <p>[.....овогтой] нь ИНД-61-д заасан химийн зэрэглэл олгоход тавигдах шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.</p> <p>..... /гарын үсэг/ ... он ... сар ... өдөр</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасны дагуу химийн зэрэглэл эзэмшигч нь ИНЕГ–ын даргад хүсэлт гарган химийн зэрэглэлээ нисгэгчийн үнэмлэхэндээ тэмдэглүүлж болно.</p>	
<p>61.755 Эрх</p> <p>Хүчинтэй нисгэгчийн химийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид ИНД-137-гийн дагуу ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд агаарын хөлгөөс ХАА-н химийн бодис цацах эрхийг олгоно.</p>	<p>61.755. Эрх, хягаарлалт / Privileges and limitations</p> <p>(a) Хүчин төгөлдөр химийн зэрэглэл нь ИНД-137-т заасны дагуу хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн химийн бодис хаях эрх олгоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>61.757 Хүчинтэй байх шаардлага</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн</p>	<p>61.757. Ур чадварын хадгалалтад тавигдах шаардлага / Currency requirements</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд химийн</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>зэрэглэл олгосноос хойш 5 жилийн дараа, дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийн химийн зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн эзэмшигч нь өмнөх 5 жилийн дотор Даргын хүлээн зөвшөөрөхүйц сэргээх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх;</p> <p>(2) тухайн сургалтын холбогдох бүртгэлийг 61.29-ийн дагуу нисгэгчийн дэвтэртээ бичиж тэмдэглүүлсэн байх.</p> <p>(b) Шаардсан өдрөөс өмнө 90 хоногийн дотор энэ зүйлийн (a)-д шаардсан сэргээх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн нисгэгчийг тухайн сургалтын курсийг хугацаанд нь дүүргэсэнд тооцно.</p>	<p>зэрэглэлтэй этгээд зэрэглэл авснаас хойш 3 жилийн дараа, дараах шаардлагыг хангаагүй бол уг зэрэглэлээр олгогдох эрхийг эдлэхгүй:</p> <p>1/ өмнөх 3 /гурав/ жилийн хугацаанд ИНЕГ-ын хүлээн зөвшөөрсөн давтан сургалтанд хамрагдсан байх;</p> <p>2/ энэ дүрмийн 61.29-ын дагуу бүртгэл нислэгийн дэвтэртээ тэмдэглүүлсэн байх.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд давтан сургалтанд хамрагдах өдрөөс 90 хоногийн өмнө хамрагдсан бол цаг хугацаанд нь хамрагдсанд тооцно.</p>	<p>-“3 жил” гэснийг “5 жил” гэж өөрчлөгдсөн</p>
<p>Q Бүлэг. Хэрэглэлийн зэрэглэл</p>	<p>С БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛИЙН НИСЛЭГИЙН ЗЭРЭГЛЭЛ / INSTRUMENT RATINGS</p>	
<p>61.801 Нөхцөл хангах шаардлага</p> <p>(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд хэрэглэлийн зэрэглэл (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг) эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, шөнийн нислэг үйлдэх эрх бүхий хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;</p> <p>(2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн цагийн туршлагатай байх;</p> <p>(3) дараах сэдвээр газрын бэлтгэл сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:</p> <p>(i) нисэхийн хууль дүрэм: IFR-ийн дагуу үйлдэх нислэгтэй холбоотой дүрэм, журам; нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй холбоотой практик</p>	<p>61.801. Тавигдах шаардлага / Eligibility requirements</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд онгоцны буюу нисдэг тэрэгний хувьд хэрэглэлийн нислэгийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх ба зохих агаарын хөлгийн ангиллын хувьд шөнийн нислэг үйлдэх эрхтэй байх;</p> <p>2/ нислэгийн дараах дадлага туршлагатай байна:</p> <p>2.1 зохих ангиллын агаарын хөлөг дээр агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн алсын зайн 50 цагийн нислэг үйлдсэн;</p> <p>2.2 хэрэглэлийн газрын 20-оос ихгүй цагийг багтаасан 40 цагийн хэрэглэлийн нислэг үйлдсэн, эсхүл зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр багш нисгэгчийн хяналтад 30 цагийн хэрэглэлийн нислэг үйлдсэн.</p> <p>3/ дараах сэдвүүдийг багтаасан газрын бэлтгэл сургалтанд амжилттай хамрагдсан байна:</p> <p>3.1 нисэхийн хууль тогтоомж: ХНД-холбогдсон дүрэм, журам, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний журам; ХНД-ээр үйлдэх нислэгт</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

хэрэглээ болон журам; IFR-ийн дагуу үйлдэх нислэгтэй холбоотой нислэгийн өмнөх бэлтгэл болон үзлэг; нислэгийн үйл ажиллагааны төлөвлөлт; IFR-ийн дагуу үйлдэх нислэгийн төлөвлөгөөг бэлтгэх болон бүрдүүлэх; өндөр хэмжигчийг тохируулах журам; AIP, NOTAM, нисэхийн код болон товчлол зэрэг нисэхийн бичиг баримтын тайлбар болон хэрэглээ, нисэн гарах, нислэгийн замын дагуух, өндөр алдах болон ойртолт үйлдэхэд зориулсан хэрэглэлийн журмын нислэгийн зураг; урьдчилан сэргийлэх болон онцгой нөхцөлийн журам; IFR-ийн дагуу үйлдэх нислэгтэй холбоотой аюулгүй байдлын практик дадлага; IFR-ийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаанд хэрэглэдэг радио-холбооны журам болон фразеолог/стандарт хэллэг; холбоо ажилгүй болсон үед авах арга хэмжээ;

(ii) нислэгийн навигаци-IFR: радио навигацийн туслах төхөөрөмж ашиглан агаарын навигаци хийх практик дадлага; нисэн гарах, нислэгийн замын дагуух ойртолт болон буулт үйлдэх нислэгийн үе шатанд навигацийн систем ашиглах, түүний нарийвчлал болон найдвартай ажиллагаа; радио навигацийн туслах төхөөрөмжийг таньж тогтоох;

(iii) цаг уур: нисэхийн цаг уурын тайлан мэдээ, нислэгийн зураг болон цаг уурын урьдчилсан мэдээг тайлж унших болон ашиглах; нислэгийн өмнө ба нислэгийн үед цаг уурын мэдээ авах журам ба түүнийг ашиглах; өндөр хэмжих; нисэхийн цаг уур судлал; тухайн бүс нутгийн нислэгт нөлөөлж болзошгүй элементийг хамарсан цаг агаар судлал; хөөрөлт, нислэгийн замын дагуух болон буултын нөхцөлд нөлөөлж болох даралтын системийн хөдөлгөөн, фронтын бүтэц болон цаг агаарын онцгой аюултай үзэгдлийн үүсэл, тэдгээрийн шинж чанар; цаг агаарын аюултай нөхцөлөөс зайлсхийх;

хамаарах нислэгийн өмнөх бэлтгэл, шалгалт; нислэгийн төлөвлөгөө; ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд нислэгийн төлөвлөгөөний бэлтгэл ажил; өндөр хэмжигч тохируулах журам; AIP, NOTAM, аэронавтикийн код болон товчлол зэрэг бичиг баримтын ашиглалт; ХНД-ээр хөөрөлт, чиг шулуун нислэг, өндөр алдах, ойртолт үйлдэх зураглалууд; онцгой нөхцөл байдал буюу онцгой тохиолдлын журмууд; ХНД-д хамаарах аюулгүй ажиллагааны зарчим; ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлөгтэй радио холбоо барих журам, нислэгийн холбооны хэллэг; холбоо гэмтсэн буюу ажиллагаагүй болсон тохиолдолд авах арга хэмжээ;

3.2 нислэгийн навигаци-ХНД: агаарын навигаци; хөөрөлт, чиглэлийн нислэг, ойртолт, буулт зэрэг нислэгийн үе шатуудад навигацийн системийг ашиглах, түүний нарийвчлал, найдвартай байдал; радио навигацийн төхөөрөмжүүд;

3.3 цаг уур: аэронавтикийн цаг уурын тайлан мэдээлэл, хүснэгт буюу зураглал, цаг уурын урьдчилсан мэдээ ашиглах; нислэгийн өмнө ба нислэгийн үед, өндрийн нислэгт цаг уурын мэдээ авах журам, түүнийг ашиглах; аэронавтикийн цаг уур судлал, агаарын хөлгийн нислэгт нөлөө үзүүлж буй элементүүдэд хамаарах нутаг дэвсгэрийн цаг агаар судлал; даралтын системийн хөдөлгөөн, түүний бүтэц, хөөрөлт, чиглэлийн нислэг, буулт зэрэг нислэгийн үе шатуудад нөлөөлж болох цаг агаарын онцгой үзэгдлийн үүсэл, тэдгээрийн шинж чанар, цаг агаарын аюултай нөхцөлөөс зайлсхийх;

Орчуулга, найруулга
зассан

<p>(iv) хэрэглэлийн болон навигацийн туслах төхөөрөмж: IMC-д болон IFR-ийн дагуу нислэг үйлдэх агаарын хөлгийн хяналт, навигацид шаардлагатай авионик болон хэрэглэл ашиглах, тэдгээрийн хязгаарлалт, ажиллагаатай байдал; автопилотын хэрэглээ болон түүний хязгаарлалт; компас, түүний эргэлтийн болон заалтын хурдны алдаа; гироскопын хэрэглэл, түүний ашиглалтын хязгаарлалт болон нарийвчлалын нөлөө; хэд хэдэн нислэгийн хэрэглэл доголдолтой ажиллах үед мөрдөх журам ба дадлага;</p> <p>(v) хүний хүчин зүйл: хүний боломж болон хязгаарлалт.</p> <p>(4) <u>тохирох категорийн агаарын хөлгөөр, зохих ёсоор мэргэшсэн</u> багш-нисгэгчийн зохион байгуулсан, дараах сэдвийг багтаасан минимум 10 цагийн хосолсон нислэгийн зааварчилгаатай нислэгийн сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:</p> <p>(i) нислэгийн заавар, эсхүл дүйцэх баримт бичиг болон IFR-ийн нислэгийн төлөвлөгөөг бэлтгэхтэй холбоотой нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний баримт бичгийг ашиглах журмыг багтаасан нислэгийн өмнөх журам;</p> <p>(ii) нислэгийн өмнөх үзлэг, шалгах хуудсыг ашиглах, явгалалт болон хөөрөлтийн өмнөх үзлэг;</p> <p>(iii) хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийг хамарсан IFR-ийн нислэгийн үеийн журам болон маневр үүнд: хөөрөлтийн үед хэрэглэлийн нислэгт шилжих; нисэн гарах болон нисэн ирэх стандарт хэрэглэлийн журам; нислэгийн замын дагуух IFR-ийн журам; хүлээлтийн журам; тодорхой өгөгдсөн минимал хүртэл хэрэглэлийн ойртолт үйлдэх; ойртолтоос 2-т гарах журам (missed approach procedure); хэрэглэлийн ойртолтоос буулт үйлдэх зэргийг багтаасан;</p>	<p>3.4 хэрэглэлийн болон навигацийн төхөөрөмж: ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн хяналт, навигацид шаардлагатай <u>хэрэглэлүүдийн</u> ашиглалт, хязгаарлалт, ашиглалтанд тэнцэх байдал ба хэрэглэлийн нислэгийн цаг агаарын нөхцлийн үед тэдгээрийг ашиглах; автомат жолоодлого, луужин ашиглах, эргэлт болон хурдатгалын алдаа, тэдгээрийн хязгаар; гироскоп хэрэглэлүүд, тэдгээрийн ашиглалтын хязгаарлалт; навигацийн хэд хэдэн хэрэглэлийн алдаатай ажиллагааны үед мөрдөх журам;</p> <p>3.5 хүний хүчин зүйл: хүний боломж ба хязгаарлалт.</p> <p>4/ эрх бүхий багш нисгэгчээс дараах зүйлийг багтаасан 10-аас доошгүй цагийн хосолсон нислэгийн зааварчилга авсан байна:</p> <p>4.1 ХНД-ээр үйлдэх нислэгт хамаарах бичиг баримт, нислэгийн заавруудыг ашиглах, ХНД-ийн нислэгийн төлөвлөгөөтэй нислэг хөдөлгөөний үйлчилгээтэй холбоотой бичиг баримтын өмнөх бэлтгэл;</p> <p>4.2 нислэгийн өмнөх үзлэг; шалгах хуудсуудыг нислэгийн холбогдох үе шатанд ашиглах</p> <p>4.3 дараах зүйлийг хамарсан ХНД-ээр үйлдэх нислэгийн үе дэх хэвийн, хэвийн бус болон онцгой тохиолдлын журмууд: хөөрөлтийн үед хэрэглэлийн нислэгт шилжих, хэрэглэлийн стандарт гаралт, оролт; чиг шулуун нислэгийн ХНД; нислэгийн хүлээх журам; тодорхой өгөгдсөн минимум хувьд хэрэглэлийн ойртолтын тухай; ойртолтоос 2 дугаар хайрцагт гарах журам; хэрэглэлийн ойртолтоор буулт үйлдэх;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- “нислэгийн чанар” гэснийг “нислэгийн үзүүлэлт” гэж</p> <p>-“жолоодлого” гэснийг “маневр” гэж</p>
--	---	--

<p>(iv) нислэгийн үеийн маневр болон тодорхой <u>нислэгийн үзүүлэлт</u>;</p> <p>(v) олон хөдөлгүүртэй агаарын хөлгийн хувьд, нэг хөдөлгүүр ажиллагаагүй болсон, эсхүл ажиллагаагүй болсон нөхцөлийг зохиомлоор үүсгэсэн үед зөвхөн хэрэглэл ашиглан агаарын хөлгийг удирдах;</p> <p>(5) энэ зүйлийн (a)(3)-т заасан <u>сэдвээр зөвшөөрөгдсөн</u> бичгийн шалгалтыг хамарсан бичгийн шалгалтын хүчинтэй, эсхүл <u>зөвшөөрөгдсөн дүйцэх кредиттэй байх</u>;</p> <p>(6) Даргад (тохирох агаарын хөлөг, эсхүл зөвшөөрөгдсөн синтетик дадлагажуур дээр нислэгийн шалгалт өгч) хүсэлт гаргагчийн шалгуулж байгаа навигацийн системтэй хамааралтай, энэ зүйлийн (a)(4)-т заасан журам, маневр болон үйл ажиллагааг гүйцэтгэх ур чадвар болон дараах ур чадвараа амжилттай шалгуулсан байх:</p> <p>(i) агаарын хөлгөөр түүний хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа эрхлэх;</p> <p>(ii) бүх <u>маневрыг</u> жигд, нямбай гүйцэтгэх;</p> <p>(iii) оновчтой шийдвэр гаргах болон нисгэгчийн ур чадвар;</p> <p>(iv) <u>нисэхийн</u> мэдлэгээ ашиглах;</p> <p>(v) бүх нислэгийн туршид нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлийг бататгах хэлбэрээр тухайн агаарын хөлгийг итгэлтэйгээр удирдах.</p> <p>(b) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хязгаарлалтгүй дүйцэх зэрэглэл эзэмшигч нь хэрэглэлийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) энэ зүйлийн (a)(3)(i)-ийн дагуу тогтоосон нисэхийн хууль, дүрмийн сэдвээр бичгийн шалгалтын кредиттэй байх;</p> <p>(2) энэ зүйлийн (a)(6)-д шаардсан нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.</p> <p><u>(c) Монгол Улсын зэвсэгт хүчний хэрэглэлийн зэрэглэл</u></p>	<p>4.4 нислэгийн үе дэх маневр, зарим <u>нислэгийн чанарууд</u>;</p> <p>4.5 олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд нэг хөдөлгүүр ажиллахгүй байх үед зөвхөн хэрэглэл ашиглан агаарын хөлгийн үйл ажиллагааг удирдах чадвар;</p> <p>5/ энэ зүйлийн (a) 3/-т заасан сэдвүүдийг багтаасан, бичгийн шалгалт өгсөн байна;</p> <p>6/ энэ зүйлийн (a) 4/-т заасан журам, маневр, үйлдэлийг чадварлаг гүйцэтгэх ур чадвараа (тохирох агаарын хөлөг, эсхүл дадлагажуур дээр нислэгийн шалгалт гүйцэтгэн), мөн навигацийн системийг ашиглах дараах чадваруудаа ИНЕГ-ын даргад үзүүлнэ.</p> <p>6.1 агаарын хөлгийг түүний ашиглалтын хязгаарлалтын хүрээнд ажиллуулах чадвар;</p> <p>6.2 бүх <u>жолоодлогыг</u> анхааралтай, жигд гүйцэтгэх;</p> <p>6.3 бодит байдалд цаг алдалгүй шийдвэр гаргах буюу кредит өгч, нисэх багийн гишүүдтэй холбоо сайтай байх;</p> <p>6.4 <u>аэронавтикийн</u> мэдлэгээ ашиглах;</p> <p>6.5 тухайн агаарын хөлгийг нислэгийн бүх хугацаанд өөртөө итгэлтэй жолоодох.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон хэрэглэлийн нислэгийн зэрэглэлтэй бол дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ энэ зүйлийн (a)(3)(3.1)-т заасан нисэхийн хууль тогтоомжийн шалгалтыг бичгээр өгсөн байх;</p> <p>2/ энэ зүйлийн (a)(5)-д заасан нислэгийн шалгалт өгсөн байх.</p>	<p>-“аэронавтик” гэснийг “нисэх” гэж</p> <p>Amend.11-ээр нэмэгдсэн</p>
--	--	--

<p>эзэмшдэг бөгөөд хэрэглэлийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас 3 сарын өмнө Монгол Улсын зэвсэгт хүчний хэрэглэлийн нислэгийн дүгнэлтийг амжилттай хийлгэсэн этгээдийг энэ зүйлийн (а)(2) (а)(6) хүртэлх нөхцөл хангах шаардлагыг хангасанд тооцно.</p>		
<p>61.803 Зэрэглэл олгох (a) Хэрэглэлийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч 61.801-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, Дарга тухайн нисгэгчийн үнэмлэхэд баталгаажуулсан тэмдэглэл хийн, зэрэглэл олгож болно. (b) Хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч нь ойртолтын нэмэлт туслах төхөөрөмж, эсхүл системийн баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхдээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно. <u>(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэд ойртолтын нэмэлт туслах төхөөрөмжийн, эсхүл системийн баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.</u></p>	<p>61.803. Зэрэглэл олгох / Issue (a) Өргөдөл гаргагчийг энэ дүрмийн 61.801-д заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл ИНЕГ–ын дарга тухайн нисгэгчийн үнэмлэх дээр тэмдэглэл хийн, зэрэглэл олгоно. (б) Хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч нь ИНЕГ–ын даргад хүсэлт гарган нэмэлт ойртолтын төхөөрөмж, эсхүл системийн тэмдэглэл нисгэгчийн үнэмлэхэндээ тэмдэглүүлж болно.</p>	<p>Amend.11-ээр нэмэгдсэн</p>
<p>61.805 Эрх, хязгаарлалт (a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид, IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохирох агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх эрхийг олгоно. (b) <u>Хэрэглэлийн</u> зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд түүнийг эзэмшигч нь дараах үүрэгтэй: (1) ганц - нисгэгчтэй агаарын хөлгийн хувьд, 61.801 (a)(6), эсхүл 61.801(c)-д шаардсан ганц нисгэгчийн үйл ажиллагааны стандартын дагуу нислэгийн шалгалтыг <u>амжилттай өгсөн</u> байх; (2) гол тэнхлэгийн шугамын дагуу бус татах хүчтэй, олон хөдөлгүүртэй нисэх онгоцны хувьд, 61.801(a)(6), эсхүл 61.801(c)-д шаардсан нислэгийн шалгалтыг, гол тэнхлэгийн шугамын дагуу бус татах хүчтэй, олон хөдөлгүүртэй нисэх онгоцоор амжилттай өгсөн байх; (3) хэрэв тухайн эзэмшигч нь IFR-ийн дагуу, хэрэглэлийн ойртолтын үйлдэх журмыг ашиглаж байгаа бол, шалгагч-нисгэгч тухайн эзэмшигч ойртолтын <u>туслах</u></p>	<p>61.805. Эрх, хязгаарлалт / Privileges and limitations (a) Энэ зүйлийн (б)-г харгалзан үзсэнээр, хэрэглэлийн нислэгийн зэрэглэл эзэмшигч нь ХНД-ээр үйлдэх нислэгт агаарын хөлгийн хамтран нисгэгч, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх эрхтэй. (б) Дараах тохиолдолд хэрэглэлийн <u>нислэгийн</u> зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээр олгогдох эрхийг эдлэнэ: 1/ нэг нисгэгчтэй агаарын хөлгийн хувьд нэг нисгэгчийн үйл ажиллагааны стандартын дагуу 61.801 (a)(6), эсхүл 61.801(в)(1)-д заасан нислэгийн шалгалтыг <u>өгсөн</u> байх; 2/ хөдөлгүүрүүд нь агаарын хөлгийн гол тэнхлэг дагуу байрлаагүй, олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд 61.801(a)(6), эсхүл 61.801(в)(1)-д заасан нислэгийн шалгалтыг өгсөн байх; 3/ ХНД-ийн дагуу хэрэглэлийн тусламжтайгаар ойртолт үйлдэх нислэгийн хувьд ойртолтын төхөөрөмж буюу системийн талаарх ур чадварын</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>төхөөрөмж, эсхүл системийн ур чадвараа амжилттай шалгуулсныг тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх;</p> <p>(4) хэрэв тухайн эзэмшигч нь зөвхөн 2-р ангиллын ЭМГ эзэмшдэг бол, ИНД-67-д заасан 1-р ангиллын сонсголын шаардлагыг хангасан байх ёстой ба 2-р ангиллын ЭМГ-нд баталгаажуулсан тэмдэглэл хийлгэсэн байх.</p>	<p>шалгалтыг амжилттай өгсөн тухай тэмдэглэлийг шалгах-нисгэгч, нислэгийн дэвтэрт нь хийсэн байх;</p> <p>4/ 2 дугаар ангиллын эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд ИНД-67-гийн дагуу 1 дүгээр ангиллын эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшигчийн сонсголд тавигдах шаардлагыг хангасан байх.</p>	
<p>61.807 Хүчинтэй байх шаардлага</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг хангаагүй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>(1) өмнө үргэлжилсэн 12 сарын дотор:</p> <p>(i) тохирох категорин агаарын хөлгийн хувьд, 61.801(a)(6)-гийн дагуу шалгагч-нисгэгчид, ур чадвараа амжилттай шалгуулсан байх;</p> <p>(ii) ур чадварын шалгалт авсан этгээд нь, ур чадварын шалгалтаа амжилттай өгснийг 61.29-ийн дагуу нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх;</p> <p>(2) өмнө үргэлжилсэн 3 сарын дотор:</p> <p>(i) энэ зүйлийн (a)(1)-ийн шаардлагыг хангасан, эсхүл 3-аас доошгүй хэрэглэлийн цагийг хуримтлуулсан байх (үүний 1-ээс доошгүй цаг нь хэрэглэлийн нислэгийн цаг байх ёстой);</p> <p>(ii) 3-аас доошгүй удаа хэвлэн нийтэлсэн хэрэглэлийн ойртолтын үйлдэх журмыг гүйцэтгэсэн байх (үүний 1 нь зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн байж болно);</p> <p>(3) хэрэв гол тэнхлэгийн шугамын дагуу бус татах хүчтэй олон - хөдөлгүүртэй агаарын хөлгийн нисгэгчийн үүргийг IFR-ийн дагуу гүйцэтгэх бол энэ зүйлийн (a)(1)-д шаардсаны дагуу ур чадварын шалгалтыг гол тэнхлэгийн шугамын дагуу бус татах хүчтэй олон-хөдөлгүүртэй агаарын хөлгөөр амжилттай өгсөн байх;</p> <p>(4) хэрэв IFR-ийн дагуу хэрэглэлийн ойртолтын үйлдэх</p>	<p>61.807. Ур чадварын хадгалалтад тавигдах шаардлага / Currency requirements</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд хэрэглэлийн зэрэглэлтэй этгээд нь дараах шаардлагыг хангаагүй бол уг зэрэглэлээр олгогдох эрхийг эдлэхгүй:</p> <p>1/ өмнөх 12 сарын хугацаанд:</p> <p>1.1 энэ дүрмийн 61.801(a)(6)-д заасан шаардлагын дагуу ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн байх;</p> <p>1.2 энэ дүрмийн 61.29-ын дагуу эрх бүхий этгээдээр ур чадварын шалгалтын амжилттай гүйцэтгэсэн кредит нислэгийн дэвтэртээ тэмдэглүүлсэн байх;</p> <p>2/ өмнөх 3 сарын хугацаанд:</p> <p>2.1 энэ зүйлийн (a)1/-т заасан шаардлагыг хангасан, эсхүл 3-аас доошгүй хэрэглэлийн цаг, үүний 1-ээс доошгүй цаг нь хэрэглэлийн нислэгийнх байх;</p> <p>2.2 3-аас доошгүй удаа ХНД-ээр ойртолт үйлдсэн байх (үүний 1 нь зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр байж болно);</p> <p>3/ хөдөлгүүрүүд нь агаарын хөлгийн гол тэнхлэг дагуу байрлаагүй олон хөдөлгүүрт агаарын хөлгөөр нислэг үйлдэх гэж байгаа бол энэ зүйлийн (a)1/-т заасан шаардлагын дагуу ур чадварын шалгалтыг өгсөн байх;</p> <p>4/ 3 сарын хугацаанд нислэгийн үед, эсхүл</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>журмыг ашиглах бол, өмнө үргэлжилсэн 3 сарын дотор, нислэгт, эсхүл зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуур дээр төстэй маягийн навигацийн системийг ашиглан хэвлэн нийтэлсэн хэрэглэлийн ойртолтын ойртолт үйлдэх журмыг гүйцэтгэсэн байх;</p> <p>(5) хэрэв ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд, IFR-ийн үйл ажиллагаа эрхлэх бол, ИНД-121, 125, эсхүл 135-ын IFR -ийн ур чадварын шаардлагын аль хамааралтайг нь хангасан байх.</p> <p>(b) Хэрэв тухайн агаарын хөлөг нь арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгээгүй бол, энэ зүйлийн (a)(2)-ын шаардлагыг хангаагүй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч нь, IFR-аар нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.</p> <p>(c) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор энэ зүйлийн (a)(1)-д шаардсан шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг хугацаанд нь өгсөнд тооцно.</p>	<p>зөвшөөрөгдсөн дадлагажуур дээр ижил маягийн навигацийн системийг ашиглан ХНД-ээр ойртолт үйлдсэн бол;</p> <p>5/ ИНД-119-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн эрх мэдлийн хүрээнд ХНД-ээр нислэг үйлдэгдэж байгаа бол ИНД-121-ийн шаардлагын дагуу ХНД-ийн ур чадвараа шалгуулсан байх.</p> <p>(b) Хэрэв агаарын хөлөг агаарт үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд хэрэглэлийн нислэгийн зэрэглэл эзэмшигч нь энэ зүйлийн (a) 2/-т заасан шаардлагыг хангаагүй бол ХНД-ийн нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн туслах нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)1/-т заасан шаардлагыг биелүүлэхийн тулд ур чадварын шалгалтаа өгөх өдрөөс 60 хоногийн өмнө ур чадвараа шалгуулсан бол цаг хугацаанд нь шалгуулсанд тооцно.</p>	
<p>R Бүлэг. Нөөц</p>	<p>T БҮЛЭГ. НӨӨЦ / RESERVED</p>	
<p>S Бүлэг. Шалгагч-нисгэгчийн зэрэглэл</p>	<p>У БҮЛЭГ. ШАЛГАХ-НИСГЭГЧИЙН ЗЭРЭГЛЭЛ /FLIGHT EXAMINER RATINGS</p>	
<p>61.901 Нөхцөл хангах шаардлага</p> <p>(a) Агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</p> <p>(1) ИНД-125 болон ИНД-135-ын дагуух үйл ажиллагааны хувьд, тохирох коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;</p> <p>(2) ИНД-121-ийн дагуух үйл ажиллагааны хувьд, агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх (нисэх онгоц) эзэмшдэг байх;</p> <p>(3) хүчинтэй А, В, эсхүл D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;</p> <p>(4) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн туршлагатай байх;</p> <p>(5) агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэх ур чадвараа Даргад амжилттай шалгуулсан байх.</p> <p>(6) агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл</p>	<p>61.901. Тавигдах шаардлага / Eligibility requirements</p> <p>(a) Агаарын тээвэрлэгчийн шалгах-нисгэгчийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ ИНД-135-д заасан үйл ажиллагаанд оролцвол коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй байх;</p> <p>2/ ИНД-121-д заасан үйл ажиллагаанд оролцвол агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй байх;</p> <p>3/ “А”, “В”, эсхүл “С” ангиллын багш нисгэгчийн хүчин төгөлдөр зэрэглэлтэй байх;</p> <p>4/ ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөх нислэгийн дадлагатай байх;</p> <p>5/ агаарын тээвэрлэгчийн шалгах-нисгэгчийн үүрэг гүйцэтгэх ур чадвараа ИНЕГ-ын даргад шалгуулсан байх.</p>	

эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хугацаанд, зөвшөөрөгдсөн шалгагч-нисгэгчийн сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх.

(b) Ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших, эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) тохирох А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;

(2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн туршлагатай байх;

(3) ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэх ур чадвараа Даргад амжилттай шалгуулсан байх;

(4) ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц хугацаанд, зөвшөөрөгдсөн шалгагч-нисгэгчийн сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх.

(c) ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) тохирох, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;

(2) тохирох, хүчинтэй Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;

(3) дараах цагийг багтаасан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн цагийн туршлагатай байх:

(i) нийт нислэгийн цаг;

(ii) хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цаг;

(iii) агаараас бордоо цацсан нислэгийн цаг, хэрэв хамааралтай бол;

(iv) агаараас шингэн цацсан нислэгийн цаг, хэрэв хамааралтай бол;

(v) агаараас мэрэгчийн хор цацсан нислэгийн цаг, хэрэв хамааралтай бол;

(vi) нислэгийн зааварчилгаа өгсөн цаг;

(4) тухайн этгээд нь ХАА-н шалгагч-нисгэгчийн үүргийг

(б) Ерөнхий зориулалтын нисэхийн шалгах-нисгэгчийн зэрэглэл авахаар өргөдөл гаргагч дараах шаардлагыг хангасан байна:

1/ “А” ангиллын багш нисгэгчийн зэрэглэлтэй байх;

2/ ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөх нислэгийн дадлагатай байх;

3/ Ерөнхий зориулалтын нисэхийн шалгах-нисгэгчийн үүрэг гүйцэтгэх ур чадвараа ИНЕГ-ын даргад шалгуулсан байх.

-Amend.11-ээр өөрчлөгдсөн

-Amend.11-ээр нэмэгдсэн

<p>гүйцэтгэх чадвараа Даргад амжилттай шалгуулсан байх; (5) ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хугацаанд шалгагч-нисгэгчийн зөвшөөрөгдсөн сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх.</p>		
<p>61.903 Зэрэглэл олгох Хэрэв Дарга шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь 61.901-ийн холбогдох шаардлага хангасан гэж үзвэл, Дарга хүсэлт гаргагчийн нисгэгчийн үнэмлэхэд тэмдэглэл хийн зэрэглэл олгох ба тухайн нисгэгчийн дэвтэрт холбогдох шалгагч-нисгэгчийн эрхийн тэмдэглэл хийж болно.</p>	<p>61.903. Зэрэглэл олгох / Issue (a) Өргөдөл гаргагч энэ дүрмийн 61.901-ийн шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл ИНЕГ-ын дарга тухайн нисгэгчийн үнэмлэх дээр зэрэглэлийн тэмдэглэл хийж өгнө. Мөн шалгах-нисгэгч дээрх шаардлагыг хангасан гэж үзвэл өргөдөл гаргагчийн нислэгийн дэвтэр дээр тэмдэглэл хийн зэрэглэл олгоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>61.905 Эрх, хязгаарлалт Агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл (a) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй агаарын тээврийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь энэ Дүрмээр шаардсан нисгэгчийн үнэмлэх олгох, эсхүл зэрэглэл олгох, эсхүл сунгах, эсхүл үйл ажиллагааны ур чадварын үнэлгээ хийх зорилгоор Даргын олгосон зөвшөөрлийн дагуу дараах гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын хүрээнд нислэгийн шалгалт авч болно: (1) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл (2) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол. Ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл (b) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь энэ Дүрмээр шаардсан нисгэгчийн үнэмлэх олгох, эсхүл зэрэглэл олгох, эсхүл сунгах, эсхүл үйл ажиллагааны ур чадварын үнэлгээ хийх зорилгоор нисдэг тэрэг болон 9, эсхүл түүнээс цөөн гэрчилгээжсэн</p>	<p>61.905. Эрх, хязгаарлалт / Privileges and limitations Агаарын тээвэрлэгчийн шалгах нисгэгч (a) Энэ зүйлийн (г)-г харгалзан үзсэнээр, ИНЕГ-ын дарга зөвшөөрөл олговол Агаарын тээвэрлэгчийн шалгах-нисгэгч нь энэ дүрмийн дагуу үнэмлэх буюу зэрэглэл олгох, эсхүл үнэмлэх шинэчлэх болон үйл ажиллагааны ур чадварын кредит өгөхтэй холбогдсон нислэгийн шалгалтыг дараах байгууллагуудын удирдлага дор гүйцэтгэх эрхтэй: 1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, нислэгийн шалгалт авах эрхтэй нисэхийн сургалтын байгууллага; эсхүл 2/ ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн нислэгийн шалгалт авах эрхтэй агаарын тээвэрлэгч. Ерөнхий зориулалттай нисэхийн шалгах-нисгэгч (b) Энэ зүйлийн (г)-г харгалзан үзсэнээр, ИНЕГ-ын дарга зөвшөөрөл олговол Ерөнхий зориулалттай нисэхийн шалгах-нисгэгч нь энэ дүрмийн дагуу үнэмлэх буюу зэрэглэл олгох, эсхүл үнэмлэх шинэчлэх, эсхүл нисдэг тэрэгний үйл ажиллагааны ур чадварыг дүгнэхтэй холбогдсон шалгалт, нисгэгчийн суудлаас гадна 9-өөс</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

зорчигчийн суудлын багтаамжтай **нисэх** онгоцны хувьд, **Даргын** олгосон зөвшөөрлийн дагуу дараах гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын хүрээнд нислэгийн **шалгалт** авч болно:

(1) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, **хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол;** эсхүл

(2) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, хэрэв **гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол;** эсхүл

(3) тухайн нислэгийн шалгалт авахаар Даргын шилжүүлсэн эрх эзэмшдэг этгээдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр авч ажиллуулж байгаа.

ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл

(ba) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь энэ **Дүрмээр шаардсан зэрэглэл олгох, эсхүл сунгах, эсхүл үйл ажиллагааны үр чадварын үнэлгээ хийх зорилгоор Даргын олгосон зөвшөөрлийн дагуу дараах байгууллагын хүрээнд нислэгийн шалгалт авч болно:**

(1) **гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа;** эсхүл

(2) **гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа;** эсхүл

(3) **тухайн нислэгийн шалгалт авахаар Даргын шилжүүлсэн эрх эзэмшдэг этгээдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр, авч ажиллуулж байгаа.**

Хязгаарлагдмал эрхтэй **шалгагч-нисгэгчийн зэрэглэл**

(c) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй хязгаарлагдмал эрхтэй **шалгагч**-нисгэгчийн зэрэглэлтэй тухайн эзэмшигч нь **Даргын** олгосон зөвшөөрлийн эрхийг, тухайн нислэгийн

дээшгүй зорчигчийн суудал бүхий онгоцны хувьд үйл ажиллагааны үр чадварыг дүгнэхтэй холбогдсон нислэгийн шалгалтыг дараах байгууллагуудын удирдлага дор **гүйцэтгэх** эрхтэй:

1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нислэгийн шалгалт авах эрхтэй нисэхийн сургалтын байгууллага; эсхүл

2/ ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн нислэгийн шалгалт авах эрхтэй; эсхүл

3/ дээрх шалгалтыг авах эрхтэй, ИНЕГ–ын даргаас итгэмжлэл олгогдсон аливаа этгээд.

-Amend.11-ээр нэмэгдсэн

Хязгаарлагдмал эрхтэй **шалгах-нисгэгч**

(в) Энэ зүйлийн (г)-г харгалзан үзсэнээр, ИНЕГ–ын дарга зөвшөөрсөн эрхүүдийг, Хязгаарлагдмал эрхтэй **шалгах**-нисгэгч нь ИНД-141-ийн дагуу үйл ажиллагаа

<p>шалгалт авахыг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын хүрээнд хэрэгжүүлж болно.</p> <p>Бүрэн эрхтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл</p> <p>(d) <u>Шалгагч</u>-нисгэгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд тухайн эзэмшигч нь ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй тохирох, хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх <u>үүрэгтэй</u>.</p> <p>(e) Энэ зүйлийн (d)-г үл харгалзан, хэрэв <u>шалгагч</u>-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь шаардлагатай багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй бол, хүчинтэй ЭМГ, эсхүл <u>хүчинтэй маягийн зэрэглэл</u> эзэмшихийг шаардахгүй.</p>	<p>явуулдаг, нислэгийн шалгалт авах эрхтэй нисэхийн сургалтын байгууллагад эдлэнэ.</p> <p>Бүх төрлийн шалгах-нисгэгч</p> <p>(г) <u>Шалгах</u>-нисгэгчийн эрхийг эдлэхийн тулд тухайн ашиглаж байгаа агаарын хөлгийн хувьд агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, тохирох багш нисгэгчийн зэрэглэлтэй байна.</p> <p>(д) Энэ зүйлийн (г)-г үл харгалзан, хэрэв шалгах-нисгэгч нисэх багийн гишүүний хувьд үүрэг гүйцэтгэхгүй бол эрүүл мэндийн <u>хүчин төгөлдөр</u> гэрчилгээ шаардахгүй</p>	<p>- “Бүх төрлийн шалгах-нисгэгч” гэснийг “Бүрэн эрхтэй шалгагч-нисгэгч” гэж</p>
<p>61.907 Хүчинтэй байх шаардлага</p> <p>(a) Тухайн <u>шалгагч</u>-нисгэгч нь өмнө <u>үргэлжилсэн</u> 24 сарын дотор тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх ур чадвараа <u>Даргад амжилттай</u> шалгуулснаас бусад тохиолдолд, шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн эрхээ <u>хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй</u>.</p> <p>(b) Агаарын тээврийн <u>шалгагч</u>-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн хувьд, энэ зүйлийн (a)-д шаардсан дараах ур чадварын <u>шалгалт</u> нь зөвшөөрөгдсөн нислэгийн дадлагажуурын үе шат, эсхүл нислэгийн үе шат, эсхүл хэрэв <u>Дарга</u> шаардсан бол <u>хоёуланг</u> нь багтаасан байх ёстой:</p> <p>(1) <u>шалгагч-нисгэгчийн</u> шалгалт авах хамгийн хүнд маягийн агаарын хөлөг дээр, эсхүл <u>Даргын</u> шаардаж болох бусад агаарын хөлөг дээр;</p> <p>(2) ИНД-121, <u>125</u> эсхүл ИНД-135-ын шаардлагын дагуу, авахыг зорьж байгаа эрхтэй аль хамааралтайгаар.</p> <p>(c) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор энэ зүйлийн (a)-д шаардсан шалгалтыг <u>амжилттай</u> өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь <u>өгсөнд</u> тооцно.</p>	<p>61.907. Ур чадварын хадгалалтад тавигдах шаардлага / Currency requirements</p> <p>(a) <u>Шалгах</u>-нисгэгч нь өмнөх 24 сарын хугацаанд зэрэглэлийн дагуу олгогдсон эрх эдлэх ур чадвараа <u>ИНЕГ</u>-ын даргад шалгуулаагүй бол уг зэрэглэлээр олгогдох <u>эрхийг эдлэхгүй</u>.</p> <p>(б) Агаарын тээвэрлэгчийн <u>шалгах</u>-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн хувьд, энэ зүйлийн (a)-д заасан ур чадвараа дараах <u>нөхцлийн</u> дагуу дадлагажуурын, эсхүл нислэгийн <u>үед</u>, эсхүл ИНЕГ-ын даргаас шаардлагатай гэж үзвэл <u>аль аль үед нь</u> шалгуулна:</p> <p>1/ хөөрөлтийн жингээрээ хамгийн хүнд маягийн агаарын хөлөг дээр, эсхүл <u>ИНЕГ</u>-ын даргаас шаардсан бусад агаарын хөлөг дээр шалгуулах;</p> <p>2/ олгогдох эрхүүдтэй хамааралтайгаар, ИНД-121, эсхүл ИНД-135-ын холбогдох шаардлагын дагуу.</p> <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд ур чадварын шалгалтаа <u>өгөх</u> өдрөөс 60 хоногийн өмнө ур чадвараа шалгуулсан бол цаг хугацаанд нь <u>шалгуулсанд</u> тооцно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>61.909. Мөрдөгдөж байгаа дүрмийн заалтыг хүчингүй болгох болон хадгалах</p> <p><u>(a) 2002 онд хүчинтэй болсон ИНД-61 болон түүний нэмэлт өөрчлөлт нь энэхүү шинэчлэлтээр хүчингүй болж,</u></p>		

солигдоно.

(b) Хэрэв дараах бичиг баримт нь шинэчилсэн ИНД-61-ийг 2019 оны 7 сарын 30-наас мөрдөж эхлэхээс өмнө гарсан бол хүчинтэй хэвээр байна:

- (1) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу олгосон бүх үнэмлэх, зэрэглэл болон бусад нисэхийн баримт бичиг;
- (2) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу нисэхийн баримт бичиг эзэмшигчийн хэрэгжүүлж байгаа бүх эрх, хязгаарлалт;
- (3) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу зөвшөөрөгдсөн бүх бичгийн шалгалтын, эсхүл нислэгийн шалгалтын дүн болон кредит;
- (4) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу зөвшөөрөгдсөн бүх нислэгийн шалгалтын дүн;
- (5) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу нисгэгчийн дэвтэрт бичсэн бүх нислэгийн цагийн бичилт;
- (6) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу бүх нислэгийн туршлага хадгалсан тухай болон нислэгийн дүгнэлт хийсэн тэмдэглэл;
- (7) 2019 оны 7 сарын 30-наас өмнө ИНД-61-ийн дагуу олгосон, эсхүл хүсэлт гаргасан бүх маягт.

Дүрмийн боловсруулалтын хэлтэс